

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 3 САР. №06, 07 (064, 065)

САЛХИ ХААШАА АЖИЛЧИД ТИЙШЭЭ

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

ТӨР ГЭДЭГ БИЗНЕС...

WWW.MONGOLIANECONOMY.MN


## ХӨГЖЛИЙН ЗУРАГЛАЛ

ГАРАА/2014

БАРИА/2040



ЭДИЙН ЗАСГИЙН СОРИЛТЫГ ХЭРХЭН ДАВАХЫГ  
ШИНЖИЖ АЗЫН ДӨРВӨН БЭРХ ОРХИЛОО



# APC ухаалаг тог баригч бүтээгдэхүүнүүдийг танилцуулж байна.

*Хамгийн найдвартай  
Хамгийн шилдэг шийдэл*



175 жилийн түүхтэй Schneider Electric компани манай байгууллагад хамгийн сайн хамгаалалтыг санал болгож байна.

## Сүлжээний хамгаалалтаараа дэлхийд тэргүүлэгч ухаалаг тог баригчууд

- 16 сегменттэй LEO дэлгэц нь цахилгаан хүчдэлийн төлөвийг хурдан хугацаанд мэдээллэнэ
- Ухаалаг баттерейн удирдлагын систем нь баттерейн үр ашигтай ажиллагаа, найдвартай байдлыг хангана
- Автомат хүчдэлийн тохируулга нь хэт нам болон өндөр цахилгаан хүчдэлийг аюулгүй түвшинд барина.
- PowerChute удирдлагын програм
- Зайнаас удирдах систем
- Зуун дамжсан туршлагад суурилсан дизайн

Чанар, шинэ технологи, найдвартай ажиллагаа нь цахилгаан хүчдэлээс шалтгаалах бүх эрсдлээс бүрэн хамгаална.

# Dell PowerEdge

## 12-р үеийн серверүүд

Орчин үед мэдээллийн технологийн салбар хурдацтай хөгжиж, хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг даган технологийн дэвшлүүд гарч байгаа хэдий ч бизнесийн хэрэглэгчийн хувьд хамгийн чухал асуудал нь бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагаа, өргөтгөхөд уян хатан боломж, үр ашгийг сайжруулсан, ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн байдал, хямд зардал байсаар байна.

Компьютерийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Dell компанийн PowerEdge 12 дугаар үеийн дэвшилтэт технологи бүхий сервер нь хэрэглэгчид үйл ажиллагааг сайжруулах илүү их боломж, арга хэрэгсэл өгөх хамгийн дэвшилтэт технологийг санал болгож байна.

Dell серверийн 12-р үеийн нэгтгэсэн удирдлагын систем нь системийг өргөжүүлэх, серверийн өөрчлөлт шинэчлэлт, хяналт хийх, удирдах боломжоороо дамжуулан бүх серверт хүрч ажиллаж чадна.

Байгууллагын үйл ажиллагааны үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх мэдээллийн технологийн дэд бүтцийн нарийн төвөгтэй байдлыг багасгахад зориулан бүтээгджээ.

### Виртуал хүчин чадал

Олон байгууллага өргөжин хөгжиж буй бизнесээ бэхжүүлэх болон үйл ажиллагааны бүтээмжээ зөв зохион байгуулах зорилгоор виртуализмийг ашигладаг. Тэд өмнөх нэг сервер, нэг програмнаасаа шилжиж дан хост сервер дээрх программуудын виртуал загварыг ашиглах хандлагатай байдаг.

### Виртуализмд зориулагдсан

Dell PowerEdge серверийн хосолсон удирдлага нь дээд зэргээр ихэсгэсэн санах ойн хүчин чадал болон олон найдвартай дотоод хадгалах багтаамж, шинэ өндөр түвшний уян хатан I/O бүхий виртуализмд зориулагдсан.

### Удирдахад илүү хялбар

Виртуализмын энэхүү нэмэлт боломжууд нь таны IT дэд бүтцийг хөнгөвчилж, цөөн сервер ашиглаж, зардал хэмнэх, цахилгаан зарцуулалт болон орон зайг хэмнэх боломжийг олгоно. Түүнчлэн, виртуал орчинг удирдах нь илүү хялбар болсон ба та хулганыхаа товчийг хэдхэн товшоод л Dell-ийн Виртуал Нэгдсэн Системийн шийдлээс боломжит нэгдсэн орчин хүртэл давуу талуудыг мэдрэх боломжтой.

### Аюулгүй байдлын дээд зэргийн хамгаалалт

Шинэ Dell PowerEdge серверийн нэгтгэсэн удирдлага нь таны бизнесийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, мэдээлэл технологийн үйлчилгээг тогтмол хянах зэрэг боломжоор хангасан. Нэг нэгнээ орлож ажиллах хоёр SD картыг ашиглан таны виртуал орчныг хамгийн өндөр түвшинд хамгийн найдвартай ажиллах, аливаа эрсдлээс сэргийлэх боломжийг нээж өгсөн.

### Илүү хүчин чадал

Шинэ Dell PowerEdge сервер виртуал орчинд олон програм дээр зэрэг ажиллах эрэлтэнд тулгуурлан бүтээгдсэн. Харин Dell ProSupport нь танд асуудлаа шийдэж, системээ шинэчилж мөн илүү хурдтай ажиллахад туслах болно.

Саммит Компьютер Технологи ХХК  
Холбоо барих утас: 7007-3535, 9911-0458  
И-мэйл: corporate@summit.mn




The power to do more



PREMIER  
PARTNER

Монголын нийт компаниудын  
65% нь Dell-ийн бүтээгдэхүүнүүдийг  
өөрсдийн бизнестээ ашиглаж байна.

55% of all companies  
use Dell products for their  
businesses in Mongolia



Tel: /+976/ 7007-3535

www.summit.mn

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:**

Д.Бэхбаяр / 9999-4248

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:**

И.Отгонжаргал / 8800-6228

**АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:**

Теренс Эдвардс

**ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:**

Лиззи Хүү

**ОРЧУУЛАГЧ:**

Р.Гантулга

**ВЭБ РЕДАКТОР:**

Б.Энхцэцэг

**СЭТГҮҮЛЧИД:**

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

**ДИЗАЙНЕР:**

Ш.Оюундарь

**ВЭБ МАСТЕР:**

Н.Гал

**МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:**

Д.Барянжав / 9409-2904

М.Хишигтогтох / 9409-2906

**“ECONOMY” ТВ СТУДИ**

**СЭТГҮҮЛЧ:**

Ц.Соёлмаа

**ЗУРАГЛААЧ:**

Ш.Гантуул

**КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:**

Т.Баярсайхан

**ХАЯГ:**

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

[www.ubprint.mn](http://www.ubprint.mn)

## Монголын сэтгүүлдгийн эвлэлийн “2013 оны Шилдэг сэтгүүл”



MONGOLIAN ECONOMY  
ОНЛАЙН СЭТГҮҮЛ  
[mongolianeconomy.imedia.mn](http://mongolianeconomy.imedia.mn)

## АГУУЛГА

### ЭДИЙН ЗАСАГ

- 8 Нүхэнд унах уу, нүүдэл хийх үү
- 9 Гэтэж буй эрсдэлүүд
- 12 Манай сэтгүүл “Dow Jones” фирмтэй хамтран ажиллана
- 13 “Монголдоо бүтээцгээе”
- 15 Салхи хаашаа ажилчид тийшээ
- 18 Б.Ган-Очир: Экспортыг дэмжих төслүүд гараандаа яваа
- 19 Монголын талаарх стратегийн шийдвэр
- 22 Татварын шинэчлэл
- 24 Цогц бодлого үгүйлэгдэж байна
- 26 Төр гэдэг бизнес...
- 28 Үндэсний хөгжлийн бодлого
- 30 Нийлүүлэлт, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

### БИЗНЕС

- 32 Ноён долларыг ногтолж чадах уу
- 36 Хуулиас давсан шаардлага тавихгүй
- 38 Хөрөнгийн зах зээлийн шинэ хандлага
- 40 Засаглалыг дээш татах үүрэгтэй ТУЗ хэдийн болтол доош чангаах вэ
- 42 О.Ганбат: Гаалийн хҮнд суртал багассан
- 45 Манлайлагч
- 46 Монгол шуудай
- 48 “Хүннү Коал”-ыг үндэслэгч
- 52 Ус ба хөгжил

## “ECONOMY” ТВ СТУДИ

“ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” нэвтрүүлэг

**Нэвтрүүлэх цаг:** 2014.03.25-ны 21:50 цаг

**Нэвтрүүлэх сувар:** NTV телевизээр хүлээн авч үзнэ үү

### “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Тийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал



[facebook.com/Mongolian.Economy](https://facebook.com/Mongolian.Economy)



[twitter.com/EconomyMongolia](https://twitter.com/EconomyMongolia)



[youtube.com/user/MongolianEconomy](https://youtube.com/user/MongolianEconomy)

#### Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд

## МОНГОЛД

### АШИГТ МАЛТМАЛ

Монголын төрийн өмчит “Мон-Атом” компани Дундговь аймгийн нийт 12 ураны ордод хайгуулж хийж, нөөц тогтоогоод байна. Одоогоор Гурванбулагийн ураны ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусчээ. Ордуудад хайгуул бүрэн хийж дууссаны дараа олборлолтыг хэзээнээс эхлүүлэхийг шийдвэрлэх юм байна. Тус компанийн одоогоор илрүүлээд буй ураны нөөцийн хэмжээ 63 мянган тонн. Гэхдээ хайгуул хийх орд нэмэгдсээр байгаа тул ураны олборлолт хийх нөөцийн хэмжээ эцэслэн батлагдаагүй байгаа аж.

### ХОТ

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн дагуу үерийн усны жалга, уулын өндөрлөг зэрэг хүн амьдрах хориотой бүсүүдэд хязгаарлалт тогтоожээ. Ийм аюултай бүсэд амьдарч байгаа иргэдийг хотын ойролцоох 52 байршилд нүүлгэн шилжүүлж магадгүй аж. Шинэ суурьшлын бүсэд Нийслэлээс газар зохион байгуулалт хийгээд, сургууль, цэцэрлэг буюу нийгмийн, цахилгаан дулааны буюу инженерийн дэд бүтцийг нь шийдээд өгөх аж. Үүнийхээ дараа иргэдэд

газрыг нь хуваарилж өгөөд өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.

### ҮЙЛДВЭРЖИЛТ

Ерөнхий сайд Н.Алтанхуяг өнгөрсөн онд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Уул уурхайн яам БНХАУ-ын “Синопек” корпорацитай “Нүүрс хийжүүлэх технологи нэвтрүүлж хамтран ажиллах” тухай санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ ажлыг цаашид хариуцаж ажиллах төслийн нэгжийг Уул уурхайн яамны дэргэд байгуулахаар болсон байна. 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардсан тус төслийн хүрээнд 16 тэрбум шоо метр бүтээгдэхүүн үйлдвэрлэх дөрвөн үйлдвэр, нүүрснээс хийн түлш үйлдвэрлэх хэд хэдэн цогцолбор байгуулах аж. 2015-2018 онд бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгахаар төлөвлөжээ.

### НИЙТИЙН ТЭЭВЭР

Ерөнхий сайдын дэргэдэх Мэдээллийн технологийн зөвлөл нийтийн тээврийн үйлчилгээг шинэчлэхээр ажиллаж байна. Ирэх аравдугаар сар гэхэд иргэд буудал дээр хэдэн минутын дараа ямар чиглэлийн автобус ирэх тухай мэдээллийг

авчихаад гэрээсээ гардаг. Мөн нийтийн тээвэрт картаар үйлчлүүлдэг болох зэрэг үйлчилгээг нэвтрүүлэх гэнэ. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудыг нийтийн тээвэрээр үнэ төлбөргүй зорчуулахад төсвөөс 53 тэрбум төгрөг жилд зарцуулдагас 15 сая төгрөг хаана, яаж зарцуулдаг зэргийг мөн тодорхой болгох ажээ.

### АВТОЗАМ

Аймгуудыг хатуу хучилттай замаар холбох ажлыг өнгөрсөн онд Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд байгаа. Энэ жилийн хувьд зам засварын ажил ирэх дөрөвдүгээр сараас эхлэх аж. Уг ажилд зориулж энэ онд 570 гаруй тэрбум төгрөг төсөвлөжээ. Зам, барилгын ажил эхлэх дөхөж байгаа ч өнөөдрийн байдлаар Завхан, Говь-Алтай аймгийн замын ажлыг Концессийн гэрээний шугамаар шийдвэрлэхээр болжээ.

### ЧИНГИС БОНД

Засгийн газар энэ жил үйлдвэржилтэд зориулж нэг их наяд төгрөг зарцуулахаар болсон. Үүнийг арилжааны банкуудаар дамжуулан экспортыг нэмэгдүүлэх,

импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжүүдэд таван жилийн хугацаатай, жилийн есөн хувийн хүүтэй олгох нь. Энэ зээлд 888 төслийг Эдийн засгийн хөгжлийн яам, Хөгжлийн банкттай хамтран шалгаруулсан байна. Эдгээр төслийн нийт өртөг нь 7.3 их наяд төгрөг ч, төсөл санаачлагчдын зүгээс 4.2 их наяд төгрөгийн зээл хүсээд байгаа аж. Үүнийг бондын хөрөнгөөр санхүүжүүлж дийлэхгүй учраас 888 төслийг дахин шигшихээр болсон байна.

### ТӨМӨР ЗАМ

Улаанбаатар төмөр замын удирдлагуудын мэдэгдсэнээр энэ онд Улаанбаатар төмөр замаар нийт 13 сая тонн ачаа тээвэрлэхээр болсон байна. Энэ нь өнгөрсөн оныхоос 2.7 сая тонноор илүү аж. Дээрх ачааны 3.5 сая тонн нь импорт байх бөгөөд ОХУ-аас 1.7 сая, Хятадаас 1.8 сая тонн ачаа тээвэрлэнэ. Харин экспортыг 6.9 сая тонноор тохирч, 6.1 сая нь өмнөд хөрш рүү, үлдсэн 830 мянга нь ОХУ руу ачих аж. Үлдсэн буюу 2.2 сая нь Монголоор дамжин өнгөрөх транзит тээвэр байх ажээ. Дээрх 13 сая тонн дээр дотоодын ачаа тээвэрээ нэмэх юм бол энэ жилд 22-23 сая тонн ачаа тээвэрлэх дүн гарчээ.

## ДЭЛХИЙ ДАХИНД

### АМЕРИК

Өнгөрсөн сард АНУ-ын үнийн өсөлт жилийн түвшингээр 1.1 хувьтай байв. Энэ оны нэгдүгээр сартай харьцуулахад 1.6 хувиар буурсан болохыг тус улсын Хөдөлмөрийн яамнаас мэдэгджээ. Сүүлийн үеийн мэдээ, баримтаас харахад инфляци нь Холбооны нөөцийн банкнаас гаргасан инфляцийн зорилтот түвшин болох хоёр хувиас нэлээд доогуур байна. Урьд нь байгаагүй хамгийн доод түвшинд хүрэх магадлалтай гэжээ.

### ЕВРОБУС

Евробүсийн инфляци энэ оны нэгдүгээр сард 0.8, өнгөрсөн сард 0.7 хувийн өсөлттэй байв. Энэ талаар “Евростат” статистикийн агентлагаас мэдээлсэн байна. Европын төвбанкнаас баримталж буй инфляцийн зорилтот түвшин мөн хоёр хувь. Инфляци хэт доогуур байх нь евробүсийн 18 орны эдийн засагт дефляци нүүрлэх аюултай. Гэхдээ евробүсийн орнууд эдийн засгийн хямралаас гарч байгаа гэдэгт тус банкныхан итгэлтэй байна.

### БНХАУ

Хятадын зүүн хэсэгт орших Фенгуа хотын Zhejiang Xin-

grun Real Estate үл хөдлөх хөрөнгийн компани эргэн төлөгдөөгүй 400 сая орчим ам.долларын асуудалд оржээ. Энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугих болсноос хойш тус улсын үл хөдлөх хөрөнгийн компаниудын хувьцаа унаж эхлэв. Тухайлбал, Шанхайд бүртгэлтэй Poly Real Estate Group-ын хувьцаа гурав, Шенженьд бүртгэлтэй China Vanke-ийнх хоёр хувиар тус тус буурчээ.

### ЯПОН

Японы гадаад худалдааны алдагдал өнгөрсөн сард 800 тэрбум иен болж буурсан байна. Тус улсын экспорт 9.8 хувиар өссөн бол импорт өмнөх сарынхаас буурч, өсөн хувийн өсөлттэй байв. Энэ нь сүүлийн өсөн сарын хугацаан дахь хамгийн доод хэмжээ аж. Өнгөрсөн нэгдүгээр сард импорт 25 хувиар нэмэгдсэнээр экспорт, импортын зөрүү хамгийн их болжээ. Ирэх дөрөвдүгээр сард борлуулалтын татвар нэмэгдэх учраас импортын бараа, бүтээгдэхүүн ихээр нөөцлөх болсон байна.

### ОХУ – УКРАЙН

ОХУ-д гурван сая орчим Украин хүн ажиллаж, амьдарч байна. Энэ талаар

ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Крым ОХУ-тай нэгдэж буй талаар энэ сарын 18-нд хэлсэн үгэндээ дурджээ. Тэрбээр ОХУ дахь украинчууд өнгөрсөн онд 20 тэрбум ам.долларын орлоготой

ажилласан нь Украины ДНБ-ий 12 хувьтай тэнцэнэ гэжээ. Энэ сарын 16-нд Крымд бүх нийтийг хамарсан санал асуулга явуулж, иргэдийн 97 хувь ОХУ-тай нэгдэхийг дэмжсэн билээ.



## ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

НҮХЭНД УНАХ УУ,  
НҮҮДЭЛ ХИЙХ ҮҮ

И.ОТГОНЖАРГАЛ

“Mongolian Economy”  
сэтгүүлийн Орлогч  
эрхлэгч

**Ж**ил бүрийн гуравдугаар сарын дундуур болдог Монголын эдийн засгийн чуулган энэ удаа эдийн засаг нэлээд эгзэгтэй, сорилттой тулгарсан цаг үед болж байна. Валютын ханш, инфляци, хөрөнгө оруулалтын орчин, Чингис болон Самурай бонд гээд чуулганд оролцогч нийгмийн салбар бүрийн төлөөлөлд хөндөх сэдэв, ярих асуудал мундахгүй их байна байх. Сүүлийн жилүүдэд өндөр өсөлтийг үзүүлсээр ирсэн Монголын эдийн засгийн байдал 2014 он гарсаар богино хугацаандаа таагүй дүр зурагтай байгаа учраас тэр.

Монголын эдийн засгийн чуулганыг зохион байгуулагчдын зүгээс оролцогчдын санаа бодлыг илүү ирээдүйг чиглэсэн хөгжлийн өргөн хүрээтэй асуудлуудад уяж, уралдуулахыг зорьжээ. Энэ тухай манай сэтгүүлд гарсан Монголын эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал Б.Лакшми болон Монголын эдийн засгийн чуулганыг Зохион байгуулах хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Ган-Очир нарын ярилцлагаас илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. 2014 оны Давосын дэлхийн эдийн засгийн чуулганаас Монгол Улсын цаашдын хөгжлийн стратегийн шийдвэр, хувилбарууд 2040 онд хэрхэх талаар судлан гаргаж, дэлхийн анхааралд хүргэсэн учраас бид тэрхүү судалгаа, зөвлөмжийг ч хүргэж байна. Чуулганд Давосын дэлхийн эдийн засгийн чуулганы төлөөлөгчид оролцож, дэвшүүлсэн стратеги хувилбаруудын талаар монголчуудад хүргэхээр байгаа нь энэ удаагийн чуулганы бас нэгэн онцлог юм. Мөн хүний нөөцийн асуудал, 2014 оны Монгол Улсын эрсдэл, компанийн засаглал, татвар, ухаалаг төр зэрэг чуулганд хэлэлцэгдэх сонирхолтой сэдвээр нийтлэл, сурвалжлага бэлтгэсэн тул энэ талын таны санал санаачилгыг баяжуулах тоо баримт сэтгүүлээс цөөнгүй олодоно гэдэгт итгэлтэй байна.

Засгийн газраас валютын хомсдолтой эдийн засгаа дэмжихийн тулд импортыг орлох,

экспортыг дэмжихээ зарлаж, хөтөлбөр баталж, төсөл шалгаруулсан. Монголын эдийн засгийн чуулган “Монголдоо бүтээцгээе” сэдвийн дор чуулж байна. Монголчууд бид дотооддоо юу хийж чадах вэ. Үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нь чанар, үнээрээ гадаад зах зээлд гарах хэмжээний байж чадах болов уу? Арай зөвхөн монголчуудадаа зориулж үйлдвэрлэхээд экспортолно гэж ярихгүй байлгүй дээ. Засгийн газар Экспортыг дэмжих хөтөлбөр гаргахаас өмнө хаана, ямар эрэлт хэрэгцээ байгааг судалж үзсэн болов уу? Самурай, Чингис бондын импортыг орлох үйлдвэрлэлийн чиглэлээр шалгаруулаад байгаа эхний ээлжийн 888 төсөл хэр чансаатай бол.

Энэ бүхнийг монголчууд өнөөдрийн чуулганаараа ярилцаж, сайн санал санаачилга гаргаж, зөв шийдлийг олох учиртай. Өндөр өсөлтөөрөө дэлхийд гайхуулж байсан Монголын эдийн засгийн үнэн нүүр царай харагдах хэмжээнд хүрч доошлоод байна. Байгаа чадамж нөөцөө хэр зөв тодорхойлж, ашиглахаас улс орны ойрын болон хэтийн төлөв хамаарах сорилттой тулгарлаа. Хөгжлийн чигээ баримжаалах ноён уул нь юу байх вэ. Дотоодын үйлдвэрлэл үү, экспортын бараа юу, эрдэм мэдлэгтэй монгол хүний хөгжил үү, ухаалаг төр үү. Өнөөдрийн байдлаар Монголд төдийгүй дэлхий нийт анхааран хүлээж байгаа эдийн засгийг хөдөлгөх хүч нь Оюутолгойн гацааг арилгах явдал юм. Оюутолгойгүйгээр Монголыг төсөөлөхгүй болж дэлхий. Монголчуудын амьдрал ч түүнгүйгээр хүнд байна.

Дотоод, гадаадын сайн туршлага, санал санаачилгыг нэгтгэн зангидаж төрийн бодлогод тусгаж авч явах нь нүхэнд унах уу, нүүдэл хийх үү гэдгийг шийдэх гарц юм.

“Mongolian Economy” сэтгүүлийн хувьд хүнд байдлыг богино хугацаанд гэтлэн давах, хөгжлийн зураглалаа зөв тодорхойлох боломж бидэнд бий эсэхийг шинжихээр азын дөрвөн бэрх орхилоо. ■

## ЭРСДЭЛ

## ГЭТЭЖ БУЙ ЭРСДЭЛҮҮД

## Б.ЭНХЦЭЦЭГ

Товчхондоо, Монгол Улсын хувьд өнгөрсөн жил хүндхэн жил байсан, байсаар ч байгаа. Үүнийг гэрчлэх хэдэн тоо дурдъя. Гадаадын шууд хөрөнгө оруулалт 54.1 хувиар буурч, төгрөгийн ханш өнгөрсөн жил нийтдээ 25 хувиар суларч, өнөөдөр 1750-1800 төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Өнгөрсөн онд манай улсын ДНБ 11.7 хувийн өсөлттэй байсан нь 2011 оны “галзуу хурд” болох 17.5 хувьтай харьцуулахад огцом бууралт. Нөгөө талаас нүүрсний экспорт 41 хувиар уруудаж, гадаад валютын нөөц 40 хувиар дундарчээ. Гадаад валютын нөөц хомсдож байхад өрийн дарамт хүндэрч, улсын өр ДНБ-ий 41 хувьтай тэнцэж байгаа бол нийт гадаад өр ДНБ-ий 146 хувьд хүрч, өрийн дарамтыг улам ч хүндрүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нүүрээ хувиргаж, Рио Тинто болон Монголын Засгийн газар хоёр асуудлаа шийдэж чадалгүй зууралдаж цаг алдсаар байтал шинээр хөрөнгө оруулагчид орж ирэх байтугай үлдсэн хэдэн гаднын хөрөнгө оруулагчид залхандаа Монголыг орхин одсоор.

Нэгэн цагт хөгжиж буй зах зээлүүд дундаа од болон гялалзаж явсан Монгол хөрөнгө оруулалтын тухай хуулиа өнгөрсөн онд шинэчилж, хөрөнгө оруулагчдын дунд алдсан итгэлээ сэргээж, “ойлгомжгүй орон” гэдэг хочноосоо салахыг хичээж буй. Гэвч хөгжлөө аваад ирээдүй рүү алхахын тулд ихийг хийж, эрсдэлийг тооцож, асуудлыг хазаарлах хэрэгтэйг мэргэжилтнүүд хэлж байна.

“Moody’s” үнэлгээний агентлагаас “В1” буюу тогтвортой хэмээн манай улсыг үнэлээд байгаа ч тэлж байгаа эдийн засаг нь өөрөө том эрсдэл хэмээн



харж байна.

Монгол Улсын дунд хугацааны төлөв өөдрөг харагдаж байгаа ч богино хугацаанд эмзэг, өртөмтгий байдал хадгалагдсаар байна. Эдийн засгийн тэлэх бодлогоо үргэлжлүүлэх нь инфляцийн болон төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Хөгжиж буй эдийн засагтай орнуудад элбэг тохиолддог төлбөрийн тэнцлийн дарамт Монгол Улсын хувьд голлох сорилт хэвээр байхаар байна гэж Азийн хөгжлийн банкны зүгээс үзэж буй. Түүнчлэн банкны зээл маш хурдацтай нэмэгдэж байгаа нь тухайн системийг эмзэг болгож байгаа аж.

Нөгөө талаас Дэлхийн банкнаас гаргасан сүүлийн тайланд Монголын ДНБ-ий өсөлтийг энэ онд хоёр оронтой тоон дээр дөнгөж дөрөөлөх төдий өсөлттэй байх болов уу гэж дурджээ. Хэдийгээр манай улсын эдийн засгийн өсөлт саарч байгаа ч бусад улсын хувьд энэ зөвхөн мөрөөдөж болох л өсөлтийн хувь хэмжээ.

“ДНБ-ий 146 хувьтай тэнцэх гадаад өртэй, байнгын гадаад худалдааны алдагдалтай, өсөн нэмэгдэж буй импортын хэрэгцээг хангаж чадахааргүй валютын нөөцтэй, эмзэг гадаадын хөрөнгө оруулалттай, хэзээ ч буух нь тодорхойгүй зээлийн хүүтэй,

зээлийн эрсдэлээ дааж чадахааргүй банк санхүүгийн орчинтой болсон зэрэг макро эрсдэлээс үүсэх сөрөг үр дагавараас богино хугацаанд бид гарч чадахгүй. Энэ нь 2014 онд үргэлжлэх нь тодорхой байна” хэмээн “Мандал Женерал” даатгал компанийн Эрсдэлийн ахлах менежер Ч.Анхбаяр хэлж байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв 2014 онд Монгол Улсад тулгамдаж буй онцлох таван бэрхшээлийг дурдлаа.

1. Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний эрэлт буурч байгаа, хөгжингүй орнууд зах зээлд бэлэн мөнгө хэвлэн нийлүүлэх үйл явц багассан зэргээс үүдэн 2014 онд төгрөгийн ханш сул байх төлөвтэй байна. Импортос хамааралтай дотоодын хэрэглээ нь төгрөгийн ханш унасан үед инфляцийг хөөрөгдөх нэгэн хүчин зүйл болж байна. Мөн банкны салбарын тогтвортой байдалд эрсдэл учирч болохоор байна
2. Төсвийн орлого бага, засгийн газрын өр их байгаа нь төсвийн бодлого зохицуулалтанд гол сорилт болохоор байна. Монгол Улсын хөгжлийн банкны зээл ▶

- ▶ болон “Чингис” бондын нийт 2,1 тэрбум ам.долларын эргэн төлөлт болон зээлийн хүү нь томоохон сорилт болохоор байна.
3. Эрдэс баялгийн салбарын гол экспортлогчдын дундах өрсөлдөөн ихэсч, нийлүүлэлт нэмэгдэж байгаагаас улбаалан бүтээгдэхүүний эрэлт цаашдаа сул байх төлөвтэй байна. Уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай манай улсын эдийн засагт эрдэс баялгийн эрэлт багасах нь эрсдэл, сорилтуудыг авчирч байна
  4. Байгаль орчны тулгамдсан асуудлууд нь бэрхшээл сорилтуудыг дагуулсаар буй. Тухайлбал Улаанбаатар болон Эрдэнэт зэрэг хот суурин газрууд дахь агаарын бохирдол, хөрсний доройтол болон үүнээс улбаалсан бэлчээрийн даац хэтэрч буй байдал зэрэг асуудлууд тулгарч байна.
  5. Ажилгүйдлийн түвшин буурч байгаа ч ажлын байрны чанар болон хөдөлмөр эрхлэлтийн бүтцийн хувьд хөдөлмөрлөх нөхцөл муудаж байна. Албан бус сектор, хувиараа болон гэр бүлийн хөдөлмөр эрхлэгчид, цалин авахгүй хөдөлмөр эрхлэгчдийн тоо их байгаа нь бэрхшээлүүдийг учруулж байна.

Эрсдэлийн менежер Анхбаярын хувьд хэрэв гадаад худалдааны алдагдал ДНБ-ий 20 хувиас буурахгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй, банкуудын чанаргүй зээл өссөөр байх нөхцөлд эдийн засгийн өсөлт 10 хувь байхаар байна. Харин валютын ханшийн өсөлт буурахгүй, бодлогын хүүгээ өсгөхгүй тохиолдолд инфляци 17.5 хувь, гадаад валютын албан нөөцийн бууралтыг зогсоож чадахгүй тохиолдолд валютын ханш 1920 байна гэж үзэж байгаагаар хэллээ.

Монгол улс эдийн засгийн мөчлөгийн таатай үед нөөц бүрдүүлэн, түүхий эдийн үнэ ханш олон улсын зах зээл дээр хэлбэлзэж, эдийн засагт эмзэг байдал үүсэхэд сэргүүлэн тавих зэвсэг болгон ашиглах тийм мөчлөг сөрсөн бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь туйлын шаардлага болоод байна. Мөнгөний бодлого нь макро эдийн

засаг болон санхүүгийн тогтвортой байдал, нам дор инфляцийг онолох нь чухал бөгөөд гадаад сөрөг нөлөөллөөс хамгаалахад ханшийн уян хатан дэглэмийг мөрдлөг болгох нь чухал байдаг хэмээн Азийн хөгжлийн банк Монгол Улсын өнөөгийн нөхцөлд зөвлөж байна.

Өнөөгийн байдлаар улсын өр ДНБ-ий 49.5 хувьд, нийт гадаад өр ДНБ-ий 146 хувьд хүрснээр валютын нөөц хомсдож буй. Үүнийг дагаад гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх боллоо. Валютын ханш 25 хувиар өссөнөөс шалтгаалан инфляцийн дарамт нэмэгдэж, мөнгөний тэлэх бодлогыг эрсдэлд оруулж байгааг “Мандал Женерал” компанийн эрсдэлийн шинжээчид хэлж байна. Монголын зээл хүсэх зардал төгрөгийн ханшийн уналтаас үүдэн өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал 35 хувиар өссөн байгаа “БидиСек” компани мэдээлж байсан. Нөгөө талаас Азийн хөгжлийн банкнаас одоогийн ханшийн уналт нь яваандаа эдийн засагт долларжих үзэгдлийг нэмэгдүүлж мэдэхээр байна хэмээн сануулаад байгаа юм.

Эрсдэлийн менежер Ч.Анхбаяр “2018 онд ирэх 1.25 тэрбум ам.долларын улсын өрийг дарамт багатайгаар гэтлэхийн тулд төсвийн тэнцлийг ашигтай болгох хэрэгтэй. Үүний тулд урсгал зардлыг одооноос танасан бодлого барих нь туйлын чухал” хэмээсэн юм.

Макро эдийн засгийн эрсдэл бизнесийн байгууллагад том эрсдэл учруулж болохыг ханшийн огцом өсөлтүүд бидэнд харуулж байна. Монголын ихэнх томоохон компаниуд долларын зээлтэй. Харин орлого нь монгол төгрөгөөр орж ирж буй. Тиймээс тэд ханшийн зөрүүний алдагдлаас үүдэн нэмэгдсэн өрөө давж гарах аргагүйдээ эхнээсээ банкуудад зээлийн хугацаагаа сунгах хүсэлт тавьж байгаа нь ойлгомжтойг мэргэжилтнүүд онцолж байна. Гэвч энэ тохиолдолд хуулиараа зөвхөн нэг л удаа зээлийн хугацааг сунгах боломжтой. Дараагийн удаа шууд чанаргүй зээлд шилжинэ.

“Бизнесийнхэнд илүү их бизнес хэрэгтэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэтэл нэлээд хугацаа орно. Нөхцөл байдал

тогтвортой эсэхт итгэл төрөх хүртэл гадаадын хөрөнгө оруулагчид хүлээж харна” хэмээн Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Жим Двайр хэллээ. Тэрбээр мөн “Засгийн газрын тогтворгүй байдал, янз бүрийн татвар татаасыг өсгөх, хуулийн олон дахин өөрчлөлт, аж ахуй нэгжийн зохисгүй зохицуулалтуудыг одоо хязгаарлах цаг нь болж. Хөрөнгө оруулагч болон Монгол улс хоёул ялах боломж бий” хэмээн хэлсэн юм.

Өнгөрсөн онд гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг засварлаж, араас нь алтны татварыг 2.5 хувь болгож ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Энэ нь Монголын алт монголдоо үлдэж, Монголбанк нөөцөө өсгөх боломж гэж харах хүн олон. “БиДиСек” компанийн захирал Ник Козайн “Хэрэв Монголбанк алтаа ашиглан нөөцөө нэмэгдүүлбэл, төгрөгийн ханш дунд болон урт хугацаанд өснө. Монголын эдийн засагт гайхалтай чадамж байна. Харин үр ашгийг нь үзэхийн тулд ойрын хугацаанд хүндхэн шийдвэрүүдийг гаргах шаардлага тулж ирлээ” хэмээн хэлсэн юм.

Тэрбээр мөн “Засгийн газар Оюутолгойтой гэрээний асуудлаа эцэслэж чадахгүй бол хамгийн том эрсдэл босч ирнэ. Энэ тохиолдолд Монголд итгэх итгэл ганхаж, Монгол төгрөгийн ханш үлэмж дарамтад орно” хэмээн сануулсан юм.

Энэ сарын эхэнд Төрийн ордонд болсон эдийн засагчдын хэлэлцүүлгийн үеэр хэдэн санал онцолсон. Эдийн засагт үүсээд буй нөхцөл байдлаас гарахын тулд томоохон төслүүдийн гацааг гаргаж, эргэлтэд оруулах, импортын хэрэглээг дэмжсэн зээлийн хэт өсөлтийн хурдыг сааруулах. Эдийн засгийн өсөлтийг бодит түвшинд нь хүртэл бууруулах, ам.долларын ханшийн гадагшлах урсгалыг багасгах. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэсэгчлэн зогсоох, экспортын орлогыг дэмжих, нүүрс, төмрийн хүдрийн өрсөлдөх чадварыг сайжруулах ёстой гэж тэд үзсэн. Мөн хөгжлийн бодлого, төлөвлөгөөгөө батлуулж, хөрөнгө оруулалтын урсгалаа тогтмол, улс төрөөс хараат бус байдлаар байнга нэмэгдүүлж байх ёстойг сануулсан юм. ■

“MONGOLAIN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

## XXI ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛ ЮУ ВЭ?



**Н.Жанцанноров**  
/Төрийн хошой  
шагналт, Ардын  
үжигчин, хөгжмийн  
зохиолч/

### Монголоо авч үлдэх

-Монголчууд тийм үнэт зүйлийг эрхэмлэнэ гээд таагаад хэлэх боломжгүй. Гэхдээ төсөөлөх хэрэгтэй. Төсөөлөхийн тулд өнөөдөр ямар болсон, өчигдөр ямар байсныг сайн судалж харах ёстой. Үнэт зүйл нь эдийн засгийн хөшүүрэггүйгээр дархлаажих, уламжлагдах асуудал хүнд. Заримдаа байгаа үнэт зүйлийг уламжилж болохоос гадна эдийн засгийн аргаар үнэт зүйлийг бас бий болгодог ч байж магадгүй. Монгол хүний хувьд таван хошуу мал үнэт зүйлийн хүрээнд ярьж болох асуудал. Өвөг дээдсээс энэхүү үнэт зүйл уламжилж ирэхдээ ямар мал нь сүргийн бүтцэд хэр хэмжээтэй байхыг мянга мянган жилээр тогтоож ирсэн. Адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа ийм тооны байна гээд. Сүүлийн жилүүдийн мал тооллогоор ямаа сүргийн бүтцэд бараг тал хувийг нь эзэлж байна. Уг нь монголчуудын сүргийн бүтэц дотор ямаа 10-15 хувийг эзэлж байсан байж магадгүй. Гэтэл ямааны ноолуур өсөөд ирэхээр тоо толгой нь эрс нэмэгдсэн. Эндээс үзэхэд аливаа үнэт зүйлийг өөрчлөх боломж



**Р.Амаржаргал**  
/Ерөнхий сайд асан,  
УИХ-ын гишүүн/

### Ёс зүй, хариуцлага, эх орон

-XXI зуунд улс үндэстний хэмжээнд ч, хувь хүний түвшинд ч өөрчлөлт шинэтгэл сар жилээр бус цаг хормоор хэмжигдэх хурдацтай, мөн өргөн цар хүрээтэй явагдаж байна. Техник технологийн хөгжил дэвшилд эрчлэгдэн эргэж буй өөрчлөлт, өрсөлдөөний шуурган дахь XXI зуунд Монгол Улс, монгол үндэстэн тэсэж үлдэхийн төлөө, тэргүүлж цойлохын тулд бид бүхэн монгол хүн бүрийн хүлээн зөвшөөрдөг, хүндлэн биширдэг, хүлцэн дагадаг тийм л үнэт зүйлийг бий болгох учиртай. Миний хувьд энэ зууны Монгол хүний эрхэмлэх үнэт зүйлийг эх орон гэж хэлэх байна.



**Ч.Хашчулуун**  
/Хувийн хэвшлийг дэмжих  
үндэсний зөвлөлийн  
гүйцэтгэх захирал/

### Мэдлэгтэй монгол хүн

- Монгол хүн бүрийн эрхэмлэх үнэт зүйл бол мэдлэг. Мэдлэгтэй байснаар мэдээллийн эрин зуунд амьдарч, аж төрж, өөрсдийн түүхээ бичнэ. Ингэснээр дэлхийн хөгжлөөс хоцорч, гаднын соёлд уусахгүй байх дархлаа суух юм. Шуудхан хэлэхэд, мэдлэгтэй байж бид зөв сонголт хийнэ. Тиймээс иргэдийнхээ боловсролд илүү анхаарах хэрэгтэй байна. Байгалийн баялгаас гадна түүнийг зөв удирдан зарцуулах мэдлэгтэй хүмүүн капитал чухал. XXI зуун мэдлэг, мэдээллийн зуун. Мэдээлэл их байна.

эдийн засагт байна. Өнөөгийн дэлхийн хөгжил энэ эрчээрээ урагшаа явна, илүү сайн сайхан болно гэж төсөөлж үзвэл монголчуудын үнэт зүйл юу байх талаар төсөөлөн ярьж болно. Тэр төсөөлөл даяаршиж байна. Даяаршихгүй нэг улс тусгаар үлдлээ гэж ярьж, түүнийгээ үйлдэл болгож болно. Тэглээ л бол хоцорлоо. Тиймээс өөрийн эрхгүй даяаршилд хөл нийлүүлнэ. Хүн жаргалтай сайхан амьдрахын тулд аль болох тэр жаргалыг бага цагт бүтээмж өндөртэй авах шаардлага гарна. Үүнээс гадна орчлон дээр ийм үзэл яваа. Тэнгэрээс бусад нь мөнх биш гэж. Хэрвээ энэ үзлээр яваад тэнгэрээс бусад мөнх бус бол даяаршил гэдэг зүйл мөнх бус болж таарна. Даяаршил дуусчихлаа. Тэгвэл хэн хожих вэ гэсэн асуулт гарч ирнэ. Тэр цагт өөрийгөө авч үлдсэн нь хожино. Даяаршилд өртлөө ч гэсэн Монголоороо үлдэх. Морио унаж чаддаг байх ёстой. Морьтой байх хэрэгтэй. Эмээл хазаартай үлдэх учиртай. Тэгж л чадвал бидний гарт ялалт байна. Энэ үнэт зүйлийн хураангуй бол Монголоо авч үлдэх. Уртын дуу, морин хуур, морь уургалах, гүү саах, бие биелгээ бол үнэт зүйл.

Эх орон гэдгийг бид ерөнхийд нь газар шороо, уул ус, унаган байгаль, уламжлал, зан заншил, өвөг дээдэс, үүх түүх гэсэн ойлголтуудаар төлөөлүүлж ирсэн. Мэдээж эдгээр ойлголтууд зөв хэдий ч, бид “эх орон” гэдгийг үргэлж өөрөөсөө гадна тусдаа оршин байдаг, өөрсдөөсөө ангид салангид байдаг хэмээн ойлгож иржээ. Эх орон биднээс эхэлж, биднээр дамжин оршдог. Мөн XXI зуун бол шинжлэх ухааны, мэдлэг оюуны, тэр дундаа технологийн зуун байх нь хэдийнэ тодорхой болжээ. Тиймээс энэ зууны монгол хүний эрхэмлэх үнэт зүйлс бол ёс зүй, хариуцлага, эрдэм мэдлэг, эх орон юм.

Түүнийг мэдлэг болгон хөрвүүлж, авч үйл хэрэг болгох нь чухал. Одоогийн авч хэрэгжүүлж буй дээд боловсролын шинэчлэлийн үр дүн мэдлэгтэй монгол хүн төрөн гарна гэдэгт эргэлзэж байгаа. Зөвхөн сургууль нэгтгэж, удирдлагын төвийг нэг болголоо гээд эндээс шинэчлэл гарахгүй. Боловсролын салбар дахь стандарт бүдгэрч байна. Монгол хүн эх хэлээрээ бичиж чадахгүй, түүхээ мэдэхгүй байх нь эмгэнэл. Тиймээс мэдлэгтэй байснаар бүс нутгийн түүхээ хөгжилтэй орнуудыг гүйцнэ үү гэхээс тэднийг даган дуурайж байж хөгжлөөрөө ойртож, зэрэгцэнэ гэвэл улам хэцүү болно. ■

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

# МАНАЙ СЭТГҮҮЛ “DOW JONES” ФИРМТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



## DOW JONES

**M**ongolian Economy” сэтгүүл АНУ-ын 130 гаруй жилийн түүхтэй хэвлэл болон санхүүгийн мэдээллийн “Dow Jones & Company” фирмтэй хамтран ажиллах гэрээ байгууллаа. Дэлхийд нэртэй тус байгууллагаас хамтран ажиллах санал тавьсан нь бидний хувьд Монголын тухай мэдээ мэдээллийг дэлхий дахинд үнэн бодитоор, шуурхай хүргэх боломж, мөн эх орноо сурталчлах мэдээллийн шилдэг суваг гэж харж байгаа юм. Тиймээс дээрх группын чухал бүрэлдэхүүн “Dow Jones Factiva”-тай шууд тулж харьцахаар тохирч, гэрээг хоёр талаас үзэглээд байна. Хоёр талын хамтын ажиллагаа хүчин төгөлдөр болсноор манай зүгээс “Mongolian Economy” сэтгүүлийн англи талд тавигдаж буй мэдээ, мэдээлэл, нийтлэлүүд болон [mongolianeconomy.mn](http://mongolianeconomy.mn) цахим хуудас дахь англи хэл дээрх мэдээллүүдээ “Dow Jones Factiva”-д өдөр тутам байнга нийлүүлэх юм.

“Dow Jones”-ийн зүгээс манай сэтгүүлтэй хамтрах болсон шалтгаан нь нэг талаас Монголыг чухалчлах олон улсын сонирхол нэмэгдэж буйг, нөгөө талаас Монголын тухай мэдээллийг цаг тухайд нь, найдвартай эх сурвалж, мэргэжлийн баг хамт олны гараас авах хэрэгцээ шаардлага байгааг харууллаа. Манай байгууллагын шинэхэн түншийн хувьд Монголын хэвлэл мэдээллийг багагүй судалсан бөгөөд англи, монгол хэлээр хэвлэгддэг, улс төрөөс хараат бус, мэргэжлийн баг, англи хэлтэй уншигчдын итгэлтэй түнш зэрэг шалгуураар “Mongolian Economy” сэтгүүлийг сонгосноо онцлон тэмдэглэсэн билээ.

“Dow Jones” фирм бизнес санхүүгийн ертөнцийн үйлчлүүлэгчдэд санхүүгийн мэдээ, мэдээлэл болон үйлчилгээ, тэднийг багтаасан технологийн орчин үеийн шийдлийг санал болгодог

онцлогтой. Тус корпорацийн мэдэлд дэлхийн хэвлэл мэдээллийн акул “The Wall Street Journal” сонин багтдаг. Мөн санхүү, хөрөнгийн зах зээлийн салбарынхныг өглөө бүр сэрээдэг Dow Jones индексийг бид сайн мэднэ. “Dow Jones Factiva” нь дэлхийн 200 орны 36 мянга гаруй найдвартай эх сурвалжаас 28 хэл дээр мэдээ мэдээлэл авах боломжийг уншигчиддаа олгодог мэдээллийн цогц шийдэл бүхий ухаалаг том талбар юм.

Манай сэтгүүл, сайтын бэлтгэсэн мэдээ, мэдээлэл тун удахгүй эх орны нутаг дэвсгэрээс хальж, олон улсын уншигчдад дэлхийн хэвлэлийн хамгийн шилдэг сувгаар дамжин өдөр бүр хүрдэг болно гэдгийг уншигч, захиалагчдадаа дуулгахад нэн таатай байна. Хамтын ажиллагаагаа цаашид улам гүнзгийрүүлж, илүү өгөөжтэй болгох тухайд манай хоёр байгууллагын зүгээс ярилцсан, хийхээр төлөвлөсөн ажлууд бий.

Ийн манай сэтгүүлийн гадаад харилцаа эрчимтэй хөгжиж буй юм. Өнгөрсөн зун сэтгүүлийн тусгай баг Лондон хотыг зорьж, “The Economist”, “The Financial Times” сонины редакцид зочилж, дэлхийн шилдэг хэвлэлүүдийн үйл ажиллагаа, туршлагатай танилцаж, үнэтэй зөвлөгөө авснаа бид мэдээлж байсан. Мөн АНУ-ын хамгийн том өдөр тутмын сонин болох “The USA today”-ийн тусгай дугаар бэлтгэдэг сэтгүүлчид Монголд ирэх үеэрээ манай сэтгүүлийн редакцид зочилж, үйл ажиллагаатай танилцсан. Түүнчлэн бид Лондон, Хонконг, Токиод болдог Монголын хөрөнгө оруулалтын чуулганы мэдээллийн түншээр жил бүр ажиллаж байна. Ийнхүү бид эх орноо гадаад ертөнцөд сурталчлах, эдийн засаг, бизнесийн үнэн бодитой мэдээллийг ертөнцөд түгээж, гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголдоо татахын төлөө хичээн ажиллаж байна. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2014

# “МОНГОЛДОО БҮТЭЭЦГЭЭЕ”

Б.АЛТАЙ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гүйцэтгэх захирал Б.Лакшмитэй ярилцлаа.



**-Монголын эдийн засгийн ээлжит чуулган “Монголдоо бүтээцгээе” уриан дор болох гэж байна. Энэ жил чухам яагаад дээрх уриаг сонгосон юм бэ?**

“Монголдоо бүтээцгээе” урианы талаар хэд хэдэн зүйлийг онцолж хэлье. Бидний хувьд өөрсдийн хэрэглэж буй бүхнийг дотооддоо үйлдвэрлэх боломжгүй. Гэхдээ боломжгүй гээд одоогийнх шиг хийж чадах зүйлээ импортоор аваад байна гэсэн үг биш. Харин экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд түлхүү анхаарах зайлшгүй шаардлага байгаа. Энэ нь дунд болон урт хугацаанд эдийн засгийн өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлж, эдийн засгийн хөгжлөө тэтгэдэг. Ингэснээр эдийн засаг өөрийн гэсэн дархлаатай болж, бие даана. Үүнийг нь бодож дээрх уриаг дэвшүүлсэн. Гэхдээ уриаг энэ байдлаар нь шууд хүлээж авахаас илүү баялаг бүтээх, бүтээмжтэй ажиллаж, амьдрах, эх орондоо ихийг хийж бүтээх талаас ухаж ойлгох хэрэгтэй.

**-Өнгөрсөн оны чуулган “Монгол**

**брэнд”-ийг онцолж байсан. Тэгвэл өнөө жил илүү өргөн цар хүрээг хамарсан ерөнхий уриаг дэвшүүлж байна гэж ойлголоо. Бидний хувьд тулгамдаж буй ямар асуудал байна вэ?**

-Уул уурхайгаас гадна бусад салбараа хөгжүүлэх замаар эдийн засгаа төрөлжүүлэх шаардлага байгаа. Тиймээс заавал бүхнийг гэхгүйгээр боломжтойг нь үйлдвэрлэх хэрэгтэй. Гэхдээ бүгдээрээ нэг төрлийн бараа бүтээгдэхүүн хийвэл үр дүн гарахгүй. Иймд зах зээлээ нарийн сайн судалж, хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг анхаарч, зах зээлдээ нийцүүлж бүтээх чухал. Ямар ч стандарт, шалгуур үзүүлэлт байхгүйгээр бүтээгдэхүүн нийлүүлээд байвал тухайн бараа зах зээлд удаан оршин тогтнож чадахгүй. Цаашдаа бүтээгдэхүүний стандартыг сайжруулж, өртгийг бууруулах замаар дотоодын бараа бүтээгдэхүүн импортын бараа бүтээгдэхүүнээс хямд байснаар хэрэглэгчдийг татах боломжтой. Мөн стандартын асуудлыг энэ удаагийн чуулганаар хөндөхөөр

байгаа. Манай улс цаашдаа яг аль стандартыг авч мөрдөх юм, түүнийг хэрхэн нутагшуулах талаар тодорхой шийдэлд хүрнэ гэж найдаж байгаа.

**-Хүний хөгжлийн асуудлыг энэ удаагийн чуулган түлхүү хөндөж, хэлэлцүүлэг өрнүүлэх бололтой. Жил бүрийн эдийн засгийн чуулганаар оролцогчдын зүгээс хөнддөг асуудал. Энэ удаа ямар өнцгөөс асуудлыг ярих вэ?**

-Аливаа улсын хөгжлийн үндэс нь хүн. Тиймээс хүний хөгжлийн асуудал дэлхийн аль ч оронд хамгийн чухлаар тавигдаж байгаа. Гэтэл манайд энэ асуудал сүүлийн жилүүдэд бүдгэрч, орхигдох шинжтэй байна. Иймд хүний хөгжлийн асуудлыг онцолж байгаа. Хүний хөгжил бүх зүйлд нөлөөлдөг. Үүнээс болж зарим асуудал гацах нь бий. Манайх хүнээ хөгжүүлэх, хүний нөөцөө бэлтгэх асуудалд нэлээн хойрго хандаж ирсэн. Өнөө маргаашаа өнгөц харахаас илүү урт хугацааны хөгжлийн зураглалаа тодорхойлж, үүндээ хүний хөгжлөө чиглүүлэх хэрэгтэй. Уул уурхайн салбар хөгжиж байна гээд бүхий л ажиллах хүч нь тийшээ “урваж” болохгүй. Гэтэл энэ салбар эрсдэлтэй болохыг эхнээсээ манайхан мэдэрч эхэллээ. Түүхий эдийн үнийн уналт гэнэт нэг өглөө ажилгүйдэл үүсгэх, өөр салбарт шилжих зэрэг тогтворгүй байдлыг нийгэмд бий болоход хүргэж байна.

**-Мөн чуулганы хэлэлцэх сэдэвт санхүүгийн зах зээлийн талаар туссан байна лээ. Энд ямар өөрчлөлт байх вэ?**

-Санхүүгийн зах зээл өрсөлдөөнтэй, бусад салбар нь жигд хөгжиж байснаар үйлдвэрлэгчдэд илүү таатай боломж гарна. Энэ жилийн ▶

► форумар санхүүгийн зах зээлийн одоогийн хөгжлийн тогтолцоог авч үзэж байгаа. Тэр тусмаа даатгалын салбарыг онцолж байгаа. Дээрээс нь Монгол Улсын давуу болон сул талыг тодорхойлно. Ноос, ноолуурын салбараа брэнд болгохоор зорьж буй орны хувьд тухайн салбараа он удаан жилээр түлхүү хөгжүүлэх хэрэгтэйг бусад орны жишээ харуулдаг. Өөрөөр хэлбэл, дэмжсэн салбартаа хэр үнэнч байхаас ирээдүйд гарах үр ашиг нь хамаарч байна. Наанадаж дотооддоо нэмэгдсэн өртгийн сүлжээг бий болгох шаардлага байгаа. Тухайн брэндийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэгч нь Монголд байснаар брэнд биелэлээ олно. Түүнээс кластер 2-3 жилийн дотор бий болно гэж байхгүй. Тогтвортой дэмжлэг, тодорхой чиглэл байхгүйгээс болж зарим санаачилга хэрэгжих явцдаа бүдгэрч байгаа нь үнэн. Уул уурхайн салбар хөгжих нь тодорхой. Харин эдийн засгийн төрөлжүүлэх үүднээс бусад салбараа гаргаж ирэх нь зүйтэй. Тухайлбал, Франц улс 1800-гаад оны үед загварын орон болно гэж зориод өнөөдөр тэр зорилгодоо хүрсэн. Түүнээс хойш 200 гаруй жил өнгөрсөн ч загварын орон хэвээр байна. Энэ нь өөрсдийн харьцангуй давуу талаа олж хараад, түүнийгээ маш сайн хөгжүүлж чадсанд нууц нь оршиж байгаа юм.

#### **-Өнгөрсөн оны эдийн засгийн чуулганы үр дүн гарсан уу?**

-Эдийн засгийн чуулганы хувьд бодлого шийдвэрт шууд нөлөөлөхөөс илүү боломжийг эрэлхийлдэг. Нийгмийн сэтгэхүйд шинэ зүйлийг нэвтрүүлэх, хайрцагласан санаанд гарц нээж өгөх. Түүнчлэн улс орныхоо хөгжлийн талаар хоорондоо нээлттэй ярилцах талбар юм. Нэг талаасаа чуулганы үр дүнг ийм байна гээд хэлэх нь харьцангуй. Яагаад гэвэл нэг жилийн дотор брэнд төрөх, түүнийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх гэхээр цаг хугацааны хувьд боломжгүй. Харин брэнд хийх хүсэл тэмүүлэл,

итгэл үнэмшлийг хүмүүст өгч, үйлдвэрлэгчдийг сэдэлжүүлж байгаа нь магадгүй чуулганы үр дүн байж болох юм. Тэр тусмаа брэндийн хувьд цаг хугацаа, хөрөнгө, урт хугацааны хөдөлмөр, хичээл зүтгэл шингэх нь зүй ёсных.

**-Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн ухаалаг төрийн бодлого эдийн засгийн чуулганы салбар хуралдаан болж орж ирсэн. Гэхдээ хот, шүүх засаглал гээд дотроо задалсан байна лээ. Энд ямар асуудал ярилцах вэ?**

-Ухаалаг төрийн бодлого нь тусдаа их том ойлголт. Засаглалын бие даасан асуудал болж хувирч байгаа

“Аливаа улсын хөгжлийн үндэс нь хүн. Тиймээс хүний хөгжлийн асуудал дэлхийн аль ч оронд хамгийн чухлаар тавигдаж байгаа. Гэтэл манайд энэ асуудал сүүлийн жилүүдэд бүдгэрч, орхигдох шинжтэй байна. Иймд хүний хөгжлийн асуудлыг онцолж байгаа.”

юм. Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн ухаалаг төрийн бодлогод төрийн гадаад бодлогыг эдийн засагжуулах, төрийн яам, агентлагийн уялдаа холбоог сайжруулах. Мөн шүүх эрх мэдлийн шинэчлэл гээд эдийн засагтай холбоотой асуудлыг авч энэ жилийн чуулга уулзалтад оруулсан. Тухайлбал, Шүүхийн шинэчлэл ба бизнес гэсэн сэдэв бий. Шүүгчдийн хувьд бизнесийн талаар ойлголт маруухан. Гэтэл бизнесийн талаар мэдлэг нимгэн атлаа бизнестэй холбоотой асуудлыг шийдэх гээд байдаг. Манайд бизнесийн чиглэлээр мэргэшсэн шүүгч байхгүй. Энэ нь хүний эрхийг зөрчих, бизнесийн үйл ажиллагаанд хүртэл сөргөөр нөлөөлдөг.

#### **-Энэ жил ямар үр дүнг хүлээж байна вэ?**

-Улс орны хувьд судалгаа маш чухал. Гэтэл манайд эрсдэл болоод хөгжлийн замаа тооцоолсон сайн судалгаа алга. Жилийн дараах байдлаа хэрхэн харж байгаа нь таамаг төдий. Өөрөөр хэлбэл, эрсдэлээ ухаарахгүй байна. Үүнээс болоод улс гэлтгүй хувийн компаниуд хүртэл өнөөдөр хүнд байдалд орж, үйл ажиллагаа нь хэвийн горимоо алдаж байна. Тиймээс эдийн засгийн таван эрсдэлийг чуулганаар тодорхойлж, түүнээс гарах арга замын талаар хоорондоо ярилцах юм. Манай улсын хувьд хэрэглээний эдийн засагтай, ямар ч хуримтлалгүй болохоор ялимгүй хүндрэл үүсэхэд нөхцөл байдал эвгүйтэж байна. Чуулганы үр дүнг одоо хэлэхэд эрт байна. Гэхдээ эдийн засгийн чуулган болсноор шууд үр дүнг хүлээхээс дунд болон урт хугацааны бодлогын өөрчлөлт гарч байгааг анзаарч ажиглах хэрэгтэй. Бидний нүдэнд харагдах, үл харагдах багагүй ахиц дэвшил гарсан. Тухайлбал, бизнес эрхлэх орчин урьдынхаас сайжирсан гэж харж байгаа. Өмнө нь байсан хүнд суртал, олон гарын үсэг, бичиг цаасны тоо цөөрсөн. Гэхдээ аливаа зүйл хоёр талтай байдаг болохоор хараахан үр дүнд хүрээгүй ажил ч байгаа байх. Гол нь чуулганы үр дүн хүмүүсийн оролцоо, идэвх хэр байхаас ихээхэн хамаардаг. Форум болсноор шинэ зүйлийг эндээс олж харах, шийдэлд хүрэх. Нөхцөл байдлаа арай өөрөөр үнэлж, мухардлаас гарах нь чухал. Эдийн засгийн чуулганд хүмүүсийн оролцоо их чухал. Үүнийг дахин хэлье. Хүмүүсийн оролцоо, идэвх сайн байснаар эргээд эдийн засгийн хөгжилд хөшүүрэг болдог. Тэдний санал санаачилга улс орны бодлогыг тодорхойлоход үнэтэй зөвлөмж болох нь бий. Чуулганы хувьд тухайн иргэн, хувийн хэвшлийнхэн улс орны хөгжилд өөрийн дуу хоолойгоо хүргэх, санаа бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлж өгч байдгаараа давуу талтай. ■



## ХҮНИЙ НӨӨЦ

# САЛХИ ХААШАА АЖИЛЧИД ТИЙШЭЭ

## Э.ЗОРИГТ

... Энэ захад чанар хайж байна, мэдлэг боловсролыг өндрөөр үнэлнэ гэсэн зар “хүн арилжаалдаг” захаар дүүрэн. Ихэнхдээ өөрөө өөрийгөө арилжаалдаг энэ зах бол хөдөлмөрийн зах зээл юм.

Өдгөө Монголын хөдөлмөрийн зах зээл тэлсээр байна. Тухайлбал, жилд дунджаар 37 мянган оюутан дээд боловсрол эзэмшин хөдөлмөрийн зах зээлд гардаг. Дээр нь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийг төгссөн 20 гаруй мянган залуус нэмэгдэнэ. Нөгөө талдаа манай улсад жилд дунджаар 40 мянган ажлын байрны эрэлт бий болдог аж. Эрэлт нийлүүлэлтийн талын тоо баримтыг харахад энэ зах хамгийн ашигтай баймаар. Гэтэл тийм биш. Үндэсний статистикийн хорооноос гаргасан хамгийн сүүлийн үеийн тоо баримтаас харахад ажилгүйдэл 7.8 хувьтай байгаа. Дээрээс нь Монголын гурван хүн тутмын нэг нь ядуу буюу эрхэлсэн

ажилгүй өдөр хоногийг элээж байна. Сонин биш гэж үү. Гэтэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр дүүрэн ажлын зар. Нөгөө талд ажил хайсан залуус хаа сайгүй.

## Ажилгүй юу эсвэл чадваргүй юу

Салхи хаашаа Монголын хөдөлмөрийн зах зээл тийшээ. Нэг хэсэг уул уурхайгаар өвчилж, хүн бүр тэр зүг хуйларсан. Тухайн үед ШУТИС-ийн Шинжлэх ухаан, технологи, инновацийн газрын дарга Д.Энхбат “Элсэлтийн шалгалт өгөөд хамгийн өндөр оноо авсан оюутнууд эргэлзэх зүйлгүй уул уурхайн ямар нэгэн ангийг сонгож байна. Элсэлтийн шалгалтад 770 оноо авсан оюутан уул уурхайн ангид орж чадахгүй уйлаад үлдэж байна шүү дээ” гэж байлаа. Мөн мөрөөрөө ажлаа хийгээд явж байсан боловсон хүчин уурхай зорих нь ихэсч боловсон хүчний дайжилт Монголын хөдөлмөрийн зах зээлийг

хөмрөнгөө алдсан. Бичгийн хүн бульдозер барих гээд ажлаа хаясан тохиолдол ч байсан. Бизнесмэнүүд бухимдаад сүйд болж байлаа. Ямар сайндаа өнгөрсөн оны “CEO summit” захирлуудын чуулга уулзалтын үеэр ажил олгогчид боловсон хүчин хүссэн үедээ ажлаа хаяад явдаг тогтолцоог өөрчилж өгөхийг төрөөс шаардаж байсан удаатай. Гэтэл хүссэн юм хүзүүгээр татна гэдэг шиг Монголын Засгийн газар уул уурхайд нэг хэсэгтээ л хатуурхаж, нүүрс шүтсэн эдийн засаг унаж эхлэхэд уурхай зүглэсэн ажилчдын ихэнх нь уруу царайлаад гэртээ ирсэн нь цөөнгүй. Гэвч өнгөрсөн жил эдийн засгийн өсөлтийг аварсан барилгын салбар өдгөө хүн бүрийн ажиллахыг хүсдэг салбар болсон гэдгийг салбарынхан хэлж байна. “Эко Констракшн” ХХК-ийн Хүний нөөцийн менежер А.Ууганбаатар “Сүүлийн үед барилгын салбар өсөлттэй байгаа болохоор манайд ажилд орох хүсэлтэй залуусын тоо нэмэгдсээр байна. Ер »

► нь барилгын салбар өндөр цалинтай, бүтээмж өндөртэй” гэв. Салхи хаашаа сэвэлзэнэ хүн бүр тийшээ хошуурдаг энэ тогтолцоог мэргэжлийнхэн буруу шаадаг. Ийм буруу тогтолцоотой холбоотой нэг хэсэгт нь ажиллах хүчний хомсдол нүүрлэж байхад нөгөө хэсэгт нь илүүдэл үүсч ажилгүй юу, эсвэл чадваргүй юу гэдэг асуулт хариулт нэхэж байна. Нөгөө талдаа ардчилсан нийгэмд хувь хүний хийж байгаа сонголтыг буруутгаж болохгүй. Хөдөлмөрийн судалгааны институтийн захирал М.Чимэддорж “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хүн хүссэн мэргэжлээ чөлөөтэй сонгож чаддаггүй байлаа. Ажлын байраа ч өөрөө сонгох боломжгүй. Харин өдгөө байдал өөрчлөгдөөд хүмүүс өөрсдийн сонголтоо хийдэг болсон. Гэтэл Монгол шиг хүн ам цөөтэй оронд нэг салбарт ажиллах хүчний ихэнх нь төвлөрөх нь буруу. Энэ нь зарим талаараа үндэсний ажиллах хүчний ашиглалтын түвшинг бууруулж байна гэсэн үг. Тиймээс зохицуулах зайлшгүй шаардлагатай” гэсэн юм. Тэгвэл яаж зохицуулах вэ. Өнгөрсөн зуунд морьтойгоо харайгаад гарчихсан засаглалын үе шиг “Чи тийм ажил хий” гээд тулгах нь энэ нийгэмд зохимжгүй. Харин тухайн хүний сонголтод зөв мэдээлэл өгөх замаар нөлөөлөх

хэрэгтэйг тус салбарынхан хэлж байна. Өч төчнөөн мянган ажлын байр бий болоод байгаа боловч түүнд тэнцэх боловсон хүчин үгүйлэгдсээр. Үүний учир нь хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа мэргэжлийн талаарх нарийн судалгаа Монголд байхгүйтэй шууд холбоотойг тус салбарынхан амаа чилтэл хэлдэг. Гэвч ажил хэрэг болсон нь үгүй. Гэхдээ шинэ засаг эмхлэгдэж, Хөдөлмөрийн яам бий болсноос хойш хэд хэдэн ажлыг эхлүүлсэн байна. Тухайлбал, “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах” төслийг тус яамнаас амжилттай хэрэгжүүлжээ. Уг төсөл хэрэгжсэнээр хөдөлмөрийн зах зээлийн цахим мэдээллийн нэгдсэн системийг бий болгох. Мөн ажил хайгч, боловсрол олгогч, ажлын байр бий болгогч гурав мэдээллээ чөлөөтэй солилцох боломжийг бүрдүүлсэн аж. Тус төсөл цахим мэдээллийн санг бүрдүүлэх, холбогдох байгууллага хооронд мэдээлэл солилцох зэрэг үйл ажиллагааг эхлүүлээд байгаа аж. Мөн хөдөлмөрийн зах зээлийн үнэн бодит мэдээллийг иргэдэд хүргэх ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн таамаглалыг тус яамнаас гаргасан байна.

## Уучлаарай, уул уурхай

Уул уурхайн салбар манай улсын экспортын 90 гаруй хувийг бүрдүүлж байна. Гэхдээ Монголын нийт хөдөлмөр эрхлэгчдийн дөрөвхөн хувь нь тус салбарт ажилладаг. Арван жилийн дараа уул уурхайн салбар өнөөдрийнхөөс ч илүү өсөлттэй байна гэж таамаглаж буй. Гэтэл тэр үед ажиллах хүчний долоохон хувь л энэ салбарт ажиллахаар байгаа аж. Учир нь тэнд хүн биш, хүнд машин механизм ихэнх ажлыг хийчихдэг. Нэг тоо дурдахад л уул уурхайн салбарт ажиллаж байгаа нийт ажилчдын 30 хүрэхгүй хувь нь уул уурхайн мэргэжилтэй хүн байдаг аж. Тэгэхээр уул уурхайн салбар өснө гээд л тус салбар руу оюутан залуус хошуурах нь буруу гэдгийг Хөдөлмөрийн яамнаас гаргасан “Дунд ба урт хугацааны хөдөлмөрийн эрэлт-нийлүүлэлтийн таамаглал” судалгаанд дурджээ. / Дэлгэрэнгүйг графикаас харна уу/

Өөр нэг сонирхолтой баримт дурдахад Монголын эдийн засгийн тулах баганын нэг болсон хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний тоо ирэх жилүүдэд буурахаар байгаа аж. Хэдийгээр тус салбар 2022 он хүртэл өсөх хандлагатай байгаа ч нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөлмөр зарцуулалт техник, технологийн хүчээр буурч бүтээмж нэмэгдэхээр байна. Тиймээс ►

### Хөдөлмөр эрхлэлтийн таамаг (салбараар)

хүн. 2012-2022, %

Салбар	2012	2017т	2022т	Өөрчлөлт			Өсөлт (%)		
				2012-2017т	2017-2022т	2012-2022т	2012-2017т	2017-2022т	2012-2022т
ХАА	369.960	330.890	318.254	-39.070	-12.636	-51.706	-2.2	-0.8	-1.5
УУ	46.696	71.848	91.480	25.152	19.632	44.784	9.0	4.9	7.0
БҮ	64.897	81.600	88.754	16.703	7.154	23.857	4.7	1.7	3.2
Цах	14.497	15.546	16.266	1.050	719	1.768	1.4	0.9	1.2
УХ	6.681	9.891	12.856	3.210	2.965	6.175	8.2	5.4	6.8
Барилга	59.204	79.230	109.481	20.025	30.251	50.276	6.0	6.7	6.3
БөХҮД	131.340	147.710	128.148	16.370	-19.562	-3.192	2.4	-2.8	-0.2
Тээ	56.091	65.704	65.585	9.613	-119	9.494	3.2	0.0	1.6
Байр/сууц	30.235	31.986	38.341	1.751	6.355	8.106	1.1	3.7	2.4
МХ	14.740	19.262	23.433	4.522	4.171	8.693	5.5	4.0	4.7
Сан/Да	17.376	21.832	22.882	4.456	1.050	5.506	4.7	0.9	2.8
Үл/Хөд	1.208	1.301	1.659	93	358	451	1.5	5.0	3.2
Зах	13.334	14.483	11.772	1.150	-2.711	-1.562	1.7	-4.1	-1.2
ТөУ*	62.919	89.184	108.962	26.265	19.779	46.043	7.2	4.1	5.6
Бол	86.269	95.865	94.793	9.596	-1.072	8.524	2.1	-0.2	0.9
ЭМ	37.529	59.184	73.829	21.655	14.645	36.300	9.5	4.5	7.0
Урлаг	7.357	13.123	16.181	5.766	3.058	8.824	12.3	4.3	8.2
Үйлч	19.783	18.507	14.477	-1.276	-4.030	-5.306	-1.3	-4.8	-3.1
Бүгд	1.051.457	1.184.181	1.261.886	127.740	77.705	205.446	2.3	1.3	1.8

одоо 370 мянга гаруй хүн тус салбарт ажиллаж байгаа бол 10 жилийн дараа 320 мянга болж буурах төлөв бий. Эндээс өсөлттэй салбар бүхэн ажлын байрны эрэлтийг нэмэгдүүлдэггүй гэдгийг харж болно. Тиймээс иргэд өсөлттэй байгаа сургаар тэр салбарт ажилд орно гэж зүтгэх нь тийм ч таатай санаа биш аж. Дээрээс нь хөдөлмөрийн зах зээлийн аль хэсэг нь ханачихсан байгааг талууд мэдэхгүй байна. Үүнийг сайн мэдэхгүй байгаа иргэд буруу шийдвэр гаргасны улмаас “Улаан дипломтай цэвэрлэгч олширлоо гэдэг онигоо” газар авсаар л. Тухайлбал, дээрх судалгаанаас Монгол хэл шинжлэлийн чиглэлээр сурдаг оюутан залуусын тоо хэдийнэ эрэлтээсээ давсан байгааг харж болно. Харин ирэх 10 жилд нарийн мэргэжлийн, илүү мэргэшсэн мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээ өндөр байхаар байна. Тэр дундаа боловсруулах үйлдвэрийн мэргэжилтнүүдийн эрэлт өсөлттэй байгаа аж.

### Монгол хүний үнэлэмж

“Төл бүрийг мал болгоё” гэж уриалдаг шиг “Төгсөгч бүрийг чадварлаг боловсон хүчин болгоход” төр засаг, их, дээд сургуулиудын захиргаа анхаарахгүй байгааг шүүмжлэх хүн цөөнгүй. Төгсөөд гарсан зарим нь хөдөлмөрийн бүтээмж тааруу, үг даахгүй, тогтворгүй хөдөлмөрийн хүмүүжилгүй байдаг гэдгийг ажил олгогчид хэлж байна. Ер нь хөдөлмөрийн зах зээлийн асуудал ярихаар боловсролын тогтолцоотой шууд холбоотой болчихдог. Учир нь


хувь хүний үнэлэмжийг дээшлүүлэхэд мэдлэг боловсрол, дадлага туршлага гэдэг зүйл хамгийн чухал нөлөөтэй байдаг аж. Энэ хоёр хүчин зүйлийг хослуулж чадсан ажилтан хамгийн өндөр бүтээмжтэй байдаг гэх. Харин олон улсад мэдлэг дадлага туршлагыг нь өгөөд бэлэн болсон ажилчин ангийг нийлүүлдэг хэсэг нь нөгөө л их дээд сургуулиуд байдаг. Тэд тэднийг ямар ч өө сэвгүй бэлтгэж чаддаг. Тиймч болохоор хөгжингүй орнуудын хөдөлмөрийн зах зээлд гарч байгаа залуусын хөдөлмөрийн бүтээмж маш сайн байдаг гэх. Гэтэл олон улсын судалгаанаас харахад монголчуудын хөдөлмөрийн бүтээмж тун тааруу. Дэлхийн банк болон Гронинген их сургуулийн (University of Groningen) судалгааг харж байхад хөдөлмөрийн нэг цагт гаргах бүтээмж дараах байдалтай байна.

Улсын нэр	Нэг цагт гаргах бүтээмж, ам.доллараар
Норвеги	37.44
АНУ	35.90
Тайвань	21.91
Сингапур	20.93
БНСУ	18.18
Монгол	1.6 (€Г)

Эндээс харахад манайх Норвеги, АНУ –аас 24 – 22 дахин, Азийн өндөр хөгжилтэй орнуудаасаа ойролцоогоор 12 дахин бага хөдөлмөрийн бүтээмжтэй байна. “Эко Констракшн” ХХК-ийн Хүний нөөцийн менежер А.Ууганбаатар

“Бид аль болох ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй хүнийг мэргэжлийн бус байсан ч хамаагүй ажилд аваад сургахыг илүүд үздэг. Сэтгэлтэй л хүн л тогтвортой, бусдаас илүү хөдөлмөрийн бүтээмжтэй ажиллана шүү дээ.” гэв. Ер нь ажил олгогчдын үгийг сонсоод байхнээ тухайн мэргэжлээрээ сурсан гэхээсээ илүү тухайн мэргэжлээр ажиллах сонирхолтой нэгнийг сургаад авах нь илүү дээр гэсэн бодолтой байх юм билээ. ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн Социологийн секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан О.Баасантогтох “Өнөөдөр их, дээд сургуулийн төгсөгчид мэргэжлийн чадвараас гадна хамт олонтой ажиллах, хэлний мэдлэгийн тал дээр ажлын шаардлага хангахгүй байна. Зах зээлтэйгээ уялдуулсан боловсролын шинэчлэлийг хийх, тэр зах зээлд зориулсан чадварлаг боловсон хүчнийг бэлддэг тогтолцоог бий болгох цаг нь ирсэн” гэжээ. Ер нь монголчууд малаасаа хүнээ дутуу үнэлээд байна гэж шүүмжлэх хүн цөөнгүй байна. Тухайлбал, жил бүр малаа тоолж, төрөл тус бүрээр нь тоо толгойг нь нарийвчлан гаргаж, нийтэд зарлан, бахархдаг. Монголын газар нутаг дээр өнгөрсөн жил 50 сая тоо толгой мал тоологдсон. Малаа ийм сайн тоолоод байгаа мөртлөө өдийг хүртэл яг хэчнээн хүн ажилгүй байгааг нарийн тогтоосон тоо баримт Монголд одоогоор алга. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоогоор л баримжлаалж хөдөлмөрийн зах зээлийг дүгнэж байна. ■

### Салбаруудын ажил эрхлэлт



## МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН-2014



## Б.ГАН-ОЧИР: ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСЛҮҮД ГАРААНДАА ЯВАА

**Б.БАЯР**

“Монголын эдийн засгийн форум”-ын зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын зөвлөх Б.Ган-Очиртой ярилцлаа.

**-Энэ жилийн чуулганд Дэлхийн эдийн засгийн форумын төлөөлөгчид ирж оролцохоор байгаа. Тэдний зүгээс Монголын талаар хийсэн хөгжлийн зураглалаа танилцуулах уу?**

-Чуулганы хүндэт төлөөлөгчдийн нэг нь Дэлхийн эдийн засгийн форумынхан. Урьд нь төслийн багийнхан манайд хэд хэдэн удаа ирж байсан. Тэгвэл энэ удаа Монголын эдийн засгийн чуулга уулзалтад онцгой ач холбогдол өгч байгааг тэмдэглэх нь зүйтэй байх. Тэдний хувьд Монгол Улсын 2040 он хүртэлх хөгжлийн зураглалыг танилцуулна. Өнгөрсөн хугацаанд хоёр том арга хэмжээ дээрх хөгжлийн зураглалтай холбоотой болсон. Эхнийх нь дэлхийн эдийн засгийн форумын дугуй ширээний ярилцлагыг анх удаа Монголд зохион байгууллаа. Дараагийн нь Швейцарийн Давос хотноо болсон 44-дэх удаагийн Дэлхийн эдийн засгийн форумын үеэр одоо хэлэлцэх гэж буй хөгжлийн зураглалыг дэлхий нийтэд албан ёсоор танилцуулсан. Энэ нь Монгол Улсыг дэлхий нийтэд улам ойртуулж, нээлттэй орны нэг болохыг зарласан. Өнгөрсөн Дэлхийн эдийн засгийн форумын хувьд Монголоор “амьсгалсан” гэж хэлж болно. Давос хотноо Монголын талаарх эерэг уур амьсгал бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын анхааралд өртүүлж чадсан төслийн багийнхан зураглалаа хувийн хэвшлийнхэнд танилцуулж, тэдний санал хүсэлтийг авна. Энд нэг зүйлийг онцолж хэлэхэд, Дэлхийн эдийн засгийн форум болон Монголын эдийн засгийн форумын хамтын ажиллагаа өргөн хүрээнд хөгжиж байна.

**-Та Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан хөгжлийн гурван хувилбараас алийг илүү онцлох вэ?**

-Асуудлын цөм нь Монголын эдийн засгийн чуулган болох гэж байна. Эндээс таны асуултын хариулт илүү тодорхой болно. Хүн бүрийн бодол харилцан адилгүй. Тиймээс гадаад эрсдэл, боломжийн талаар өгөгдсөн хувилбарт аль нэг нь илүү гэж туйлшрах төдийлэн онц биш ээ. Харин эдгээр гурван хувилбарыг зэрэгцүүлж хөгжүүлэх, түүнд авах гээхийн ухаанаар хэрхэн хандах нь вэ гэдэг чухал.

**- “Монголдоо бүтээцгээе” уриалгын хувьд та юу хэлэх вэ?**

-“Монголдоо бүтээцгээе” сэдэв 2014 оны ярих ёстой, чухал сэдвийн нэг. Эдийн засгийн чуулганы тухайн жилдээ ямар сэдвийг онцолж байгаа нь ихээхэн ач холбогдолтой. Манай улсын хувьд экспортынхоо 99 хувийг түүхийгээр нь гадагш гаргаж байна. Харин импортын 90 орчим хувийг эцсийн хэрэглэгчдэд хүрдэг бараа, бүтээгдэхүүн эзэлж байна. Энэхүү зөрүүтэй байдал нь улс орны хөгжилд төдийгүй эдийн засагт томоохон дарамт авчирч байгаа. Тиймээс нэгдүгээрт, хийж бүтээхийг хүмүүст уриалах, хоёрдугаарт, бүтээж байгаа хүмүүсээ сонсох, гуравдугаарт, дэмжих үүднээс дэвшүүлж тавьж байгаа юм.

**-Засгийн газраас 2014 оны импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх жил болгон зарласан. Энэ чиглэлд монголчууд хэрхэн ажиллах ёстой вэ?**

-“Чингис” бондоос санхүүжүүлсэн зарим төслийн үр дүн эхнээсээ гараад эхэлсэн. Тухайлбал, оёдлын салбарт бүтээмж дээшилж, үйлдвэрлэл нэмэгдсэн. Цаашид импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжих төслүүд гараандаа явааг хэлье. ■

## ДАВОСЫН ЧУУЛГАН

# МОНГОЛЫН ТАЛААРХ СТРАТЕГИЙН ШИЙДВЭР

Р.ГАНТУЛГА

Монгол Улсын ирээдүйн нөхцөл байдал 2040 онд хэрхэх талаар хийсэн гурван хувилбарыг Дэлхийн эдийн засгийн чуулганы зүгээс санал болгосон. Хувилбар тус бүр харилцан адилгүй тодорхойгүй нөхцөл байдлаас бүрдэж буй. Тиймээс энэ нь бодлого тодорхойлогчдоод цаашдын бодлого, шийдвэрээ гаргахад нь дэмжлэг үзүүлэх юм. Үүний тулд Монголын улстөрчид стратегийн илүү сайн шийдвэр гаргах, ирээдүйд юутай ч тулгарахад бэлэн байх шаардлагатай юм.


## Яагаад хувилбарууд гэж?

Нөхцөл байдал тодорхойгүй байхад зөвхөн таамаг төдий зүйлд найдах нь ухаалаг сонголт биш. Тухайлбал, Азийн орнуудын хөгжлийн замнал цаашид ямар байх бол. Түүнчлэн өнөөгийн бодлогоо тодорхойлж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхийн тулд ирээдүйн нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай болдог. Энд санал болгож буй хувилбарууд нь энэхүү үнэлгээгээр хангаж өгнө. Хувилбарууд нь таамаг төдий зүйл биш бөгөөд ирээдүйн талаарх үнэмшилтэй зураглал юм. Энэ нь улс орон, байгууллага, группын ирээдүйн нөхцөл байдал ямар байх талаарх хамгийн боломжит зураглалыг өөр өөр хэлбэрээр гаргасан, стратегийн ул суурьтай, сайн шийдвэр гаргахад зориулсан хэрэгсэл юм.

## Монгол Улсын стратегийн хувилбарууд

Монголын хувьд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж,

## Стратегийн хувилбарууд



борлуулахад харьцангуй хялбар байх нөхцлийг бүрдүүлэх нь чухал. Гэхдээ уул уурхайгаас бусад бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээнд энэ нь хүндрэл учруулж болзошгүй. Энэ байдал 2040 онд хэрхэх талаар гурван хувилбарыг боловсруулсан. Үүнд:

### Хувилбар 1:

Бүс нутгийн сэргэн мандалт. Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад хялбар байх аж. 2040 онд Монголын хөршүүд улстөр, эдийн засгийн хувьд илүү нэгдмэл болсон

байна. Зүүн хойд Ази болон ОХУ-ын зүүн хэсэгт худалдаа, хөрөнгө, мэдлэгийн урсгал чөлөөтэй болж, хүн ам нэмэгдэж, хамтын ажиллагаа сайжирна. Үүний дүнд бүс нутгийн эдийн засаг огцом өсөх аж. Энэ нь Монголын хувьд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн болон бусад бараа, үйлчилгээг борлуулахад урьд хожид байгаагүй сайхан боломж болох юм байна. Гэхдээ эрсдэл бий. Үүнд, Монгол Улс голланд өвчин, байгаль орчинд учруулах хор хөнөөл, баян, ядуугийн хоорондох ялгаанаас үүдсэн олон нийтийн үймээн, уламжлалт ▶▶

► амьдралын хэв маягаас үүдэлтэй сөрөг нөлөө зэргээс урьдчилан сэргийлж чадах болов уу.

### Хувилбар 2:

БНХАУ-ын (байгаль орчноо хамгаалахад чиглэсэн) ногоон бодлого. Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайгаас бусад чухал бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, борлуулах боломжтой юм байна. Харин уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад хүндрэлтэй тулгарахаар байна. 2040 он гэхэд БНХАУ ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, шинэ технологи, үйлдвэрлэлийн илүү цэвэр үйл явцыг санаачилах зэрэг талбарт бүс нутгийн хэмжээндээ тэргүүлж, эдийн засгийн дундаж өсөлттэй байх аж. Учир нь тус улс нийгмийн тогтвортой байдал, хүрээлэн буй орчны чанарыг сайжруулах зэрэг илүү тогтвортой хөгжлийн төлөө зорино.

Нөгөө талаас, Хятадын ногоон хөгжил нь Монголд уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнээ эскпортлоход нь хүндрэл учруулна. Учир нь байгаль орчин болоод нийгмийн зардал нэмэгдэж, бүтээгдэхүүний эрэлт буурах аж. Гэхдээ энэ хувилбар Монгол Улсад ногоон бодлоготой болж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж, эдийн засгаа төрөлжүүлэх боломжийг бүрдүүлэх сайн талтай ч байж болох.

### Хувилбар 3:

Байгалийн нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайгаас бусад бүтээгдэхүүн болон үйлчилгээг бий болгож, борлуулах боломжгүй болох юм. Бүс нутгийн хувьд 2040 он гэхэд тарж бутарсан байдалтай, геополитикийн зөрчилдөөнтэй, эдийн засгийн тэмцэл, өрсөлдөөнөөр дүүрэн байх шинжтэй. Байгалийн нөөц, баялгийг улс төрийн хөшүүрэг болгон ашиглаж, энэ нь Монголын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүнийн эрэлтэд нөлөөлнө. Баруун эсхүл зүүн жигүүрийн популизм давамгайлсан улс, орнууд өөрсдийн хувийн ашиг сонирхлыг илүүд үзнэ. Хөрөнгө оруулагчид зөрчил, тэмцэл, үймээн самуун гарах эрсдэл багатай орнуудад хөрөнгө оруулалтаа хийхийг илүүд үзэх болно.

Энэхүү хувилбар нь Монголын хувьд хүндхэн сорилт юм. Уул уурхайн баялгаа нээн олборлож, эдийн засгийн

бусад салбараа хөгжүүлэхийн тулд санхүү болон эскпертизийн тусламж, дэмжлэг авахад олон хүндрэлтэй тулгарах аж. Өөдрөг талаас нь харвал, Монгол Улс бүс нутагтаа бие даасан хэм хэмжээгээ хадгалж, бүс нутгийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд идэвхтэй оролцох боломжтой юм байна.

## Монгол Улс стратегийн шийдвэр гаргахад зориулсан хувилбаруудын үр нөлөө

### Стратегийн шийдвэр № 1:

**Бүс нутгийн сэргэн мандалт:** Энэ хувилбараар бүс нутгийн нэгдмэл байдал нь эдийн засгийн өсөлтийг авчирч, Монгол Улсад уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах ихээхэн боломжийг бүрдүүлэх аж.

Гэхдээ эдгээр боломж шууд гараад ирнэ гэсэн баталгаа үгүй. Бүс нутгийн эдийн засгийн хүчтэй өсөлт нь бусад орны анхаарлыг татна. Гэхдээ Монгол Улс дэд бүтцээ системчилсэн хэлбэрээр сайжруулж, өрсөлдөх чадвар сайтай, өндөр ашигтай хөрөнгө оруулалтыг татахад анхаарах нь зүйтэй. Засгийн газар цаашид хувийн хэвшилд оролцоод байх уу, оролцохгүй байх уу гэдэг асуудлын тал дээр нэгдсэн зөвшилцөлд хүрэх ёстой. Мөн уул уурхайн салбарт ногдуулах татвар болон хайгуул, ашиглалтын лиценз олгох асуудлыг ч нааштай шийдвэрлэх шаардлагатай тулгарна.

Уул уурхайн салбарыг өргөжүүлж, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэхдээ ашгийн шударга хуваарилалт хийж байгаа гэдгээ олон нийтэд ойлгуулах байдлаар зохион байгуулах. Голланд өвчнөөс сэргийлэх, хөгжлийг дэмжих хэлбэрээр уул уурхайгаас олох орлогыг сайтар зохион байгуулах хэрэгтэй. Валютын ханш зэрэг макро эдийн засагт зориулсан сайн менежменттэй байх нь энэ хувилбарт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улсын баялгийн сан хоёр төрлийн дэмжлэг үзүүлэх болно. Нэгдүгээрт, эдийн засаг хэт халахаас урьдчилан сэргийлэхийн тулд шаардлагатай үед эдийн засгаас мөнгө гаргаж, хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ажиллах. Хоёрдугаарт, шаардлагатай үед орон нутгийн чанартай хөрөнгө оруулалт хийж, хөгжлийн сан хэлбэрээр ажиллах. Эхнийх нь санхүүгийн экспертиз

шаардах бол удаах нь салбарын тусгай менежментийн экспертиз шаардах болно.

**БНХАУ-ын ногоон бодлого:** Энэ хувилбар Хятад болон бүс нутгийн ногоон бодлого нь Монголын уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад урт хугацааны хүндрэл учруулна гэсэн саналыг дэвшүүлж байна. Харин богино хугацаанд энэ хувилбар нь “Нартай үед хадлангаа бэлтгэх” боломжийг бүрдүүлж буй. Энэ үеийг ашиглан уул уурхайн бүтээгдэхүүнээ аль болох хурдан борлуулж, баялгийн сандаа аль болох ахиулан хуримтлал бий болгох хэрэгтэй. Бүтээгдэхүүний борлуулалт муудах үед баялгийн сангаасаа ашиглах боломжтой юм. Засгийн газар одооноос үр ашиг, өрсөлдөх чадварыг нь сайжруулах хэрэгтэй институц, дэд бүтцэд хөрөнгө оруулж эхлэх нь зүйтэй. Энэхүү богино хугацааны стратеги нь урт хугацаанд өөр боломжийг бүрдүүлэх боломжтой гэдгийг олон нийтэд ойлгуулах хэрэгтэй болно.

Энэ хувилбараар уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний ханш буурч, энэ нь экспортыг дэмжихэд хангалтгүй байх аж. Гэхдээ Монгол Улсын хувьд ногоон хөгжлийг сонгосон орнууд руу эскпортлох боломжтой газрын ховор элемент, уран зэрэг өөр бүтээгдэхүүн нээн илрүүлэх боломж бий.

Байгалийн нөөцийн зөрчилдөөн: Энэ хувилбараар геополитикийн зөрчил нэмэгдэж, эрдэс баялгийн стратегийн зориулалтаарх ашиглалт нэмэгдэх учраас уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулахад ихээхэн хүндрэлтэй болохоор байна. Өмнөх хувилбарын нэгэн адил уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг аль болох хурдан, үр ашигтай хийж, баялгийн сандаа хуримтлалтай болохын тулд одоогийн уул уурхайн үйл ажиллагааны үр ашгийг хамгийн дээд түвшинд хүрэгэхэд анхаарах хэрэгтэй.

### Стратегийн шийдвэр №2:

**Бүс нутгийн сэргэн мандалт:** Бүс нутгийн нэгдмэл байдал болон эдийн засгийн өсөлт нь бүс нутагт харьцуулалт хийх давуу талыг Монголд олгох болно. Хөдөө аж ахуй, оёмол бүтээгдэхүүн, газрын тос, байгалийн хий, уул уурхай, санхүүгийн үйлчилгээ зэрэг салбарт бараа, үйлчилгээ шинээр бий болгох шаардлагатай тулгарна. Тухайлбал, Монгол Улс ОХУ-ын хөдөө аж ахуйн ►

► зарим бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломжгүй ч оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ өрсөлдөх давуу талтай байж болох юм.

**БНХАУ-ын ногоон бодлого:** Энэ хувилбар Хятад болон бүс нутгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалахад чиглэсэн ногоон бодлого баримтлахыг харуулж байна. Энэ нь Монголын уул уурхайн гол нэрийн бараа, үйчилгээнд томоохон сорилт болох аж. Зах зээлийн эрэлт өөрчлөгдөх учраас Монголын хувьд органик мах, сүү, ноолуур, эко аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч гэх мэт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. Бараа, үйчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэхийн тулд нэлээд цаг хугацаа, хөрөнгө оруулалт шаардагдана.

Шинэ бараа, үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд бизнесийн орчин маш сайн байх шаардлагатай. Тухайн салбар хараахан бие дааж хөгжих боломжгүй үед төрийн оролцоо зарим үед дэмжлэг үзүүлэх нь бий. Гэхдээ үүнийг хийхэдээ маш сайн судалгаа, шинжилгээнд үндэслэх ёстой. Мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон олон улсын компаниудад зориулсан тодорхой, ойлгомжтой журам гаргаж, бизнесийн орчинг ил тод болгох. Мөн баялгийн сангийн хөрөнгөөс боловсролын салбарт хөрөнгө оруулах шаардлагатай тулгарна.

**Байгалийн нөөцийн зөрчилдөөн:** Энэ хувилбараар Монгол Улс уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулах, мөн бусад салбараа хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилт олохын тулд ихээхэн хүндрэлтэй тулгарах аж. Бүс нутгийн бизнесийн орчин тааруухан байх болно.

Дэд бүтэц, боловсролын салбарт стратегийн хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадварыг хамгийн дээд түвшинд хүргэхэд чухал ач холбогдолтой. Бүс нутгийн тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны сүлжээг дэмжихэд эртнээс анхаарах нь цаашид бүсийн дунд хуваагдал үүсч, үүнээс бий болох сөрөг нөлөөллийг бууруулахад тустай юм.

Хөрөнгө оруулалт, тээврийн зардал багатай бүтээгдэхүүн, үйлчилгээ нь экспортыг төрөлжүүлэх сайхан боломж байж болох. Тухайлбал, чацаргана гэх мэт. Мөн Итали зэрэг зах зээл рүү ноолуур тээвэрлэхэд хялбар байж болно. Хөрш орнуудтай харьцуулахад

мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарт ихээхэн дэвшил гаргах боломж Монголд бий.

Логистик, аюулгүй байдлын стандартыг дээшлүүлснээр махны экспортыг сайжруулах боломжтой. Гэхдээ шинэ салбараар эдийн засгийг төрөлжүүлэхэд тулгарах саад, бэрхшээл нь Монголыг нүүдэлчин соёл, уламжлалын өнөөгийн хэв маягаа цаашид хэвээр хадгалахад хүргэж ч болзошгүй.

### Стратегийн шийдвэр №3:

**Бүс нутгийн сэргэн мандалт:** Энэ хувилбараар бүс нутаг нэгдмэл байх бөгөөд Монгол Улсын хувьд худалдаа, хөрөнгө оруулалт хийх боломж олж авахад илүү хялбар байх аж. Гэхдээ эдгээр боломжийг хүртэх давуу талыг олж авахын тулд Монголын Засгийн газар бүс нутгийн орнуудын Засгийн газар болон институттэй нягт хамтран ажиллах шаардлагатай. Энэ хувилбараар амжилт олохын тулд Монгол бизнесийн сайн түнш байж, хөршүүд болон олон талт институт, хувийн хөрөнгө оруулагчидтай сайн харилцаатай байх шаардлагатай юм.

Хөнгөлттэй зээлийн сан болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын есөлтийг түвшинг үнэлснээр тээврийн зардал, логистикийн асуудлыг нааштай шийдвэрлэх боломжтой. Учир нь Монгол Улс далайд гарцгүй. Хоёр хөршийнхөө болон бүсийн хэмжээнд худалдаа, наймааг хөнгөвчлөхөд чиглэсэн дэд бүтцээр хангаж өгөх хэрэгтэй болно.

**БНХАУ-ын ногоон бодлого:** БНХАУ болон бүсийн бусад орон ногоон хөгжлөөр замнах тохиолдолд Монгол тэдгээртэй хэрхэн хамгийн сайн харилцаатай байхаа тодорхойлох хэрэгтэй болно. Тухайлбал, олон улсад ногоон орон гэсэн нэр хүндийг олж авах, хөрөнгө оруулагчдыг татах. Хятад болон дэлхийн компаниудтай хоёр талт хэлэлцээр хийх нь ногоон үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн сүлжээ (green industry supply chains)-нд нэгдэх боломжийг олж авах чадавхыг хөгжүүлнэ. Тухайлбал, газрын ховор элементээ ашиглан цахилгаан автомашины зай хураагуурын зарим эд ангийг үйлдвэрлэх гэх мэт.

**Байгалийн нөөцийн зөрчилдөөн:** Энэ хувилбар нь геополитикийн зөрчилдөөн, мөн байгалийн нөөцийг стратегийн орд болгон ашиглах нь бүс нутаг дахь харилцааг ойлгох, боломжийг олж илрүүлэхэд чадварлаг удирдан, зохион байгуулах зэрэгт чухал ач

холбогдолтой байх болно. Тухайлбал, Хятадын оролцоотой зөрчилдөөн нь Австрали, Монгол зэрэг нийлүүлэгч орны худалдаанд заналхийлж болзошгүй юм. Энэ нь Хятадтай хөдөө аж ахуйн худалдааны талбарт хамтрах боломжийг нээж өгөх ч талтай. Хөрш орнуудтайгаа эдийн засаг, улс төрийн ул суурьтай харилцааг бий болгохын чухлыг энэ хувилбар санал болгож буй. Урт хугацаанд эдийн засгийн байдал улам хүндрэх учраас соёл, боловсролын солилцоо зэрэг харилцааг хөгжүүлэх, нөгөө талаас зардал багатай сонголтуудыг хийх боломжтой юм. Бүс нутгаас гаднах орнуудтай урт хугацааны түншлэл, хамтарсан хөрөнгө оруулалт хийх нь хамгийн зөв арга зам байж болох. Энэ нь ноолуур зэрэг уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэхэд тустай. Эцэст нь хэлэхэд, энэ хувилбараар бүс нутгийн байдал замбараагүй байх боловч Монгол Улс хоёр хөршийнхээ Монгол угсаатнуудтай худалдааны харилцаагаа өргөжүүлэх боломжтой юм.

*Дээрх гурван хувилбар нь гадаад, дотоодын бизнесийн байгууллага, эрдэмтэн, судлаачидтай Монгол Улсын цаашид эдийн засгийн талаар стратегийн уулзалт, хэлэлцээр хийж, төрийн бодлого тодорхойлоход гол тулгуур болж өгөх юм. Энэ тайланг гаргахаас өмнө олон уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Тухайн үед бүс нутаг болон дэлхий эдийн засаг Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлж буй, эдгээр нь хоорондоо хэр нягт холбоотой зэргийг онцлон тэмдэглэж байв. Дээрх хувилбарууд нь Монгол орны нөхцөл байдал 2040 он хүртэл ямар байх талаарх хамгийн боломжит санал. Хоорондоо харилцан адилгүй бөгөөд хоосон таамаг, төсөөллөөс ангид. Мөн Монгол Улсыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх үүднээс байгалийн нөөцөө зөв зохистой ашиглах боломжийг дээд зэргээр нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн болно.*

*Цаашид гарын авлага болгон ашиглах дээрх хувилбарууд нь ДЭЗЧ болон Монгол Улсын хоорондох хамтын ажиллагааны үр дүн юм. Хувилбаруудын гол зорилго нь хурдацтай хөгжиж, шинээр гарч ирж буй эдийн засгийн дүр төрхөө олоход нь Монгол Улс болон гол оролцогч талуудад дэмжлэг үзүүлэхэд оршино. ■*

## ТАТВАР

## ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

## И.ОТГОНЖАРГАЛ


“Төр буй дор татвар буй” гэсэн ардын үг татварын байгууллагын таних тэмдэг мэт монголчуудын сэтгэлд хоногшсон байдаг. Гэхдээ өнөөдрийг болтол монгол хүн бүрт татвар төлөх ухамсар төдийлэн сайн төлөвшөөгүй. Энэ нь Монгол Улсад орчин үеийн татварын систем 1992 оноос бүрдэж эхэлсэн хэмээн үздэгтэй холбоотой ч байж болох. Бусад хөгжилтэй оронтой харьцуулахад манай татварын салбарын хөгжлийн түүх харьцангуй залуу учраас монголчууд татварын ухамсарт суралцах шатандаа яваа гэж өмөөрч болох юм. Зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш Монголд татварын систем сайжирсаар ирлээ. Ерээд оны сүүлч шинэ мянганы эхэн үе хүртэл монголчуудын хувьд татварын албатай харилцана гэдэг амаргүй ажил байв. Заавал өөрийнхөө дүүрэг, байгууллагыг хариуцсан татварын байцаагчийг таньдаг байх шаардлагатай төдийгүй татварын албанд ирээд тайлангаа хурдан өгч чадах эсэх нь зөвхөн тухайн байгууллагыг хариуцсан байцаагчаас бүрэн хамааралтай болдог хүнд үе байсан. Татвар төлөгч аж ахуйн нэгж нь ч харьцангуй цөөхөн, уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, АПУ, МЦК зэрэг тухайн үеийн төрийн болон хувийн тоотой хэдхэн том компани, үйлдвэр аж ахуйн нэгжээс улсын төсвийн орлогын ихэнх хэсэг бүрддэг байв. Харин одоо бол байдал өөр. XXI зууны монголчууд татварын үр ашиг, ач холбогдолыг бага сага гадарлахтайгаа болж. Гэхдээ л ажил төрөл хийж байгаа томчууд нь болж өгвөл татвараас зугатаж бултчих арга саам хэрэглэх дуртай болохоор үр хүүхэд нь татварын тухай огт

ойлголтгүй өсөж, хүмүүждэг. Тийм болохоор “Mongolian Economy” сэтгүүл Сангийн яам болон бусад холбогдох байгууллагатай хамтран олон нийтэд татварын системтэй мэдлэг, мэдээлэл өгөх ажлыг эхлүүлж байна. Төр, засгийн татвар хураамжийн бодлого шийдвэр ч хөгжлийн төрхөө олж, илүү ухаалаг, энгийн ойлгомжтой болох чиглэлд явж байна. Татвар төлдөг, хураадаг хоёр талын хүсэл сонирхол нэгдээд, төрийн ухаалаг бодлого хэрэгжээд ирвэл татварын утга учрыг иргэд ойлгож, үүргээ ухамсарлана.

Өнгөрсөн хугацаанд татварын алба хамгийн их өөрчлөлтийг авчирсан. Хүнд суртлыг халж, үйлчилгээ нь татвар төлөгчдөд ойртож, хөнгөн шуурхай болж чадсан гэдэгтэй олон нийт санал нийлэх байх. Мэдээж бүрэн төгс сайжирч бол чадаагүй л дээ. Гэхдээ л татварын байцаачийг царайчилахаа больж, өнөөдөр татвар төлөгч татварын тайлангаа тушаахын тулд заавал өмнөх шигээ татварын

албанд биеэр очих шаардлагагүй, хаа дуртай газраасаа тайлангаа цахим хэлбэрээр өгдөг болсон. Хүссэн дурын мэдээллийг утсаар асууж, шаардлагатай хуулийн заалтыг тайлбарлуулж ч болно гээд олон эерэг өөрчлөлт бий болсон. Ялангуяа сүүлийн 2-3 жилд татварын тайлагнал, төлөлтийг хялбарчлах ажлыг Засгийн газраас нэлээд хийж байгаа. Сангийн сайд Ч.Улаан “2014 онд нийт аж ахуйн нэгжийн 70 хувийг электрон тайлагналын системд хамруулна. НӨАТ-ын э-падааны систем нэвтрүүлнэ” хэмээн ярьсан.

Монгол Улс өнөөдрийн байдлаар экспортынхоо 90 орчим хувийг зөвхөн уул уурхайгаас олж байгаа. Тэр дундаа зэс, нүүрс зэрэг уул уурхайн цөөн нэрийн бүтээгдэхүүний орлогоос эдийн засаг хараат байгаа учраас татварын II үе шатны шинэчлэлийг 2014-2017 онд хийхээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссаны дагуу өнөөдөр татварын шинэчлэлийн ▶




► асуудал ид өрнөж байна. Шинэчлэл хийх шаардлага нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн зохицуулалтыг хийж өгөх, татварын хуулийн зарим ойлгомжгүй, хийдэл давхардал үүсгэдэг зүйл заалтыг Долоон буудлын Долгор эмээ уншсан ч ойлгохоор энгийн болгох зорилгыг агуулсан аж.

Монгол Улс татварын I үе шатны шинэчлэлийг 2006-2012 онд хийсэн гэж үздэг. Тус шинэчлэл нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах зорилготойгоор хэрэгжсэн бөгөөд татварын дөрвөн 10-ын зарчимд шилжсэн явдал юм. Ингэснээр Монгол Улс тухайн үед Азидаа хамгийн бага татвартай орон болж байсныг та мэдэх байх. Үр дүнд нь гаднын хөрөнгө оруулалтыг татаж, татварын орлого эрс өссөн. Тухайлбал, статистик мэдээллээс үзэхэд сүүлийн арван жилд ААНОАТ төлөгчийн тоо жил бүр дунджаар 13-18 хувиар өсөж, 2012 оны жилийн эцсийн байдлаар 82432-д хүрчээ. Тус татвар нь нэгдсэн төсвийн орлогын 12-20 хувийг эзэлж байна. Энэ нь уул уурхайн салбарын хөгжилтэй шууд холбоотой.

Өнөөдрийн татварын шинэчлэлийн хүрээнд нийт 17 хуульд өөрчлөлт оруулахаар байгаа аж. Үүнээс Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зэрэг гол хуулийн төслийг боловсруулж, намрын чуулган завсарлахаас өмнө УИХ-д өргөн барьсан билээ. Хаврын чуулган эхлэнгүүт батлагдахаар байгаа. Мөн Онцгой албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ч Сангийн сайд Улсын Их хурлын даргад өнгөрсөн хоёрдугаар сард өргөн барьсан. Онцгой албан татварт хамаарагддаг бараа, үйлчилгээний татвар болон Ашигт малтмалын тухай хуулиар тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээг ам.доллараар тогтоосон байдаг. Үүнээс үүдэн ам.долларын ханш өсөх үед аж ахуйн нэгжүүдийн татварын ачаалал нэмэгддэг. Харин

2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу хөрөнгө оруулагч нарт татварын дэмжлэг үзүүлэхээр заасан.



• Тогтворжуулах гэрчилгээгээр дараах татварын хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна:

1. Аж ахуйн нэгж ийн орлогын албан татвар
2. Гаалийн албан татвар
3. Нэмэгдсэн өртгийн албан татвар
4. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Эх сурвалж: Сангийн сайд Ч.Улаан "Улсын төсөвт нүүрсний салбарын үзүүлэх нөлөө, татварын орчин шинэчлэх" илтгэлээс

ам.долларын ханш буурах үед төсвийн орлогын эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлдэг байна. Тиймээс энэ нөхцөл байдлыг харгалзан үзэж, ам.доллараар тогтоосон онцгой албан татвар, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төгрөгөөр тогтоох зорилгоор Онцгой албан татварын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудад өөрчлөлт оруулах төслийг боловсруулжээ. Дээрх хуулиудад ам.доллараар тогтоосон татвар, төлбөрийг төгрөгт шилжүүлэн тогтоохдоо ирэх жилүүдийн ам.долларын төгрөгтэй харьцах ханш, инфляцийн түвшинд үндэслэн, төсөвт төвлөрөх орлогын хэмжээг тодорхой хугацаанд бууруулахгүй байх зарчмыг баримтлан боловсруулсан байна.

Мөн намрын чуулганд өргөн барьсан ААНОАТ, НӨАТ –ын тухай хуулиадад хөрөнгө оруулагч, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийн орчин, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн томоохон өөрчлөлт орж байна. Тухайлбал, ААНОАТ-ын тухай хуульд уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн телефоны операторын үйлчилгээ, согтууруулах ундаа, тамхи, банк санхүү зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжид төсөвт төлсөн ААНОАТ-ын 90 хувийг буцаан олгохоор тусгажээ. Мөн НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг өнөөгийн эдийн засгийн өсөлттэй уялдуулан өөрчлөхөөр НӨАТ –ын тухай хуулийн төслийг боловсруулсан. НӨАТ төлөгчийн босгыг дараах хоёр нөхцөлийг үндэслэн тогтоосон гэнэ.

Үүнд, нэгдүгээрт, инфляцийн өсөлт, хоёрдугаарт, НӨАТ-ын оновчтой босгыг тогтоох загварыг ашиглажээ. НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг 1998 онд 10 сая төгрөг гэж тогтоосноос хойш 16 жилийн турш ямар ч өөрчлөлт ороогүй. Гэтэл инфляци жилд дунджаар 10 хувиар өссөн бөгөөд 1998 оны 10 сая төгрөг өдгөө 42 сая төгрөг болоод байна. Тиймээс энэ байдлыг харгалзан ОУВС болон Торонтогийн их сургуулийн судлаач Майкл Кеен, Жак Минтз нарын НӨАТ-ын оновчтой босго тогтоох загварыг ашиглаж, НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг байхаар тогтоож. Түүнчлэн босгын хэмжээг өөрчилснээр одоо НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээдийн эрх ашгийг хохироохгүй байх зорилгоор 10-50 сая хүртэл төгрөгийн борлуулалтын орлоготой хувь хүн, хуулийн этгээдийн тухайд албан татвар төлөгчөөр сайн дураар бүртгүүлэх боломжийг олгож байгаагаараа энэ хууль нэлээд онцлогтой болсон гэж хуулийн төслийг боловсруулсан Сангийн яамны холбогдох мэргэжилтнүүд онцолж байна. Өмнө нь НӨАТ-ын босго бага байсан нь жижиг үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж дээр тооцоолол хийхэд хүндрэлтэй. Сар болгон татварын албанд тайлан гаргаж, падаан цуглуулах ажилд цаг, мөнгө зарлагдадаг гэсэн гомдол тасардаггүй байжээ. Ийнхүү босгыг 50 сая төгрөгөөр тогтоосон тохиолдолд 10 сая төгрөг даваад НӨАТ төлөгчөөр бүртгүүлчихсэн байгаа аж ахуйн нэгжийн нуруу амарна гэсэн үг. ►

▶ Гэхдээ хасалт хийлгэх сонирхолгүй, Аж ахуйн нэгжүүдийн хувьд хүсвэл сайн дурын НӨАТ суутгагч гэдэг ангилалд орох нээлттэй. Та 50 саяын босгод хүрээгүй ч гэсэн хүсвэл НӨАТ төлөгч байж болно гэсэн үг. Нэр томъёоны хувьд “НӨАТ төлөгч” гэсэн томъёоллыг НӨАТ-ын суутгагч гэж өөрчлөн оруулж ирж байгаа аж. “НӨАТ төлөгч” гэсэн томъёолол хэрэглэж байгаагаас аж ахуйн нэгжүүд өөрсдөө уг татварыг төлөөд байгаа юм шиг буруу ойлгодог. Гэтэл эцсийн хэрэглэгч л төлдөг. Дундаас нь суутгаж авч төсөвт төлөх үүрэгтэй этгээд өөрийгөө төлж байна гэж ойлгоод байгаа юм. Тиймээс нэр томъёог ийн өөрчилжээ.

Татварын шинэчлэлийг хийхдээ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримталж байгаа гэдгийг холбогдох албаныхан хэлж буй. Харин шинэчлэлийн хүрээнд татварын

хууль тогтоомж энгийн ойлгомжтой болсноор татвар төлөгчийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардал буурна гэж үзэж байна.

ААНОАТ-ын тухайд 10, 25 гэсэн хоёр хувь хэмжээтэй. Тодруулбал гурван тэрбум төгрөгийн ашигтай ажилласан аж ахуйн нэгж ашгаасаа 10 хувийн татвар төлнө. Гурван тэрбумаас дээш орлоготой аж ахуйн нэгжийн хувьд 25 хувийн татвар төлдөг. Үүнийг олон улсын түвшинтэй харьцуулахад дундаж түвшинд байгаа юм. НӨАТ ч мөн ялгаагүй, бусад орныхтой харьцуулахад дундаж түвшинд буй. Хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээ дэлхийн түвшингээс нэлээд доогуур гэдгийг мэргэжилтнүүд онцлож байна. Татварын хувь хэмжээ дэлхийн түвшингээс доогуур байна гээд дээрх гурван гол татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй гэж ойлгож

болох нь ээ. Нөгөөтэйгүүр татварын хууль эрх зүйн орчноос гадна татвар төлөх, тайлагнахтай холбоотой цахим, шуурхай орчинг бий болгох шинэчлэл нэлээд бий аж.

“Mongolian Economy” сэтгүүл эхний удаад татварын хоёр дахь шатны шинэчлэлтэй холбоотой боловсруулагдаж, батлагдах шатандаа яваад хоёр хуулийн төслийн мэдээллийг хүргэлээ. Ойрын үед Засгийн газар, ашигт малтмал, газрын тос үйлдвэрлэгчдийн хуулийг өргөн барихаар бэлэн болгоод байгаа аж. Хотын татвар, Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар гэсэн хоёр хууль шинээр батлагдахаар байгаа. Манайх дараа дараагийн дугаартаа бусад хуулийн шинэчлэлийн талаарх мэдээллийг тогтмол хүргэх болно. Мөн татвар төлөгчдийнхөө мэдлэгийг зузаатгахад чиглэсэн зүйл ч багагүй бичнэ гэдгийг дуулгая. ■

## ЭРҮҮЛ МЭНД

# ЦОГЦ БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

### С.БАТЗАЯА

Эд хөрөнгөө алдвал багыг, эрүүл мэндээ алдвал ихийг алдсанд тооц гэсэн үг байдаг. Хүн бүр ажилтай, орлоготой байж, сайхан амьдралыг цогцлоохын тулд эрүүл байх ёстой. Бидний хичээл зүтгэл, дадал зуршил эрүүл аж төрөхөд нөлөөлдөг ч урьдчилан сэргийлэх эсвэл өвдсөн үедээ эмнэлгийн үйлчилгээ авах хэрэгцээ амьдралаас урган гардаг. Харин бидэнд үзүүлж буй үйлчилгээний чанар сэтгэлд төдийлэн хүрдэггүй. Хамгийн наад захын жишээ дурьдахад, элэгний В, С вирусын шинжилгээг бид хоёр дахь шатлалын эмнэлэгт төлбөртэй өгдөг.

Эрүүл мэндийн даатгалд сар бүр цалингийнхаа хоёр хувийг төлдөг ч үр шимийг нь тэр бүр хүртэж чадахгүй байгаа. Үүнийг шинэчлэн найруулж батлах Иргэний эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулж өгөхөөр ярьж буй ч амьдрал дээр хэрхэн буух нь тодорхойгүй байна. Даатгал төлдөг хэр нь эмчилгээ оношилгоог төлбөртэй авахыг албан бус төлбөр гэдэг аж. Энэ төлбөрийн хэмжээг багасгана гэж Эрүүл мэндийн сайд Н.Удвал ярьж байна. Учир нь, ДЭМБ-аас 2010 онд албан бус төлбөрийн хэмжээ Монгол Улсад ямар байгааг судалжээ. Хариу нь монголчуудын эрүүл мэндийн зардлын 41 хувийг

албан бус зардал эзэлж буй дүн гарч. Тиймээс яам энэ төлбөрийг 25 хувь хүртэл бууруулах зорилт тавьжээ. Өөрөөр хэлбэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын дутууг иргэдээс авахгүйн тулд төсөвтөө 33 тэрбум төгрөг нэмж суулгах тооцоо хийсэн байна. Мөн өндөр өртөгтэй мэс засал, тусгай хэрэгслийн тодорхой хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас гаргаж, иргэдийн халааснаас гарах зардлыг бууруулахад есөн тэрбум төгрөг шаардлагатай байгаа аж.

Энэ оны улсын төсөвт эрүүл мэндийн салбарт 570 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт суулгажээ. Үүн дээр эрүүл ▶▶

▶ мэндийн даатгалын санхүүжилтээр 200 орчим тэрбум төгрөг нэмэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл, энэ жил тус салбарт 760-780 орчим тэрбум төгрөг зарцуулах юм. Манай улс эрүүл мэндийн салбарт хуваарилагдаж буй мөнгөө зөв зүйлд зарцуулах нь чухал болоод буй. Ингэхийн тулд салбарын уялдаа холбоог сайжруулах ёстойг Эрүүл мэндийн эдийн засагч Ц.Нацагдорж хэлж байна. Мөн тэрбээр “Манай улс 1998 оноос хойш эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх гэж оролдсон байдаг. Өрхийн эмнэлгүүд байгуулж, салбарын хүртээмж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд багагүй ажил хийсэн. Харин санхүүжилтийн болон эмнэлгийн салбарын шинэчлэлийг хийх гэж оролдсон ч амжилтад хүрээгүй. Учир нь, эдгээр шинэчлэл тус тусдаа ямар ч уялдаагүй хийгдэж ирсэн. Улс орны эдийн засаг нийгмийн хөгжилтэй холбоотой зарим үзүүлэлт дээшилсэн ч эрүүл мэндийн салбарын гүйцэтгэл сайжраагүй. Өөрөөр хэлбэл, тусламж үйлчилгээг тэгш хүртэж буй эсэх, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, үйлчилгээний чанарт ахиц дэвшил гарсан уу, үр ашиг нь дээшилсэн эсэх нь хангалтгүй. Уг нь энэ мэт завсрын зорилтууд биелж байвал эцсийн зорилго нь сайжрах ёстой байдаг юм” гэв.

Манай улсын өнгөрсөн хугацаанд явж ирсэн тогтолцооноос харахад, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэл тийм ч сайн биш байж. Энэ нь Монголд тус салбарын шинэчлэлийг цогцоор нь хийгээгүйтэй холбоотой аж. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх урт,

дунд, богино хугацааны хөтөлбөр гардаг ч цаасан дээр үлддэг. Учир нь, тухайн гаргасан хөтөлбөрт ямар арга замаар хүрэх, хэрхэн хэрэгжүүлэх талаарх шийдэл, гарц байдаггүй. Энэ салбарыг цаашид яаж хөгжүүлэх талаар Ц.Нацагдорж судалгаа хийжээ. Тэрбээр “Гурван үе шатаар хөгжүүлэх ёстой. Нэгдүгээрт, эрүүл мэндийн салбарын засаглалыг зөв гаргаж ирэх. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын эрх үүргийн хуваарилалт оновчгүй байна. Санхүүжилтийн хуваагдмал байдал хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа. Салбарын санхүүжилтийн 70 хувийг улсын төсөв, үлдсэнийг нь даатгалаас өгч буй ч манай бодлого гаргах түвшний хүмүүс даатгал яриад байдаг. Бид бүх санхүүжилтээ нэг сангаар дамжуулж эмнэлгүүддээ өгдөг болох ёстой. Даатгалын байгууллага төсвийн мөнгийг яаж санд байршуулах вэ гэдэг асуудал эндээс гарч ирнэ. Даатгалын тогтолцоо болон байгууллагын засаглал ийм үед ямар байх талаар бодох ёстой юм. Тусламж үйлчилгээний зохион байгуулалтын хүрээнд Монголд хэчнээн эмнэлэг байх ёстой, ямар шатлалд хуваагдах, хот, хөдөөд ямар байхыг дахин нарийвчлан судлах шаардлагатай. Учир нь, Монголын эмнэлгийн зохион байгуулалт үр ашиггүй байна гэсэн шүүмжлэл бий. Гурав дахь шатлалын эмнэлгүүд ачааллаа дийлдэггүй. Тиймээс шатлал бүрт шинэчлэл хэрэгтэй. Шинэчлэл нь хоорондоо уялдаж, нэг зүгт зангидагдах ёстой. Үүнээс хамгийн чухал нь засаглалын шинэчлэл юм. Үүнийг амжилттай хийсэн тохиолдолд нөгөө хоёрыг нь

хэрэгжүүлэх нөхцөл бүрддэг. Тусламж үйлчилгээний зохион байгуулалтын шинэчлэлийг төлөвлөлт болон санхүүжилтийн хөшүүргийг хослуулж хэрэгжүүлэх боломжтой” хэмээлээ.

Монголын эрүүл мэндийн салбарт орж буй санхүүжилт бага байгаа учраас орчин үеийн тоног төхөөрөмж авч чадахгүй байна гэж зарим мэргэжилтэн ярьдаг. Тухайн мөнгөний эх үүсвэрийг бий болгохын тулд тусламж үйлчилгээний өртөг болон хэрэгцээг нь тооцдог байна. Манайд энэ талаар хийсэн судалгаа байдаггүй аж. Үүнийг хийхийн тулд үзүүлж буй тусламж үйлчилгээний стандартыг шинэчлэх хэрэгтэй гэсэн. Өөрөөр хэлбэл, өртгөө тооцсоны дараа хэрэгцээгээ тооцно. Эрүүл мэндийн яамны дэргэд энэ бүхнийг хийх томоохон баг байх ёстойг судлаачид хэлсэн байна. Ингэхийн тулд эхний ээлжинд Эрүүл мэндийн яам шинэчлэгдэх ёстой. Учир нь, яам бодлого боловсруулж, өөрсдөө хэрэгжүүлээд байгаа нь буруу аж.

Манай эрүүл мэндийн байгууллагууд яамны бодлого шийдвэрийн дагуу явдаг. Яам юу гэнэ түүнийг үг дуугүй биелүүлж буй. Яамны оролцоо төрийн үйлчилгээнд хэт их байгаа нь нэг талаараа энэ салбарын хөгжилд чөдөр тушаа болж байна. Шийдвэр гаргагчдад байгаа эрх мэдлийг эмнэлгүүдэд шилжүүлж өгөх хэрэгтэй. Мөн тусламж үйлчилгээнд санхүүгийн эрх мэдлийг даатгалын байгууллагад нь өгвөл хөгжих учиртай гэсэн. 1990-иэд оноос өмнө социалист системээр явж байсан Эстони, Киргизстан зэрэг улс эрүүл мэндийн салбараа уялдаа холбоотой цогцоор нь хөгжүүлснээр амжилтад хүрчээ. Өөрөөр хэлбэл, манайхтай адил системээр явж байсан ихэнх улс эмнэлгийнхээ засаглалыг өөрчилсөн байдаг аж. Эмнэлгийг бие даалгаж, хүний нөөц, санхүү, менежмент зэргийг хэрхэн шийдэх тухай эрх мэдлийг өөрсдөд нь өгчээ. Энэ нь нэг талаар хариуцлагыг бий болгож, дор бүрнээ алдаа гаргахгүй ажиллах дадлыг бий болгосон байна. Харин манайхан том зургаа харж, хөгжүүлэхээс илүүтэй аар саархан зүйлээр оролдож, засчихвал бүх зүйл сайжирна гэж бодоод байдгаас хөгжил нь урагшлахгүй байгаа аж. ■



## Л.БЯМБААГИЙН БУЛАН



Шинжээч

# ТӨР ГЭДЭГ БИЗНЕС...

## Оршил

Төр гэдэг бизнес гэхээр монголчуудын дийлэнх нь төрийн өндөр албан тушаалд томилогдож, улмаар албан тушаалаа урвуулан ашиглаж өөртөө санхүүгийн болон санхүүгийн бус ашиг хонжоо олох гэж ойлгодог. Үнэн хэрэгтээ төр гэдэг нь шууд утгаараа тухайн улсын ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг бизнес. Төрийн үйлчилгээнд хууль тогтоох, зохицуулах, хэв журам сахиулах, ард иргэдээ эрүүл байлгах, суурь дэд бүтцээр хангах гээд олон тооны нийгмийг бүхэлд нь хамарсан үйлчилгээ багтана.

Нэгэнт бизнес юм бол тэгвэл төрд бизнесийн, өөрөөр хэлбэл ашигт, мөн үр ашигт ажиллагааны хуулиуд үйлчлэх ёстой. Улс төрч, төрийн албан хаагчид улс төр, тус бүрийн чиглэл салбарын мэдлэгээс гадна юуны өмнө менежер, бизнесийн сэтгэлгээтэй байх ёстой. Тэгж үл чадваас төр дампуурна, төсвийн хямрал нүүрлэнэ. Учир нь улсын орлого татвараас бүрддэг, татварыг бид төлдөг, төр бидний мөнгийг аваад зөв, үр ашигтай зарцуулж үл чадваас төрийн функц доголдож бид төрийн үйлчилгээ авч чадахгүй болно.

Төрийн бизнесийг амжилттай ажиллах үндсийг хувийн бизнесийн зарчмаар дүгнэн харъя.

## Бизнесийн зарчим №1 Стратеги

Аливаа бизнесийн амжилтын гол үндэс стратеги байдаг. Тийм ч учраас бүх хувийн компани өөрийн ерөнхий стратеги, алсын хараа, бизнес төлөвлөгөөг тодорхой боловсруулан ажилладаг. Нэгэнт баталсан хойно стратеги төлөвлөгөөг компанийн бүх шатанд ягштал мөрдөж дэвшүүлсэн зорилгод дор бүрнээ хүрэхийн төлөө ажиллаж байж үр дүнд хүрдэг.

Төрийн хувьд улс орны хэтийн хөгжлийн төлөвлөгөө нь үндсэн стратеги болох учиртай. Үндэсний хөгжлийн стратеги нэлээд урт хугацаагаар төлөвлөгдөж, түүнд

нийцүүлэн харин намуудын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг гаргах ёстой.

Дэлхий нийтийн жишгээс харахад хөгжлийн стратеги төлөвлөлтөө сайн хийсэн улс орнууд онцгой амжилтад хүрсэн бодит жишээ олон байна. Тухайлбал, Сингапур, Өмнөд Солонгос, Макао зэрэг нь хэдхэн арван жилийн дотор гайхамшигт үсрэнгүй хөгжлийг хангаж чадсан байдаг. Эдгээр улсу үндэсний хөгжлийн стратегиа гаргаж түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө тууштай ажиллажээ. Улс орныхоо стратеги дээр суурилан компаниуд, муж улсууд, хотууд өөрсдийн стратегиа нийцүүлэн гаргасан байдаг. Жишээ нь, таван жилийн эдийн засгийн хөгжлийн стратеги АНУ-ын Washington DC дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Бизнес хамгийн таатай эдийн засаг
2. Худалдааны шүүрэлтийг зогсоох
3. Зүүн эрэг дэх технологийн хамгийн том төв
4. Тухайн ангилалдаа хамгийн сайн эрүүл мэндийн төв
5. Зорьж очдог сонголт болох
6. Гадаад хөрөнгө оруулагч, бизнес, жуулчдыг татах Хойд Америкийн тэргүүн хот болох
7. 100,000 шинэ ажлын байр, нэг тэрбум ам.долларын татварын орлого

Монголын хувьд одоог хүртэл бүх нийтээр хүлээн зөвшөөрч, судалгаа шинжилгээн дээр тулгуурлан боловруулагдсан цогц бодлогын баримт бичиг алга. Тиймээс төр бүх нийтийн хүчийг нэгдсэн зорилго руу хөтөлж, чиглүүлж чадахгүй байгаа юм. Нам, яам, хувийн хэвшил, ард иргэд бүгд тус бүрийн үзэл бодол, хүсэл эрмэлзэл дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулж байгаа ▶

► нь эцсийн нэгдсэн зорилгоо мэдэгхүй, ойлгоогүй, тул нэг алхам ахиж хоёр алхам ухарч байгаа мэт санагдана.

Саяхнаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төсөл яригдаж эхэлсэн бөгөөд уг хуулийн төсөлд Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн эрх зүйн үндсийг тодорхойлж, уялдааг хангах, хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах зарчмууд багтаж байгаа аж. Энэ хууль батлагдвал цаашид нэгдсэн стратегия боловсруулж батлах үүд нээгдэх нь.

## Бизнесийн зарчим №2 Харьцангуй давуу тал, өрсөлдөөн

Ширүүн өрсөлдөөн дунд бусдаас ялгаран гарах онцлог шинж, харьцангуй давуу тал бол бизнес удаан хугацаанд тогтвортой, ашигтай ажиллах үндсийг бүрдүүлдэг. Тэр нь үйлчилгээний чанар, үйлдвэрлэлийн үр ашигтай байдал, маркетингийн арга техник, найдвартай байдал гээд юу ч байж болно. Жишээлбэл, Apple компанийн давуу тал нь бүтээгдэхүүн болгон шинэлэг хэрнээ, энгийн, өндөр чанартай байлгаж чаддаг оршдог.

Тэгвэл Монголын давуу тал, бусад улс орноос ялгарах онцлог шинж чанар юу билээ? Үүнийг нарийн гаргаж ирж гадаад зах зээл дээр таниулснаар бид улсынхаа маркетингийг оновчтой хийж бусдаас илүү их хөрөнгө оруулалт татаж чадна. Монголын хувьд уудам газар нутаг, газар зүйн байршил, хоёр том зах зээлд ойрхон оршдог, залуу хүн амтай, зэвсэгт мөргөлдөөн, маргаан үгүй, ардчилсан нийгэм гээд тоочиж болно. Харин төрийн хувьд хувийн хэвшил болон хөрөнгө оруулагч нарт үйл ажиллагаа явуулахад таатай, шударга, тогтвортой орчин бүрдүүлэх нь ялгарах давуу тал бий болгох үндэс юм.

Монголын өрсөлдөх чадварын үнэлэн дүгнэсэн цөөнгүй судалгаа байдаг бөгөөд манай улс төдийлэн өндөрт жагсаж чадахгүй байгааг бид мэднэ. Тиймээс стратегия тодорхойлчихоод дараагийн хийх ёстой алхам бол өрсөлдөх чадвараа дээшлүүлэх явдал юм.

## Бизнесийн зарчим №3 Санхүү, мөнгөн урсгал

Бизнесийн амжилтын дараагийн чухал үзүүлэлт бол мөнгө, санхүүтэй шууд холбоотой. Орлого хэрхэн төвлөрүүлэх үү, үйл ажиллагааны үр ашгийг хэрхэн хамгийн өндөрт байлгах үү, мөнгөн урсгалын менежментийг хэрхэн оновчтой хийх, хэдэн төгрөгний хөрөнгө оруулалт хийгээд хэдэн төгрөгний ашиг олох, өнөөдрийн ашиг уу эсвэл ирээдүйн тогтвортой байдал уу зэрэг олон асуудал үүнд хамаарна. Мөн эдгээр асуудлыг хэрхэн шийдсэнээс компанийн ирээдүй үлэмж хамаарна. Монгол компаниуд орлого, зардлын асуудлыг харьцангуй сайн шийдэж чаддаг ч мөнгөн урсгалын төлөвлөлт, мөн хөрөнгө оруулалтын удирдлагад алдаа гарах нь их.

Төрийн хувьд санхүүгийн менежментийг ямар түвшинд хийж байгааг төсвийн гүйцэтгэл, төлбөрийн балансыг статистикаас харж болно.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийн нэгдсэн систем ч гүйцэд бүрэлдээгүй байна. Төрийн хөрөнгө оруулалтыг

- Санхүүгийн өгөөж авчрах төслүүд
- Санхүүгийн өгөөж өгөхгүй төслүүд гэж ангилж болох бөгөөд санхүүгийн өгөөж өгч чадахгүй төслүүдийн хувьд нийгэм эдийн засгийн үр өгөөж асар өндөр байх ёстой. Санхүүгийн болон эдийн засгийн үр ашгийг тооцооны үндсэн дээр хамгийн өндөр өгөөжтэйг авч хэрэгжүүлэх нь төрийн мөнгөөр шийдэгдэх төслүүдээс хамгийн сайныг сонгох боломж бүрдэнэ.

## Бизнесийн зарчим №4 Хүний нөөц

Бизнесийн хөдөлгөгч хүч, хамгийн чухал капитал нь хүний нөөц байдаг. Хүний нөөцийн удирдлага нь менежментийн урлагийн салшгүй нэг хэсэг мөн. Ажиллах хүчний тухайд үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлдэг. Энэ тогтолцоогоор дамжуулан цалин, урамшуулал, мөн үүрэг хариуцлагын асуудлыг тухайн ажилтны гүйцэтгэлтэй шууд уяж болдог. Жишээ нь, Америкийн том банкуудын захирлууд өндөр цалин, урамшуулал авдаг ч, банкны гүйцэтгэл муу байвал зохих хариуцлагаа шууд хүлээдэг.

Манай төрийн албан хаагчдын хувьд цалин бага гэдэг нэрийдлээр ажил үүргээ сайн хийх, цаашилбал хариуцлага хүлээх соёл бараг байдаггүй. Ингэснээр үр ашиггүй зардал өндөр, ажлын гүйцэтгэл ч сул байна. Төр нэг төгрөг зарцуулаад хэдэн төгрөг олж байгаагаас нь төрийн албаны үр ашигт ажиллагааг тодорхойлж болох байх, харамсалтай нь сүүлийн жилүүдэд төсөв алдагдалтай гарч байгааг бид мэднэ.

## Дүгнэлт

Иймэрхүү байдлаар бизнес, хувийн салбараас авч хэрэгжүүлэх зарчим олон бий. Тухайлбал, манлайлал, харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүний шийдэл зэргийг нэрлэж болно. Эдгээрийг авч хэрэгжүүлж чадвал “төр муу менежер” гэдэг ойлголтоос салж чадна.

Харамсалтай нь гэх үү, эмгэнэлтэй нь гэх үү дэлхий нийтийн давамгайл сонгож хэрэгжүүлж буй зах зээлийн эдийн засагт үнэгүй юм гэж байдаггүй. Хэн нэгэн хэзээ нэгэн цагт заавал төлж таардаг. Төр биш бол татвар төлөгч төлж таарна, одоо үе биш бол хойч үе төлнө. Тиймээс бизнесийн үр ашиг, ашигт ажиллагааны зарчмыг төрийн салбарт түлхүү нэвтрүүлбэл хямралаас зайлсхийж, ухаалаг төрийн үндэс зөв тавигдаж, урт хугацаанд тогтвортой эдийн засагтай болох болов уу. ■

## БОДЛОГЫН СУДАЛГАА

# ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

МУИС-ийн дэргэдэх Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс энэ сард бэлтгэн гаргасан “Үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн харьцуулсан судалгаа”-г хүргэж байна. Энэхүү судалгааг тус хүрээлэнгийн судлаач Д.Эрдэнэбулган боловсруулжээ.

Зарим улс орны эдийн засаг яагаад хоцорч байхад зарим нь хөгжлөөрөө тэргүүлдэг талаар олон эмпирик судалгаа хийгдсэн байдаг. Улс орны хөгжлийн түвшин нь эдийн засаг, улс төрийн институцын боловсронгуй байдлаас шалтгаалдаг гэдэг дээр олон судлаач санал нэгддэг. Манай улстай ижил төстэй, уул уурхайд түшиглэдэг улсуудаас амжилттай хөгжиж чадсан жишээ бол Чили, Ботсвана юм. Чилийн гол экспортын бүтээгдэхүүн нь зэс, харин Ботсванийнх алмааз эрдэнэ.

Эдгээр улсын туршлагаас ажиглагдсан нийтлэг зүйл бол залуу үеийнхээ боловсролд анхаарч, их хэмжээний хөрөнгө оруулж, тэднийгээ “хөгжлийн гол хөдөлгөх хүч” болгосон явдал юм. Түүнчлэн, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдөж байсан ч улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогууд нь тогтвортой, тууштай байсан. Үүнээс гадна иргэдийн эх оронч үзэл санаа, улс төрийн намуудын өндөр ёс суртахуун, хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх үүрэгтэй тусдаа бие даасан нэгжүүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Д.Асэмоглу, Ж.Робинсон (D.Acemoglu and J.Robinson 2008), В.Ж.Хафф (W.J.Huff 1995), В.Скалли (Scully 1988), Т.Растин (Rastin 2003) зэрэг



эрдэмтдийн эмпирик болон онолын судалгааны үр дүнгээс харахад улс орнуудын хөгжлийн түвшин нь тухайн орны эдийн засаг, улс төрийн институцаас хамаардаг байна. Т.Растин судалгаандаа Сингапур улс капиталист эдийн засгийн загварыг сонгосноороо хэрхэн хурдацтай өсөлтөд хүрснийг харуулсан бол В.Скалли судалгаандаа эдийн засгийн хөгжил нь тухайн улсын институцын тогтолцооноос хүчтэй хамаардаг болохыг харуулжээ. Тодруулбал, хуульд өөрчлөлт оруулах, хувийн өмчтэй болох, зах зээлийн нөөцийн хуваарилалтад санал бодлоо тусгах улс төрийн эрх чөлөөтэй улс орныг улс төрийн эрх чөлөөгүй улст оронтой харьцуулахад эдийн засгийн өсөлтийн хурд гурав дахин, үр ашиг 1.5-2 дахин их байгааг 115 улсын 1960 – 1980 оны тоон мэдээлэл ашиглан харуулсан.

В.Ж.Хафф 1960 оноос хойш Сингапур улсыг эдийн засгийн өндөр өсөлтөд хүргэсэн чухал хүчин зүйл болох Засгийн газрын үүрэг оролцоог Тайвань, БНСУ болон Азийн бусад улс оронтой харьцуулан шинжилжээ. Д.Асэмоглу, Ж.Робинсон нар Латин Америкийн зарим улсын эдийн засгийн түүхэн тоон мэдээллийг судлаад, урт хугацааны эдийн засгийн өсөлтөд эдийн засгийн институц нь улс төрийн институцаас илүү чухал нөлөөтэй болохыг харуулсан. Институц гэдэг нь нийгмийн оролцогчдын харилцан үйлдлийн хөшүүрэг, хязгаарлаж

зохицуулах дүрэм журам юм.

Манай улсын хувьд “Мянганы хөгжлийн зорилт” –д суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” –ыг 2007–2008 онд боловсруулсан боловч уг хөтөлбөр тунхгийн шинжтэй болжээ. Цаашид манай улс уул уурхайн баялагтаа тулгуурлан амжилттайгаар тогтвортой хөгжихийн тулд, өөрийн оронтой эдийн засгийн хөгжлийн суурь нөхцөлийн хувьд ойролцоо, амжилттай хөгжиж, ядуу буурай орноос хөгжингүй орон болж чадсан бусад орны туршлагыг судалж, тэдний туршлага, ноу-хаугаас өөрийн оронд хэрэгтэй зүйлсийг тусгаж авах хэрэгтэй юм. Мөн дунд болон урт хугацааны үндэсний хөгжлийн нэгдмэл бодлогоо тодорхойлон боловсруулж, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх явдал туйлын чухал болоод байгаа билээ. Сүүлийн жилүүдэд улс орнууд социалист, капиталист системийн аль нэгийг шууд сонголтгүйгээр, энэ хоёр системийн давуу талуудыг оновчтой хослуулан, эдийн засгийн хөгжлийн загвараа боловсруулахыг өөр өөрийн арга барилаар оролдох болсон. Үүнийг амжилттай хослуулаж чадсан улсын нэг Сингапур. Тус улсын Ерөнхий сайд асан Ли Куан (Lee Kuan) “1965 онд Танд ямар нэгэн хөгжлийн загвар байсан уу?” гэсэн сэтгүүлчийн асуултад “Үгүй ээ, би Хонгонг, Швейцарь, Израйл юу хийж байсан туршлагыг судалж, хэрэгтэй зүйлсүүдийг тусгаж авсан л төдий” хэмээн хариулсан нь чухамхүү энэ хоёр туйлын хувилбарын оновчтой хослолыг өөрийн орны хувьд олохыг эрэлхийлж байсныг илтгэж байгаа юм.

Сингапурын хөгжлийн нууц бол капиталист зах зээлд төрийн оролцооны оновчтой хүрээг тодорхойлж, Засгийн газрын дунд болон урт хугацааны бодлогыг ▶

► дагаж мөрдөж чадсанд оршдог гэж В.Ж.Хафф (1995) дүгнэжээ. В.Ж.Хаффын судалгаанаас үзвэл Сингапур улсын хурдацтай өсөлт дараах хэдэн хүчин зүйлээс шалтгаалсан. Үүнд, Засгийн газрын зүгээс хөдөлмөрийн зах зээлд хийсэн зохицуулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжсэн. Иргэдээ мөнгөн хуримтлалтай болохыг дэмжсэн бодлогууд, мөн төрийн өмчит компаниудын оновчтой менежментийг тодорхойлох, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зэрэг бодлогыг дурдсан байна. Мөн эдийн засаг, улс төрийн шийдвэрүүдийг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролтой “элит бүлэг” (elite group) гаргаж байжээ. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хөгжилд эдийн засаг, улс төрийн институцээс гадна боловсролтой, манлайлагч, элит бүлгийн үүрэг оролцоо чухал байсан бөгөөд үүгээрээ БНСУ, Тайвань зэрэг улсын туршлагатай адил байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Хэдийгээр сайн институцыг сонгосон ч тухайн институц тогтворгүй байвал эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрч чадахгүй. Иймд тухайн улсын хөгжил эдийн засгийн институцын тогтвортой байдал, түүний тогтолцооноос ихээхэн хамаардаг. Урт хугацааны эдийн засгийн институцын тогтвортой байдал улс төрийн институцын өөрчлөлтөөс үл хамааран эдийн засгийн өндөр хөгжилд хүргэж болохыг Д.Асэмоглу, Ж.Робинсон (2008) нар Латин Америкийн зарим улсын жишээн дээр харуулсан. Зах зээлийн эдийн засгийн зарчмаар амжилттай хөгжиж, ядуу буурай орноос хөгжингүй орон болж чадсан бодит жишээ цөөнгүй байна. Үүнд, Япон, БНСУ, Тайвань, Сингапур, Өмнөд Африк, Ботсвана, Чили зэрэг улсыг дурдаж болно. Эдгээрээс эдийн засгийн хөгжлийн суурь нөхцөлийн хувьд манай улстай ойролцоо орнууд болох Ботсвана, Чили улсын туршлагаас сонирхуулъя.

Ботсвана улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь алмааз бөгөөд улс төрийн олон намт тогтолцоотой. Байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжиж байгаа ардчилсан орон юм. 2011 онд нийт экспорт (5,882 сая ам.доллар)-ын 75.6%-ыг алмааз бүрдүүлсэн ба 2010

оныхтой харьцуулахад алмаазын экспорт 24.8 хувиар өсчээ. Алмаазын Дэбсвана (Debswana) ордыг тус улсын засгийн газар болон алмаазын гол худалдаалагч Дэ Бийр (De Beer) компани 50/50 хувиар хуваан эзэмшихээр гэрээ хийсэн байдаг.

1966 онд тусгаар тогтнолоо зарласнаас хойш, тус улсад нэг нам буюу Ардчилсан нам нь засгийн эрх барьж байгаа бөгөөд улсынхаа эдийн засгийн болон үндэсний хөгжлийн бодлогоо тогтвортой байлгаж, тууштай хэрэгжүүлж чадсан тул нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь 1966 онд 70 ам.доллар байсан бол 2013 оны байдлаар 6500 ам.доллар болж өсчээ. Ингэж, эдийн засгийн өндөр өсөлтөд хүрэхэд нөлөөлсөн чухал хүчин зүйлс бол дэд бүтэц, боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг ихээр хийж ирсэн нь явдал юм.

Харин эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь зэс, алт зэрэг байгалийн баялаг болох Чили улс манай улстай харьцуулахад олон хүн амтай /16.6 сая/ бөгөөд улс төрийн олон намын системтэй, зах зээлийн эдийн засагтай ардчилсан улс юм. Чилийн засгийн газар зэсийн томоохон экспортлогч болох Коделко /Codelco/ компанийг эзэмшидэг бөгөөд 2007 онд улсын төсөвт 35 тэрбум ам.долларын /1994 оноос хойш хамгийн их/ орлого төвлөрүүлжээ. 2008-2011 онуудад тус компани жилд дунджаар 21.5 тэрбум ам.долларын орлого улсынхаа төсөвт төвлөрүүлжээ. Тус улс хөгжлийн бодлогоо тогтвортой байлгаж, тууштай хэрэгжүүлснээр амжилттай хөгжиж буй. Эдний нэг хүнд ногдох ДНБ дунджаар 1960-1970 оны хооронд 2732 ам.доллар /2005 оны суурь үнээр/ байсан бол 2001-2012 онд 7782 ам.доллар /2005 оны суурь үнээр/ болж өссөн байна /Дэлхийн банкны 1960-2012 он хүртлэх тоо мэдээлэлийг ашиглав/.

Амжилттай хөгжлийн гол суурь нь өндөр боловсролтой элит давхаргыг /Чикагогийн явгүүд гэдэх/ бий болгосон явдал бөгөөд, залуу үеийнхээ боловсролын салбарт ихээхэн хөрөнгө оруулж, тэднийгээ “хөгжлийн гол хөдөлгөгч хүч” болгосноор ухаалаг бодлого хэрэгжүүлж, бодлогын залгамж чанараа хадгалж чадаж байна.

Уул уурхайн баялагтаа тулгуурлан амжилттай хөгжсөн дээрх хоёр орны хөгжлийн замнал, туршлага, үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлт зэргийг судалж үзэхэд амжилт олоход дараах нийтлэг суурь нөхцөлүүд нөлөөлсөн байна.

Нэгдүгээрт, улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, шийдвэр гаргахад өндөр боловсролтой залуу боловсон хүчин чухал үүрэгтэй оролцсон.

Хоёрдугаарт, төрийн болон эдийн засгийн бодлого нь улс төрийн нөлөөллөөс ангид, тухайн нөхцөл байдлаас шалтгаалж тууштай байдал нь алдагдаагүй.

Гуравдугаарт, эдгээр улсын эдийн засагт төрийн бодлогоор дэмжсэн оролцоо идэвхитэй байсан.

Энэ хоёр орны улс төр, эдийн засгийн гол шийдвэрийг өндөр боловсролтой давхаргын тодорхойлж байснаас гадна, судалгаа эрдэм шинжилгээний байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд нь үндэсний хөгжлийн бодлого боловсруулах, түүнийг тууштай хэрэгжүүлэхэд идэвхтэй, чухал хувь нэмэр оруулж иржээ. Бодлогын тогтвортой, тууштай байдлыг хангахад улс төрийн намууд болон гүйцэтгэх засаглал дахь чадварлаг боловсон хүчин маш чухал хүчин зүйл болдог аж.

Манай орны хувьд эдгээр орны туршлага сургамжтай хэдий ч шууд хуулбарлан дуурайх нь өрөөсгөл шийдэл болно. Бодлого төлөвлөлтийг улс төрийн намуудын нийтлэг зорилгод үйлчилдэг байхаар тодорхойлох, эргээд энэхүү төлөвлөлтийг аль ч нам нь тууштай хэрэгжүүлдэг байхад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь зүйтэй юм. Тиймээс хөгжлийн бодлогын талаар улс төрийн нэгдмэл ойлголцолд хүрэх нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн эхний бөгөөд шийдвэрлэх алхам болох юм. Цаашилбал, бодлогын залгамж халааг хадгалахын тулд улс төрийн намуудад болоод гүйцэтгэх засаглалд ажиллах боловсон хүчнийг илүү чадавхижуулах шаардлага тулгарах болно. Чадвартай боловсон хүчнээр байнга шинэчлэгдэж, баяжиж байж бидний дээр хэлэлцсэн бодлогын төлөвлөлт хэрэгжиж, бодлогын залгамж халаа хадгалагдах юм. ■



## ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛД

НИЙЛҮҮЛЭЛТ, ТҮҮНД  
НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

Энэ удаагийн булангаар микро эдийн засгийн үндсэн ухагдахууны нэг болох бүтээгдэхүүний нийлүүлэлт, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар авч үзнэ.

**Нийлүүлэлт хийгдэх үндсэн**

**нөхцөл.** Бүтээгдэхүүний зах зээл дээр нийлүүлэлтийг пүүсүүд хийдэг. Пүүсүүд бүтээгдэхүүнийг нийлүүлэхийн тулд

1. Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эдийн засгийн нөөц буюу газар, капитал, хөдөлмөртэй байх
2. Тодорхой бүтээгдэхүүнийг бий болгох өөрийн технологитой байх
3. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалтай байх
4. Үйлдвэрлэл явуулахдаа ашиг олох сонирхолтой байх
5. Үйлдвэрлэх болон зарж борлуулах төлөвлөгөөтэй байх гэсэн шаардлагуудыг хангах ёстой.

Нөөц болон технологи нь юу үйлдвэрлэх боломжтойг тодорхойлдог. Нийлүүлэлт нь технологийн ямар боломжийг ашиглан үйлдвэрлэл явуулах вэ гэдэг шийдвэрийг өөртөө тусгасан байдаг. Тодорхой хугацаанд, тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд, тодорхой үнийн түвшинд худалдан борлуулахаар төлөвлөж


буй бүтээгдэхүүний хэмжээг сонгосон бүтээгдэхүүний нийлүүлэлт тоо хэмжээ гэнэ. Нийлүүлэлт нь борлуулсан тоо хэмжээтэйгээ тэнцүү байх албагүй. Учир нь пүүс тодорхой нөхцөлд төлөвлөлтийг хийж бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг хэдий ч нийлүүлэлтийг хийх хугацааны хожимдлоос шалтгаалан эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс төлөвлөсөн хэмжээгээр борлогдохгүй байх талтай.

**Нийлүүлэлтийн тоо хэмжээ ба нийлүүлэлтийн муруй.**

“Борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлөгч үнийн бус бусад хүчин зүйлс тогтмол байхад” бүтээгдэхүүний үнэ өндөр байх тусам нийлүүлэлтийн тоо хэмжээ төдий чинээ их байх эсвэл бүтээгдэхүүний үнэ бага байхад нийлүүлэлтийн тоо хэмжээ төдий чинээ бага байх зүй тогтлыг нийлүүлэлтийн хууль гэнэ.

Энэ хууль нь ахиу зардлын өсөлттэй холбоотой. Пүүс нэмж нэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нэмж гарч байгаа зардлыг бүтээгдэхүүний тухайн нэгжийн ахиу зардал гэдэг. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх тоо хэмжээ нэмэгдэх тусам тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ахиу зардал нэмэгддэг. Учир нь илүү их бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд түүхий эд материалыг илүү ихээр нөөцлөх шаардлагатай тул агуулах, тээврийн зардал нэмэгддэг. Мөн хөдөлмөр, капиталаа ч нэмэгдүүлэх хэрэгцээ гардаг нь зардлыг өсгөдөг.

Нийлүүлэлтийн муруй нь үйлдвэрлэгчийн “борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлөгч үнийн бус бусад хүчин зүйлс тогтмол байхад” бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тоо хэмжээ ба үнийн хоорондын харилцан хамаарлыг харуулдаг. Нийлүүлэлтийн муруй нь хамгийн бага үнийн муруйг мөн илэрхийлдэг. Үйлдвэрлэх тоо хэмжээ нэмэгдэх тусам ахиу зардал өсдгийг өмнө дурьдсан. Иймээс үйлдвэрлэгчийн нэмэлт нэг нэгжийг зарах хүсэлтэй байгаа хамгийн бага үнэ өсдөг. Тиймээс энэхүү хамгийн бага үнэ нь ахиу зардал болно. Нийлүүлэлтийн муруйг дараах байдлаар дүрслэн үзүүлдэг.



Нийлүүлэлтийн муруй нь тодорхой хэмжээний нийлүүлэлтийг хийхэд үйлдвэрлэгчийн зүгээс санал болгох хамгийн доод үнийг тусган харуулдаг. Өөрөөр хэлбэл, пүүсүүд нийлүүлэлтийн муруй дээрх үнээс ▶

► илүү үнээр бүтээгдэхүүнээ борлуулах эрмэлзэлтэй байдаг.

**Нийлүүлэлтэд буюу борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлдөг үнийн бус хүчин зүйлсийн нөлөө.**

Бүтээгдэхүүний нийлүүлэлтийг өөрчлөлт дараах хүчин зүйлсээс хамаардаг. Үүнд:

- Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн үнэ буюу нөөцийн үнэ
- Түүхий эд, материалын үнэ
- Бусад бүтээгдэхүүний үнэ
- Хүлээгдэж буй үнэ
- Технологи
- Нийлүүлэгчийн тоо

Борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлдөг үнээс бусад хүчин зүйлсээс аль нэг нь өөрчлөгдөхөд нийлүүлэлт өөрчлөгддөг. Үйлдвэрлэгчийн худалдахаар төлөвлөж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ харгалзах үнийн түвшин бүрт өөрчлөгдөж шинэ нийлүүлэлтийн муруй бий болно. Нийлүүлэлт нэмэгдэхэд нийлүүлэлтийн муруй баруун гар тийш, харин багасахад зүүн гар тийш шилждэг.

Нөөцийн үнийн өсөлт. Хэрэв бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглагдаж буй хөдөлмөрийн үнэ цалин, капиталын үнэ түрээс, газрын үнэ рент өсвөл нэмэлт нэгж бүтээгдэхүүний хамгийн бага үнэ өснө. Иймээс нөөцийн үнийн өсөлт нийлүүлэлтийг багасгаж, нийлүүлэлтийн муруй зүүн гар тийш шилждэг.

Түүхий эд материалын үнэ. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд оролцож буй түүхий эд, материалын үнэ өсөх нь бүтээгдэхүүний өөрийн өртгийг нэмэгдүүлж, үнэ өсөх шалтгаан болно. Үүнээс үүдэн үйлдвэрлэлийн зардалтай холбоотой нийлүүлэлт багасдаг.

Бусад бүтээгдэхүүний үнэ. Тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн орлох бүтээгдэхүүн гэдэг нь нэгэн ижил нөөцийг ашиглан үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнийг хэлнэ. Тухайлбал улаан буудай, рапс нь үйлдвэрлэлийн орлох бүтээгдэхүүн юм. Хэрэв үйлдвэрлэлийн орлох

бүтээгдэхүүний үнэ буурвал пүүс үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ нийлүүлэлтийг өсгөдөг. Улаан буудайн үнэ буурч рапсийн үнэ нэмэгдвэл, тариаланчид буудай тариалах талбайдаа рапс тариалах болно. Хэрвээ бүтээгдэхүүнүүд нь хамтдаа үйлдвэрлэгддэг бол үйлдвэрлэлийн хавсарга бүтээгдэхүүн гэнэ. Хавсарга бүтээгдэхүүний үнэ өсвөл тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлт ихэснэ.


Хүлээгдэж буй ирээдүйн үнэ. Хэрэв нийлүүлэгчид бүтээгдэхүүний үнэ ирээдүйд өснө гэж хүлээж байгаа бол өнөөдөр нийлүүлэлтээ бууруулж, нийлүүлэлтийн муруй зүүн тийш шилжинэ. Жишээ нь маргааш бензиний үнэ нэмэгдэх нь тодорхой болбол шатахуун түгээгч нар нийлүүлж байсан шатахууны хэмжээгээ өнөөдөр аль болох багасгаж, дараа өдөр илүү ихийг борлуулахыг эрмэлзэнэ.

Технологи. Технологийн дэвшил нь бүтээмжийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зардлыг бууруулдаг. Өөрөөр хэлбэл нэгж хугацаанд илүү олон бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой болж, нийлүүлэлт нэмэгдэж, нийлүүлэлтийн муруй баруун тийш шилжинэ. Байгалийн гамшиг, хил гааль хаах, эдийн засгийн хориг арга хэмжээ зэрэг нь технологийн сөрөг өөрчлөлт гэж үзнэ. Эдгээр нь нийлүүлэлтийг бууруулдаг.

Нийлүүлэгчийн тоо. Өмнө авч үзсэн хүчин зүйлс нь тухайн нэг пүүсийн шийдвэр гаргалттай холбоотой

яригддаг бол нийлүүлэгчийн тоо нь зах зээлийн нийлүүлэлтийг тодорхойлдог. Нийлүүлэгчийн тоо олон болох тусам тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлт өснө. Нийлүүлэгчийн тооны өсөлт нь нийлүүлэлтийн муруйг баруун тийш шилжүүлнэ. Нийлүүлэгчийн тоо нь зах зээлийн өрсөлдөөнийг тодорхойлогч гол үзүүлэлт юм. Тухайлбал бүтээгдэхүүнийг цор ганц пүүс нийлүүлж байвал тэр пүүс нь монополь пүүс болно.

Нийлүүлэлтийн муруйн дагуух шилжилт. Борлуулалтын төлөвлөлтөд нөлөөлөгч үнийн бус бусад хүчин зүйлс тогтмол байхад тухайн бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөхөд нийлүүлэлтийн тоо хэмжээ өөрчлөгдөж нийлүүлэлтийн муруйн дагуу шилжилт хийнэ. Тухайлбал үнэ өсөхөд нийлүүлэлт дагаад нэмэгддэг. Үнийн өсөлт нь нийлүүлэлтийг урамшуулдаг. Үйлдвэрлэгчид илүү их орлого, ашиг олох бололцоо бий болдог.



**Нийлүүлэлтийн муруйн шилжилт.**

Хэрэв үнэ өөрчлөгдөөгүй нөхцөлд борлуулалтад нөлөөлөгч үнийн бус бусад хүчин зүйлс өөрчлөгдвөл нийлүүлэлт өөрчлөгдөж, нийлүүлэлтийн муруй бүхэлдээ шилжинэ. Тухайлбал бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аль нэгэн салбарт технологийн дэвшил гарвал, нэгж хугацаанд тухайн салбарын пүүсүүд өмнөхөөсөө илүү бага зардлаар илүү их бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж нийлүүлэх бололцоотой болно. Цалин нэмэгдэх нь үйлдвэрлэлийн зардлыг ихэсгэх тул үнийг өсгөх шалтгаан болж, нийлүүлэлтийн муруй зүүн гар тийш шилжин, нийлүүлэлт буурна. ■



## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

# НОЁН ДОЛЛАРЫГ НОГТОЛЖ ЧАДАХ УУ?

“Mongolian Economy” сэтгүүлийн дэргэдэх “Economy” телевизийн студи ээлжит нэвтрүүлгээ ам.долларын ханшийн өсөлтийн шалтгаан юу болох, үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ, гарц шийдэл нь юу байх вэ гэсэн асуудлаар эдийн засагч, бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг өрнүүллээ. Хэлэлцүүлэгт эдийн засагч Д.Жаргалсайхан, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Эрдэнэбат, “Сэргэн мандалт” группийн ерөнхийлөгч Ч.Төмөрчулуу, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын төвийн судлаач ,,,,,,нар уригдан оролцсон. Тус хэлэлцүүлгийг сэтгүүлдээ товчлон буулгаж байна.

## Д.Жаргалсайхан: Монгол Улс социализм руу явж байна



**-Валютын ханш өсөөд байгаа үндсэн шалтгаан юу юм бол. Энэ нь юуг илтгэж харуулаад байна вэ?**

**-Д.Жаргалсайхан:** Би энэ тухай “Долларыг ялах долоон алхам” гэж нийтлэл бичихдээ хөндлөнгийн болон улс төрийн биш байр сууринаас ажиглаж ханш өсөх гурван шалтгаан байна гэж үзсэн. **Нэгдүгээрт**, суурь шалтгаан бий. Монгол Улс зах



Зүүн гар талаас Б.Эрдэнэбат, Д.Жаргалсайхан, Ч.Төмөрчулуу, Ч.Ганбат. 2014 03.11

зээлийн нийгмээс социализм руу явж байна. Төрийн компани олноор байгуулж байна. Төсвийн мөнгө тэдний алдагдлыг нөхөж байгаа болохоос биш, шаардлагатай зүйл рүүгээ чиглэхгүй байгаа учраас ийм байдалд хүрсэн. Харамсалтай нь Ардчилсан нам төрийн эрх барьж байгаа энэ үед Монгол Улс улам илүү социализмд шилжиж байгаа нь сонин хувь заяаны шоглол болж байгаа юм. **Хоёрдугаарт**, төр улам томорч, төрийн компаниуд олширч хүмүүс хувийн секторт ажиллах сонирхолгүй болж байна. Хувийн секторт ажиллана гэдэг бол үндсэндээ шийтгэл болж хувирлаа. Улсын секторт ажиллаж байгаа бол хөнгөлөлттэй байр авах гэх мэт боломж их байгаад учир бий. **Гуравдугаарт**, Төр бодлогогүй ажиллаж байна. Зөвхөн мөнгө олох нь чухал болохоос, олсон мөнгөө хэрхэн зарцуулах вэ гэдэг нь тэдэнд сонин биш байна. Үүнийг

бондын шийдвэрүүд харуулж байна. Хэрэглээний гол бараа цахилгаан эрчим хүч, ус, шатахуун, мах, гурил, будааны үнийг зах зээл биш Засгийн газрын шийдвэрээр тогтоож байгаа учраас бид хэзээ нэгэн цагт яг ийм байдалд хүрэх ёстой байсан. Үүнд хүргэхгүй байсан жийрэг бол уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн өндөр үнэ байсан юм. Харин ханш буурахаар хөлөг онгоц шиг усанд живчихэж байгаа юм.

**-Б.Эрдэнэбат:** Уул уурхайн эдийн засаг гэдэг бол ердийн эдийн засагтай харьцуулбал маш савалгаатай. Байгалийн баялагтай улс бол нэг талаар давуу талтай. Нөгөө талаас сөрөг зүйлс гарч ирдэг. Жишээлэхэд, институцийн чадавхид нөлөөлдөг. Хүмүүс хоорондоо хамтран ажиллах, зөв зүйлээ дэмжиж, бурууг илрүүлж, зогсоох механизмыг эдийн засагчид институц гэж нэрлэдэг. Эдийн ▶

Фотог Э.Зоригт

засагчид ямар улс сэргэж, ямар улс мөхөж байна вэ гэдгийг институц хэр хөгжсөнөөр нь тодорхойлдог. Үүнд байгалийн баялаг, далайд гарцтай эсэх нь огт хамаагүй. Одоогоор хамгийн сайн хөгжсөн нь Баруун европ болоод байна. Харин байгалийн баялаг бол хөдөлмөрлөж олоогүй ашгийг бий болгож байгаа юм. Энэ мэт олон зүйлийг хэлж болно. Валютын ханш өөрчлөгдөөд байна гэдэг нь тухайн улсын эдийн засаг маш их савалгаатай байгааг харуулж байгаа юм. Өнөөдөр тоглоомын дүрэм өөр болсон гэдгийг ойлгох хэрэгтэй. Монгол Улсын эдийн засагт уул уурхай түүхэндээ ийм өндөр нөлөөтэй байгаагүй. Бид одоо түүхий эдийн валюттай улс гэдэг ангилалд орчихлоо. Экспортын орлогын дийлэнх хэсгийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлдэг улс энэ ангилалд хамаардаг. Канад, Чили Австрали, ОХУ ч үүнд орно. Эдгээр улстай бид бодлогоо харьцуулж үзэх хэрэгтэй. Тэд валютын ханшийн бодлогоо хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдгийг судлахад илүүдэхгүй. Ханшаа тогтмол байдлаар механикаар барих арга байна.

## Б.Эрдэнбат: Манай улс айхтар ган зуд, шуургатай нутагт орж ирлээ



**-2008 онд манайх ханшаа механикаар барьж үзсэн биз дээ.**

-Тэгсэн. Энэ үед Төвбанкнаас интервенц хийсэн. Тухайн үедээ валютын нөөцийнхөө 50 хувийг алдсан. Нэг тэрбум ам.долларын албан нөөцтэй байдаг байсан. Олон улсын валютын сангаас "Stand by" хөтөлбөр гуйсан. Тус олон улсын байгууллагын өмнө хормой дэвсэж гуйсан тоогоороо манай улс 1991-2008 он гэхэд дөрвөн удаа болсон. Энэ байдлаараа дэлхийд тэргүүлж байна шүү дээ. Одоо бидэнд хариуцлага чухал. Төвбанкны бие

даасан байдал хэрэгтэй. Өнөөдөр олигтой явж байгаа Төвбанкууд бүгд улс төр, бизнесээс хараат бус байдаг. Австрали Канадын төвбанк дэлхийн эдийн засгийн төлөв байдлыг ажиглаад сууж байдаг. Өөрчлөлт орлоо гэхэд урьдчилаад мэдээлж чаддаг. Ингэснээр бизнес эрхлэгчид болон эдийн засагт оролцогчид урьдчилан арга хэмжээ авдаг. Түүхий эдийн эдийн засагтай улсад ийм сэрэмж хэрэгтэй. Төвбанк энэ үүргээ биелүүлэх ёстой. Манайх одоо бол бүх юм болно гэж амлаад байдаг. Харин болохоо байхаар амлаад байсан хүмүүс нь алга болчихдог.

**-Дэлхийн зах зээл дээр ойрын үед нүүрсний үнэ сэргэх хандлага байхгүй байгаа. Тэгэхээр манайх эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хэрхэн сайжруулах арга хэмжээ авах вэ. Эрдэнэбат багшийн хэлсэн Stand by хөтөлбөрийг дахиад ОУВС-гаас авах уу?**

-Д.Жаргалсайхан: 2009 онд 250 сая долларын түр амь аврах зээл авсан. Энэ гэрээгээр төсвийн алдагдлаа нөхөөд явсан. Гэхдээ ингээд бид сайндаа хямралаас гарсан юм биш. Түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр өсөөд аяндаа хямралаас гарчихсан. Гэтэл тухайн үеийн төр засгийн удирдлагууд бид хийчлээ, хямралаас гарчихлаа гэж байсан. Харин тухайн үед хийх ёстой байсан төртэй холбоотой бүтцийн өөрчлөлтийг бүрэн хийж чадаагүй. Үнээ чөлөөлж чадаагүй. Тэр үед Засгийн газрын тогтоол гараад цахилгааныг үнийг аажмаар чөлөөлнө гэж байсан. Гэтэл тэрийгээ хийгээгүй. Харин үр дүнд нь гинжин урвалаар алдагдалтай болсоор байгаад төрийн секторын зардлыг төсвөөрөө нөхөөд явчихсан.

Энэ удаад дахиад л Олон улсын валютын сангаас өмнөхөөсөө ч их мөнгө авахаас өөр аргагүй болох байх. Хэдийгээр Хятадын нүүрсний импорт буурахгүй ч гэлээ нүүрс экспортлогч орон олон болсон. Манайхаас хямд зардлаар Хятад руу нүүрсээ нийлүүлж байна. Тэгэхээр бидэнд тэдэнтэй өрсөлдөх чадвар байхгүй. Монголын Засгийн газар ОУВС-гаас зээлжих эрхийн хэмжээгээ 50 гаруй саяар нэмэгдүүлжээ гэсэн хүсэлтээ УИХ-д өгсөн байна. Ингэхээр ОУВС-гаас тав дахь удаагаа зээл авч магадгүй байна.

Энэ удаад тус байгууллагаас тавих нөхцөл чангарах байх. Тэдний зүгээс тавих нэгдүгээр нөхцөл нь, Хөгжлийн банкаар дамжиж байгаа мөнгийг улсынхаа төсвөөр явуулаачээ гэх байх. Өнөөдөр Монгол Улс үндсэндээ албан ёсны ба албан бус гэсэн хоёр төсөвтэй болчихоод байна. Хоёр дахь нөхцөл нь, Төвbankыг Засгийн газартайгаа нийлээд битгий мөнгө хэвлээд гаргаад байгаа ч гэж хэлэх болов уу.

**-Долларын ханшийн өсөлт бизнес эрхлэгчдэд нэлээд дарамт болж байна. Үүнээс гарах боломж байна уу?**

**-Б.Төмөрчулуу:** Монголчууд энэ сэдвээр дэндүү их ярьж байна. Ялангуяа Монголбанк төсөөлөл их ярьж байна. Үүнийгээ болих хэрэгтэй. Одоо бид авч болох шуурхай арга хэмжээгээ л авах ёстой. Мэдлэг туршлага, хүмүүсийн хүч дэмээр хийх ажлаа шуурхайлмаар байна. Гэтэл хуулиар нарийн авч үзвэл гарц бий. Тус ухаалаг, мэдлэгт суурилсан алхмуудыг хиймээр байна. Статистикийн газраас гаргасан тоон хавтгай дээр Монгол Улс цэгцрээд чамбайраад байдаг. Бодит амьдрал дээр иргэдийн хэтэвчин дэх мөнгө нэмэгдсэн зүйл огт байхгүй. Үүний хамгийн том шалтгаан нь бидэнд мэдлэг туршлага дутаж байна. Сэтгэл дутаж байна. Монголбанк бүх хүчээ дайчлан ажиллах хэрэгтэй. Монгол Улсын орц гарцын харьцаа алдагдчихаад байна. Маш их зүйл манайд орж ирээд байна. Эргээд гардаг нь цөөхөн. Одоо бид юуг гаргаж болох вэ гэдгээ бодох хэрэгтэй. Олон сая малаас гарах бүтээгдэхүүнээ борлуулмаар.

**-Монголбанкинд интервенц хийхээс гадна ханш тогтворжуулах ямар арга байж болох вэ?**

-Өнөөдөр гол итгэл найдвар бол хувийн хэвшлийнхэнд байна. Засгийн газар өнөөдөр бичгийн цаас л авах мөнгөө үлдээж хэмнэлттэй ажиллах хэрэгтэй. Одоо л улс орныхоо эдийн засгийг чадавхжуулж авахгүй юм бол арван жилийн дараа ч ийм ярилцлага дахиад л болоод сууж байна байх.

Төвбанкны өнөөдөр ганц хийж чадаж байгаа нь доллараа зарах. Айлын эрх хүүхэд авдраасаа мөнгөн аяга аваад зарж байгаа юм шиг. Ингээд болдог гэсэн ойлголт өнгөрчихөөд байна. ▶



► **Ч.Ганбат:** Төвбанкинд валютын ханшийг тогтворжуулахад интервенц хийхээс гадна авч болох нэг бус арга хэмжээ байдаг. 2008 онд мөнгөний бодлогын хүүг өсөн хувиас 14 хувь болтол өсгөсөн. Мөн арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх гэх мэт арга байдаг. Валютын ханш өснө гэдэг манайд төгрөг их, харин долларын нийлүүлэлт бага байгаагаас л үүсээд байгаа юм. Тиймээс валют орж гарах урсгалаа тэнцвэржүүлж ханшийн өсөлтийн эсрэг арга хэмжээ авч болно. Цаашид бид дотоодын үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, импортыг бууруулах хэрэгтэй. Мөн арилжааны банкууд доллараар хадгаламж авахгүй байх нэг арга байна.

**-Төгрөгийн үнэлэмжээ сайжруулж, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэхэд Оюутолгой төслийн далд уурхайн хөрөнгө оруулалт, алтыг Монголбанкнд тушаах, Самурай бонд хөшүүрэг болно гэж үзэж байна. Ингэснээр ноён долларыг ногтолж чадах болов уу?**

**-Д.Жаргалсайхан:** Оюутолгойн далд уурхай урагшлах ёстой. Гэрээний дагуу л бүх зүйл явах хэрэгтэй. Гэтэл нэг Засгийн газар нь гарч ирээд л өөрчилнө гээд хэзээ ч дуусашгүй маргаан руу оруулчихаад байгаа юм. Энэ нь засаглалын чанар, биднийг удирдаж байгаа хүмүүсийн чадвар ямар байгааг харуулж байгаа. Нэгэнт хийгдсэн гэрээг муу ч сайн ч урагшлуулах л хэрэгтэй. Харин зээлээр авсан мөнгө буюу Самурай бондыг ханш тогтворжуулахад ашиглана гэдэг маш буруу. Алт бол угаасаа л Төвбанкинд тушаагдах ёстой байсныг зогсоочихсон байсан. Үүнийг эргүүлээд сэргээсэн нь сайн хэрэг болсон. Мэдээж одоогийн нөхцөлд сайн нөлөө үзүүлнэ. Ер нь зарчмын хоёр том асуудал байгаа юм. Нэгдүгээрт, төрийн компаниудыг яаралтай хувьчлах. Хуучин сэтгэлгээ бидэнд асар их ачаа болж байна. Хоёр

дахь зарчмын асуудал бол төр засагт ороод хулгайлж ууж идэхээ зогсоох хэрэгтэй.

## Б.Төмөрчулуу: Хоёр том хөрш байхад далайд гарцтай гарцгүй боломж бий



**-Б.Төмөрчулуу:** Улстөрчид сонгуулийн үеэр ертөнцийг амлах шахаад гарч ирсэн. Одоо тэднээс амлалтаа биелүүлэхийг шаардах хэрэгтэй.

**-Тэгвэл төгрөгийн ханш суларч, валютын ханш чангарсаны хариуцлагыг хэнээс асуух ёстой вэ?**

-Амлалт өгчөөд биелүүлэхгүй байгаа хүмүүсээс асуух хэрэгтэй. Ялангуяа Монголбанкны удирдлагуудаас асуу. Одоогийн нөхцөлд хамгийн гол нь төр засаг санхүүгийн хүч чадалгүй байх ёстой. Эрийн цээнд хүрсэн хувийн хэвшилдээ даатгах цаг ирчихээд байна. Далайд гарцгүй, төмөр замгүй гэх мэтээр шалтаг их хайж байна. Гэтэл хоёр том хөрш байхад далайд гарцтай гарцгүй боломж бий. Уул уурхайг нийт эдийн засгийнхаа 30 орчим хувьд л байлга. Харин мэдлэгээр бий болох эдийн засгаа 70 хувьд хүртэл хөгжүүлэх. Цаана чинь мал төллөх гэж байна. Малын эхэснээс эмийн маш чухал бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. 50 сая толгой мал тэр чигтээ валют харагдаж байна.

**-Дунд болон урт хугацааны валютын ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд юу хийх ёстой вэ?**

**-Б.Эрдэнэбат:** Юм болгон үнэтэй. Үнэ эрэлт нийлүүлэлтээр тогтдог. Долларын хувьд ч ялгаагүй. Эрэлт нийлүүлэлт хоёулаа дотоод болон гадаад хүчин зүйлээс хамаардаг. Манайд гадаад хүчин зүйлийн нөлөө их болчихлоо. Хэн нэг хүн нь бодлого

боловсруулагч болоод урсгалаараа явдаг байдал өнгөрсөн. Одоо бид айхтар ган зуд, шуургатай нутагт орж ирлээ. Үүнийгээ нэгдүгээрт ойлгох хэрэгтэй. Яагаад ханш уначихав гэдгийг тодорхойл. Гурван шалтгаан байна. Нэгдүгээрт, Монгол Улсын эдийн засгийн өсөлт бусад улсаас хэтэрхий өндөр байна. Ийм өндөр өсөлттэй улсын ханш унадаг жамтай. АНУ хоёр хувиар өсч байхад Монголын эдийн засаг 20 хувиар өсч байна. Тэгэхээр бид АНУ-аас их зүйл худалдан авч байхад АНУ манайхаас бага зүйл худалдан авч байна гэсэн үг. Долларын эрэлт импортын хэмжээнээс шалтгаалж байна. Мал аж ахуй, газар тариалан бол Монголын баялаг. Гэхдээ нэг цэгт төвлөрөөгүй. Үр шимийг нь олон хүн хүртэж болдог. Харин уул уурхай бол баялаг мөн боловч нэг цэгт төвлөрсөн. Үр шимийг нь цөөхөн хүмүүс эзэмшдэг. Тэд асар их хэмжээний ашиг олдог. Харин нэг цэгт төвлөрсөн баялгийн цөөхөн эзэмшигчидийн импортын хэрэгцээ үүсгэх чадавч асар их байдаг.

**-Тэгэхээр яах ёстой вэ?**

Нэгэнт бид шинэ дүрэм, зүй тогтол руу явж байгаагаар таньж мэдэх ёстой болж байна. Тэндээсээ бид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авмаар байна. Уул уурхайг түшиглээд хөгжчихсөн улс дэлхий дээр ганц ч байхгүй. Өөрсдийгөө тэгж хуурч байгаа улс бол байна. Шавхагдах баялаг дээр тулгуурлаад урт хугацаанд амжилттай явж байгаа улс байхгүй. Харин мэдлэг бол шавхагдахгүй. Одоо хүмүүсийн хэрэглэж байгаа гар утас сүмрэг хонины үнэтэй тэнцэж байна. Учир нь мэдлэгийг шингээсэн учраас үнэ нь тийм байгаа юм. Гэтэл Монголын дээд боловсрол олгож байгаа улсын сургууль болох МУИС 2012 онд дэлхийн их сургуулиудын жагсаалтад 2700-д жагсаж байсан. Гэтэл 2013 онд 3200-д орж 600 байраар ухарсан байх жишээтэй. Энэ нь манайх их удаан гүйж байгаа бөгөөд ухарч гүйгээд байна гэсэн үг.

**-Б.Төмөрчулуу:** Хэрсүү худалдан авалт гэдэг зүйл рүү орох хэрэгтэй. Аливаа юмыг худалдаж авахдаа маш хурдан шийдвэр гаргачихдаг. Харин үйлдвэрлэл бол маш их цаг хугацаа хөрөнгө мөнгө зарцуулдаг. Бид бүхнийг биш зөв, хэрэгтэй зүйлийг үйлдвэрлэх нь чухал. ■

## “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ТАЛААР ТА ЮУ ХЭЛЭХ ВЭ?



Ж.Үнэнбат /Компанийн засаглалын хөгжлийн төвийн гүйцэтгэх захирал/

### Эдийн засгийг байгаагаар хүргэх нь чухал

-Монголын эдийн засгийн өнөөгийн байдлыг байгаагаар нь хүргэх та бүхний үүрэг. Хараат бус мэдээллийг тогтмол өгч байснаар танай сэтгүүлийн нэр хүнд дээшилнэ. Тиймээс одоогийн эрчээ алдахгүй, хүмүүсийн амьдралд ойр сэдвээр сайн бүтээл туурвих хэрэгтэй. Ингэснээр танай сэтгүүл нийгэмд байр сууриа эзэлж, түүнийгээ улам баталгаажуулна. Өсөж яваа сэтгүүлийн хувьд улам хичээх хэрэгтэй.



Корали Геверс /Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгч/

### Эдийн засгийн асуудлын өргөн хүрээг хамардаг

-Бидний хувьд “Mongolian Economy” сэтгүүлийг унших дуртай. Үнэн зөв, өгөөжтэй мэдээлэлтэйгээс гадна Монголын эдийн засгийн асуудлуудыг өргөн хүрээнд хамарч чаддаг. Сэтгүүлчдийн хувьд эдийн засгийн хөгжил иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлж буйг ул суурьтай олон талаас нь бичдэг чадвартай.



Жим Двайер /Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал-

### Мэргэжлийн сэтгүүлзүйн замналаасаа бүү хазайгаарай.

“Mongolian Economy” сэтгүүл Монголын эдийн засгийн эргэн тойронд болж буй асуудлуудыг олон нийтэд мэргэжлийн түвшинд сэтгүүлзүйн бүтээл болгон хүргэхийг зорьж байгаа нь том амжилт. Өнгөрсөн хугацаанд тасралтгүй ахиц дэвшил гаргаж ирснийг нь харж байна. Монголын бизнесийн зөвлөл “Mongolian Economy” сэтгүүлтэй хамтран ажилладагтай талархалтай байдаг. Мэргэжлийн сэтгүүлзүйн замналаасаа бүү хазайгаарай. Амжилт хүсье



Л.Амар /Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч/

### Эдийн засгийн тоймтой, голлох сэтгүүлийн нэг


-Монголд байгаа эдийн засгийн тоймтой, голлох сэтгүүлийн нэг. Нийтлэлийн чанарын түвшин өндөр. Эдийн засгийн бодлогыг тодорхойлоход тодорхой хүрээнд нөлөө үзүүлдэг гэж харж байгаа. Танай сэтгүүлийн хамт олонд амжилт хүсье.



Х.Алтай/ Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал асан/

### Бодитой мэдээлэл өгөхийн сацуу зөв цэгцтэй мэдлэг болдог

-Монголын анхны эдийн засаг, бизнесийн төрөлжсөн сэтгүүл. Тиймээс миний хувьд тогтмол захиалж, шимтэн уншдаг. Эдийн засгийн мэдээ мэдээллийг илүү өргөн хүрээнд харж, олон талын эх сурвалжаар баяжуулсан. Энэ нь уншигчдад бодитой мэдээлэл өгөхийн сацуу зөв цэгцтэй мэдлэг болдог.



Шог зургийг А.Амарсайхан

## БОДЛОГО, ШИЙДВЭР

## ХУУЛИАС ДАВСАН ШААРДЛАГА ТАВИХГҮЙ

## С.АЗ

Монгол Улсын баялаг бүтээгчид бол бизнес эрхлэгчид. Тэдний эдийн засагт оруулж буй хувь нэмэр асар их. Бид хөгжихийн тулд бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг боомилсон шийдвэрээс аль болох татгалзах хэрэгтэй болоод байгаа. Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хувийн хэвшилд төрийн оролцоо маш их байсныг тэд хэлдэг. Энэ нь эргээд эдийн засагт чөдөр тушаа болсон гэх. Тиймээс төрийн байгууллагуудаас олгодог зөвшөөрөл, лицензийн тоог багасгаж, шат дамжлагыг нь энгийн хялбар болгохоор Ерөнхий сайдын

захирамж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар хоёр ч жлын хэсэг байгуулагдан ажиллаад багагүй хугацаа өнгөрч байна. Яам, агентлагуудаас олгодог бүх төрлийн зөвшөөрөл, лицензийг нэг бүрчлэн судалж, тэдгээрийг хүчингүй болгох эсвэл хэвээр үлдээх талаар анализын баг санал дүгнэлт боловсруулдаг. Хууль эрх зүйн үндэслэлтэй юу, хүний эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн салбарт бизнес эрхлэхэд ээлтэй эсэх гэсэн үндсэн шалгуураар дүгнэсэн тус багийн саналыг дараагийн шатанд ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэгээр ахлуулсан ажлын хэсэг хэлэлцэж

байгаа. Тэд өнгөрсөн оны есдүгээр сараас энэ оны нэгдүгээр сар хүртэл нийт 914 зөвшөөрлийг хэлэлцээд 404-ийг хүчингүй болгох, 447-г нь хэвээр үлдээх санал дэвшүүлээд байна. Түүнчлэн, шийдвэрлэхэд хүндрэлтэй 63 зөвшөөрлийг олон түвшинд хэлэлцэж эцэслэхээр ажиллаж байгаа юм. Үр дүнд нь төрийн үйлчилгээний дарамт чирэгдэл буурч, бизнесийн ээлтэй орчин бий болно гэж ЗГХЭГ үзэж буй.

Манай сэтгүүл 900 гаруй зөвшөөрлийг нэг бүрчлэн хөндөх боломжгүй. Тиймээс бизнес эрхлэгчдээс хамгийн их шүүмж хүлээдэг Мэргэжлийн хяналт болон Гаалийн ерөнхий газраас ►►

олгодог зөвшөөрөл хэрхэн цөөрч, ямар өөрчлөлт орж буйг хөндлөө. Энэ хоёр байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, бүртгэл зөвшөөрлийн тогтолцоонд бодлогын болон зохион байгуулалтын багагүй өөрчлөлт хэрэгтэйг ажлын хэсгийнхэн хэлж байсан. МХЕГ-аас 44 төрлийн зөвшөөрөл олгож байгаагаас эхний ээлжинд 25-ыг нь хүчингүй болгох, үлдсэнийг нь олон шат дамжлагагүй нэг цэгээс өгдөг болгох аж. Тухайлбал, Ургамлын хорио цээрийн гарал үүслийн гэрчилгээг аж ахуйн нэгжүүд экспорт хийхдээ жилд нэг удаа авдаг юм байна. Уг зөвшөөрөл хэрэгтэй гэдгийг тус газрын дэд дарга Б.Эрдэнэбилэгт яриандаа онцолсон. Тэрбээр “Манайхаас олгож буй зөвшөөрлүүдийн 18 нь баталгаажилтын баримт бичиг байдаг. Ямар нэгэн лиценз биш. Тухайн улс оронтой байгуулсан хоёр талын гэрээ хэлэлцээрийн хүрээнд импортлогчид давуу эрх эдэлдэг. Тиймээс тэдний талын гаргасан саналыг үндэслэсэн. Бид хоёр орны болон олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд баталгаажилтын баримт бичиг гаргаж байна. Үүнийг Монгол Улсын хуулиар зөвшөөрсөн байдаг. Манайх дэлхийн худалдааны болон хүнс, хөдөө аж ахуйн, эрүүл мэндийн байгууллагад гишүүнээр элсэн орсон. Олон улсын ургамал хамгааллын конвенцийг соёрхон баталсан орон. Тиймээс эрүүл ахуйн хэлэлцээр болон дээрх байгууллагуудаас гаргасан стандарт, журмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Энэ дагуу баталгаажилтын баримт бичиг гаргадаг” гэв. Харин Уулын ажлын тайлан төлөвлөгөө хүлээн авч хянаж зөвшөөрөх, Тэсрэх материал ашиглах хяналтын хуудас, Тамхи үйлдвэрлэхэд, Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхэд дүгнэлт гаргах зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Гаалийн ерөнхий газрын хувьд, ижил үүрэг чиглэлтэй тусгай бүс, талбайг цэгцлэх, гаалийн зуучлагчид тусгайлан зөвшөөрөл өгөх зэргээр дундын бизнесийг дэмжихгүй байхад анхаарах ёстой аж. Тус байгууллага 10 төрлийн зөвшөөрөл олгодогийн хоёрыг нь хүчингүй болгож, үлдсэнийг нь хэвээр үлдээхээр болжээ. Аж ахуйн

нэгж бүтээгдэхүүнээ экспортлохын тулд холбогдох бичиг баримтыг гаальд бүрдүүлж өгдөг. Ажлын хэсгийнхэн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбараас эхлээд гааль болон бусад байгууллагаас шаарддаг бүхий л баримт бичгийг дахин шаардаж байна. Зөвхөн тухайн бүтээгдэхүүнд хамааралтай бичгүүдээ аваад явж болдоггүй юм уу гэх асуултыг тавьж байсан. Энэ асуудалд Гаалийн ерөнхий газрын удирдлагууд “Бид хуульд заасан бичиг баримтыг үзэж байгаа. Цахим нэг цонхны үйлчилгээний хүрээнд сүлжээгээр бүх мэдээллүүд манайд ирдэг болчихвол заавал авах шаардлагагүй. Зөвхөн мал эмнэлгийн шинжилгээний хариу зэрэг бичгээ авч ирээд гэрчилгээгээ

“

**МҮХАҮТ-ын дэргэдэх Гаалийн зуучлалын зөвлөлийн төлөөлөл гаалийн зуучлагчид тусгайлан зөвшөөрөл өгдөг эрхийг мэргэжлийн холбоодод өгөх нь зөв гэдгийг хэлж байсан. Харин ажлын хэсгийнхэн үүнийг зөвшөөрөл биш бүртгэл болгохоор шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, танай компани гаалийн зуучлалын үүрэг гүйцэтгэх гэж буй бол Гаалийн ерөнхий газартаа бүртгүүлээд үйл ажиллагаагаа эрхэлж болно. Аль компаниар гаалийн зуучлал хийлгэхээ тухайн бизнес эрхлэгч өөрөө шийднэ.**

”

авах боломжтой” гэв. Үүнд ЗГХЭГ-ын дарга Ч.Сайханбилэг “Цахим нэг цонхны хөтөлбөр хэрэгжүүлэхэд төсөв, хөрөнгө дутмаг байгааг мэдэж байгаа. Засгийн газрын хуралдаанд саналаа оруулна. Гэхдээ Монгол Улсын гадаад өрийн хэмжээнээс хамаарч дахин зээл авах асуудал яригдана” хэмээлээ.

МҮХАҮТ-ын дэргэдэх Гаалийн зуучлалын зөвлөлийн төлөөлөл гаалийн зуучлагчид тусгайлан зөвшөөрөл өгдөг эрхийг мэргэжлийн холбоодод өгөх нь зөв гэдгийг хэлж байсан. Харин ажлын хэсгийнхэн үүнийг зөвшөөрөл биш бүртгэл болгохоор шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, танай компани гаалийн зуучлалын үүрэг гүйцэтгэх гэж буй бол Гаалийн ерөнхий газартаа бүртгүүлээд үйл ажиллагаагаа эрхэлж болно. Аль компаниар гаалийн зуучлал хийлгэхээ тухайн бизнес эрхлэгч өөрөө шийднэ.

Ингээд зах зээлийнхээ хуулиар хамгийн сайн нь олон үйлчүүлэгчтэй болоод явах аж. Үүнд төр оролцохгүй юм байна. Энэ эрхийг авахдаа компаниуд 850 мянган төгрөг төлнө. Одоогоор энэ эрхийг авсан 54 зуучлагч байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос дулаан, цахилгааны хангамжтай холбоотой 11 төрлийн зөвшөөрөл олгож байна. Үүнээс цахилгаан түгээх, дулаан үйлдвэрлэх, түгээх, цахилгаан экспортлох, импортлох, эрчим хүчний барилга байгууламж барих зэрэг долоон зөвшөөрлийг хэвээр үлдээжээ. Улмаар энэ оны хоёрдугаар улиралд багтаан нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж хөнгөвчлөх аж.

Татварын ерөнхий газраас 48 зөвшөөрөл олгож байгаагаас нэгийг нь л хүчингүй болгож, үлдсэнийг нь хэвээр үлдээхээр болжээ. Харин Нийгмийн даатгалын ерөнхий газраас олгодог дөрвөн зөвшөөрлийг бүгдийг нь хүчингүй болгох аж. Тодруулбал, ажил олгогчийн дугаар, арилжааны банкуудтай хамтран ажиллах болон эрүүл мэндийн даатгалын, сайн дурын даатгуулагчийн гэрээний зөвшөөрлийг тус газраас авах шаардлагагүй болж байна.

Мөн Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас олгодог гурван зөвшөөрлийг ч хассан байна. Энэ нь ахмад настны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн үйлчилгээ эрхлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад гэрчилгээ олгох зөвшөөрөл байсан юм.

Төрийн байгууллагуудаас олгодог тусгай зөвшөөрлийг энэ мэтээр цэгцэлсний дараа нийтэд нь зохицуулсан хууль гаргах юм байна. Энэ хуулиар төрийн аль нэг байгууллага өөрсдөө дур мэдэн шинээр лиценз, зөвшөөрөл олгохыг хориглох гэнэ. Шаардлагатай тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах замаар зохицуулалт хийдэг болох нь. Төр бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа хуулиас давсан шаардлагууд бий болгож, энэ нь эргээд төрийн хяналтыг цаасан дээр хэрэгждэг үр дүнгүй механизм болгож байгааг халах нь шинэчлэлийн Засгийн газрын бизнесийн орчны шинэтгэлийн гол бодлого ажээ. ■

## САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭ ХАНДЛАГА

## Э.МӨНХ-ЭРДЭНЭ

“Мандал Ассет Менежментийн хөрөнгө оруулалтын шинжээч, дилер”

**Брокерийн компаниудын чанар ба тоонд эрс өөрчлөлт орно:** Он гарснаар мэргэжлийн оролцогчдын чадавхыг сайжруулах зорилгоор энэ оны хоёрдугаар хагасаас эхлэн брокерийн компанийн хөрөнгийн 200 сая, дилер 300 сая, хөрөнгө оруулалтын зөвлөх 500 сая, андеррайтерийн компанийн хөрөнгийн хэмжээг хамгийн багадаа нэг тэрбум байхаар журамласан билээ. Тэгвэл өнгөрсөн оны III улирлын байдлаар СЗХ-ноос гаргасан тайланд дурьдаснаар нийт 90 гаруй БДК байгаа боловч тэдгээрээс дөнгөж 15 нь 200 саяас дээш төгрөгийн хөрөнгөтэй байна. Үлдсэн компаниуд нь нэгдэх эсвэл зах зээлээс гарна гэсэн үг. Уг



зохицуулалттай холбоотойгоор дараах үйл явдлууд болох боломжтой:

1. БДК-иуд хувьцааны арилжаанд идэвхтэй оролцдог бөгөөд хэрэв зах зээлээс гарахаар шийдвэл өөрсдийн худалдан авсан хувьцаагаа зах зээлд нийлүүлэх юм. Үүнтэй холбоотойгоор нийлүүлэлт мэдэгдэхүйц өсвөл хөрвөх чадвар бага зах зээлд ханшийн уналтыг авчирч болно.
2. Нэгдэж эсвэл хөрөнгөө өсгөж СЗХ-ны шаардлагыг ханган цаашид ажиллахаар төлөвлөсөн компаниудын хувьд илүүдэл хөрөнгө үүсэх ба үүнтэй холбоотойгоор хоёрдугаар хагаст эрэлт үүсч ханш өсөх боломжтой.
3. Журмыг хэрэгжүүлснээр БДК-иудын санхүүгийн чадавхи сайжрах ба үр дүнд нь зах зээл тодорхой хэмжээгээр идэвхжих юм. Мөн хүний нөөцийн хувьд чадавхжих ба үүний хэрээр чанартай үйлчилгээ, бүтээгдэхүүн үзүүлэх эерэг нөлөөтэй.

“Мерекс” ХК-ийн IPO амжилттай хэрэгжих нь алдарсан итгэл сэргэхэд амин чухал нөлөөтэй. 2012 оноос хойш хөрөнгийн зах зээлд нэг ч IPO хийгдээгүй бөгөөд хоёр жилийн дараа ийнхүү анхны IPO гарахад бэлэн болоод байна. “Мерекс” ХК нь нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн хоёр га газарт БНСУ-д бүтээгдсэн, цагт 150 шоо метр бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай TW-2500 маркийн бетон зуурмагийн үйлдвэр барихаар төлөвлөж байна. Бетон зуурмаг нь M100-M600 хүртэлх бат

бэхийн чанартай байх ба 2014-2017 онд нийт 513.2 мянган шоо метр бетон зуурмаг үйлдвэрлэн, 82.05 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөжээ. Энэ хугацаанд нийт 79 ажлын байр бий болгож, 11.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улсын төсөвт 1.8 тэрбум төгрөгийн татварын орлого оруулна гэж тооцоолжээ.

Үнэт цаас худалдан авах захиалгыг энэ сарын 21-ны өдөр хүртэл авах юм. Борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн 70-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох бөгөөд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай дуусгавар болмогц СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг нээнэ. Монголын хөрөнгийн зах зээлд хамгийн сүүлд 2011 онд IPO хийгдсэнээс хойшхи хамгийн анхны тохиолдол бөгөөд нийт 15 орчим IPO зах зээлд гарсны дөнгөж 3-4 нь л амжилттай хэрэгжиж байгаа. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл буурсан нөхцөлд хийгдэж байгаагаараа онцлогтой юм. Иймээс андеррайтерийн компани болох “Стандарт Инвестмент” нь дан ганц IPO гаргаж байгаа гэхээс илүүтэйгээр зах зээлд итгэх итгэлийг сэргээх томоохон алхмыг хийж буйгаараа хүнд үүрэг, хариуцлагыг хүлээж байна.

2014 оноос хөрөнгийн зах зээл эрүүлжиж, их өсөлтийн замд орно. Үнэт цаасны тухай шинэчилсэн хууль хөрөнгийн зах зээлийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлд ихээхэн анхаарч, томоохон дэвшил авчирсан хууль болсон билээ. Гэвч ▶

▶ Монголд сайн хууль батлагдсан ч хэрэгждэггүй тал бий. Иймээс хуулийг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид хамтран хүч нэгдэн ажиллах учиртай. Үүнд СЗХ-ны үүрэг маш чухал. Ингэж чадвал мэдээллийн ил тод байдал эрс сайжирч, зах зээл эрүүлжих юм. Эрүүл зах зээлийг илүү олон хүн сонирхож, урт хугацаанд эргэлдэх хөрөнгө өсөх юм. Үүний зэрэгцээ Хөрөнгө оруулалтын сангийн хууль батлагдсан нь зах зээлийн хөгжлийг цоо шинэ түвшинд гаргах ажлын эхлэл боллоо. Хөрөнгө оруулалтын сан байгуулах эрх зүйн орчин бий болсон нь арилжаа эрс нэмэгдэх боломжийг нээж байна. Мэргэжлийн багийн удирдлага дор сангийн хөрөнгийг эрсдэл багатай, өгөөж өндөртэй удирдах нь зах зээл томроход маш чухал нөлөөтэй. Иймээс сангууд байгуулагдсанаар арилжааны хэмжээ өсч, их өсөлтийн замд орох боломжтой. Гэхдээ хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь нарийн төвөгтэй зохион байгуулалт, харилцаанд үндэслэдэг тул том сангууд байгуулагдахад хугацаа зайлшгүй хэрэгтэй. Иймээс хоёрдугаар хагасаас анхны сангууд байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлэх болов уу.

**2014 онд анхааралдаа байлгах хувьцаат компаниуд:**

- “Нако түлш” ХК нь ЕСБХБ-наас 10 сая ам.долларын зээл авч утаагүй түлш үйлдвэрлэх үйлдвэрийн ажлаа сэргээж, эцсийн бүтээгдэхүүн хийж эхлэхээр

төлөвөж байна. Компанийн хувьд 2008 оноос хойш үйлдвэрийг хэвийн горимд ажиллуулж чадаагүй ч дахин хөрөнгө оруулалт хийх гэж байгаа нь энэ удаад амжилтад хүрч магадгүй гэсэн горьдлогыг төрүүлж байгаа юм.

- АПУ компани нь пивоны үйлдвэрлэлийн хүчин чадлаа жилд 100 сая литрт хүргэж өсгөсөн бол үүнтэй зэрэгцүүлэн сүүний фермерийн аж ахуйгаар өргөжүүлж уг зах зээлд өрсөлдөх гэж байна.
- “Талх Чихэр” ХК нь савлагааны шинэ шугам ашиглалтад оруулснаар үйлдвэрлэлийн бүтээмжээ өсгөх юм. Мөн нарийн боовны үйлдвэрлэлээ өргөтгөх хөрөнгө оруулалт хийгээд байна.
- “Ремикон” ХК нь үйлдвэрлэлийн хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлж, бетон зуурмаг үйлдвэрлэлийн салбарт эзлэх байр сууриа нэмэгдүүлэхээр ажиллаж байна.
- “Говь” ХК нь Засгийн газраас олгосон зээлээр санхүүжилт хийж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчлэхээр ажиллаж байна.
- “Шарын гол” ХК нь нүүрс угаах үйлдвэрийг ашиглалтад оруулж, шинээр нүүрсний ам нээсэн бөгөөд энэ жилээс үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх юм. Цаашид үе шаттайгаар үйлдвэрлэлээ өсгөхөөр ажиллаж байгаа юм.

Үнэт цаасны нэр	Мерекс MRX
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нэрлэсэн үнэ	100 төгрөг
Нийт тоо ширхэг	65.005.00
<b>Хөрвөх үнэт цаас</b>	
Хувь	60%
Тоо ширхэг	39.005.000
<b>Нийтэд санал болгох үнэт цаас</b>	
Хувь	40%
Тоо ширхэг	26.000.000
Нийтэд санал болгох үнэ	100 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгө	2.600.000.000 төгрөг
Анхдагч зах зээлд байршуулах арга	Тогтоосон үнээр санал болгох арга

	Хөрөнгө /сая:төг	
1	Юнайтэд секьюритис	17 257.30
2	Ти Ди Би Капитал	12 850.55
3	Би Ди Сек	9 411.17
4	Фронтьер	1 838.41
5	Баянзүрх инвест	1 311.84
6	Эм Ай Си Си	616.80
7	Азиа пасифик	498.59
8	Дэлгэрхангай секюритис	441.92
9	Блүмсбюри секюритис	441.33
10	Тэнгри секюритис	421.19
11	Ханш инвест	354.85
12	Гацуурт трейд	292.74
13	Эм Ай Би Жи	266.34
14	Глобал ассет	257.00
15	Рескан секюритис	229.08
16	Капитал маркет корпораци	167.79
17	Голомт секьюритис	164.14
18	Лайф Тайм инвестмент	155.95
19	Тэнгэр капитал	154.07
20	Булган брокер	118.58
21	Мэргэн санаа	114.66
22	Өү Си Би	113.07
23	Бумбат Алтай	106.75
24	Таван толгой хишиг	105.76
25	Мөнх отгоргуй	95.41
26	Зэргэд	90.66
27	Алтан хоромсог	87.18
28	Скай хан капитал	72.95
29	Новел инвестмент	54.31
30	Дархан брокер	53.38
31	Грийт секьюритис	52.68
32	Гранд девелопмент	51.62
33	Зюс капитал	50.01
34	Санхүүгийн хөгжлийн инвест	41.79
35	Зэт Жи Би	22.27
36	Чоно капитал	20.40

Дээрх компаниудын хувьд энэ он хөрөнгө оруулалтын үр дүнгээ үзэх жил болох юм. Энэ утгаараа хувьцааны ханшид өсөлт ажиглагдах боломжтой. ■

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

# ЗАСАГЛАЛЫГ ДЭЭШ ТАТАХ ҮҮРЭГТЭЙ ТУЗ ХЭДИЙ БОЛТОЛ ДООШ ЧАНГААХ ВЭ

## Б.БАЯРТОГТОХ

Ногдол ашиг тараахаас аль болох бултдаг. Нэмэлт хувьцаа гаргана гэхээс бүр ч айдаг. Хувьцаагаа арилжаалах замаар хөрөнгө оруулалт хийхээс зайлсхийдэг компаниуд Монголд цөөнгүй. Болж л өгвөл ашиггүй ажилласан гэх нэрийн дор үүрэг, хариуцлагаа умартах нь бий. Тэдний энэ үйлдэл нь эцэстээ хөрөнгийн зах зээлийн хөгжлийг чөдөрлөж байна. Энэ нь хамтын удирдлага буюу компанийн засаглалыг төдийлэн ухаж мэдэхгүйтэй эсвэл санаатай үйлдэл ч байж болох юм. Ажлын байр шинээр бий болгож, баялаг бүтээдэг, ДНБ-д голлох нөлөө үзүүлж байдаг хувьцаат компаниудын нийтлэг төрх энэ.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга Д.Ганбаяр “Хувьцаат компаниудын хувьд арилжааны банкуудаас өндөр хүүтэй, богино хугацаатай зээл авахаас илүү өөрсдөө нэмж хувьцаа гаргаж хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох үүд хаалга нээлттэй. Ингэснээр хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа тэлэх боломжтой” хэмээсэн. Гэвч манай хувьцаат компанийн эзэд дээрх боломжийг ашигладаггүй. Харин арилжааны банк руу зорих нь их. Тэдний хувьд өөрсдийн хувьцааг зарах сонирхол төдийлэн бага. Компанийнхаа 70-80 хувийн хувьцааг төвлөрүүлсэн байдаг учраас эзэмшил хувьцаагаа багасахаас үргэлж эмээдэг гэж хэлж болохоор. Тэгвэл компанийн гүйцэтгэх удирдлагаас илүү эрх мэдэлтэй Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ зарчмынхаа дагуу ажиллаж чадаж байна уу.

Компанийн засаглал хэрхэн төлөвшиж буйг илтгэх нэг үзүүлэлт

нь Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/. Тэд таны хувьцаа эзэмшиж буй компанийн ирээдүйг шийдэх нь олон. ТУЗ нь тухайн компанийн “хувь заяа”-г атгаж байдаг учраас давуу эрх тэдний гарт. Иймд компанийн сайн засаглалд бүтээлч, бие даасан, мэргэжлийн ТУЗ хамгийн чухал байдаг аж. Тэд компанийн болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой. Мөн тухайн компанийн стратегийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж байх учиртай. Түүнчлэн гүйцэтгэх удирдлага болон компанийн



санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Гэвч манай улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудын ТУЗ зөвхөн билгэдэл төдий байгаа нь засаглалын хөгжлийг хойш чангасаар байгаа нь нууц биш ээ.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Засгийн газар 2011 оны гуравдугаар сард баталж байсан. Түүнээс хойш гурван жил болж байна. Энэ хугацаанд компанийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр сургалт, семинар цөөнгүй болсон. Харамсалтай нь засаглалын сургалтад компанийн ТУЗ-ийн гишүүд оролцох идэвх сул болохыг зохион байгуулагчдын зүгээс хэлж байсан. Нэг талаасаа компанийн засаглал нь

урт удаан хугацааны аялал. Гэхдээ байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул хүрэх эцсийн цэггүй. Тиймээс алхам тутамд түүнд суралцах зайлшгүй шаардлага бий. Олон улсын санхүүгийн корпораци, Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын төв хамтран бэлтгэсэн “Компанийн засаглалын үнэлгээний тайлан”-нд “Монголын компаниудын засаглал балчир үедээ явна” хэмээн онцолсон. Хүүхдийн насаар төсөөлсөн энэхүү зүйрлэл нь боломж байгааг давхар илтгэнэ.

Компанийн бизнес өргөжин тэлэхийн хэрээр ТУЗ-ийн үүрэг хариуцлага нэмэгддэг. Тэдний ажилд туслах зорилгоор ТУЗ-ийн хороодыг байгуулдаг байна. Гэтэл манайд ямар ч компани ТУЗ-ийн хороодыг бүрэн байгуулаагүй. Энэ чиглэлээр тэргүүн туршлага байхгүй нь дээрх судалгаагаар гарчээ. Компанийн засаглалд хамгийн түгээмэл байдаг, дэлхийн хэмжээнд тогтсон гурван чухал хороо болох Аудит, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо ч байгуулаагүй байна. Гэтэл Азийн компаниудын 94 хувь нь Аудитын, 75 хувь нь цалин урамшууллын, 56 хувь нь нэр дэвшүүлэх хороотой байна. Компанийн тухай шинэ хуульд дээрх хороодыг заавал байгуулах заалт орсон. ►►

► Тиймээс энэ чиглэлд тодорхой ахиц гарна хэмээн найдаж болохоор. Гэхдээ хууль хэрэгжээд гурван жил болох гэж байхад дорвитой үр дүн алга.

ТУЗ нь компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн дотор гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчилд хяналт тавих асуудлыг эрхэлдэг. Үүнд компанийн хөрөнгийг зүй бусаар ашиглах. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн хүрээнд албан тушаалаа урвуулан ашиглах асуудал хамрагдах аж. ТУЗ-ийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь санхүүгийн тайланг хамруулсан дотоод хяналт шалгалтын тогтолцоонд хяналт тавих. Ийм хяналт тавих үйл ажиллагааг ТУЗ-тэй шууд харилцах эрх бүхий дотоод аудиторт хариуцуулсан байдаг аж. Хараахан манайд энэ чиглэлийн хяналтын

тогтолцоо бүрдээгүй байна. Үүнийг бий болгох зайлшгүй шаардлагатайг Д.Ганбаяр хэлсэн юм. Тэрбээр “Монголын компанийн засаглалын үнэлгээг доош чангааж байгаа нэг тааруу үзүүлэлт нь ТУЗ. Тэдний үйл ажиллагаа, үүрэг хариуцлагатай холбоотой асуудал эргээд засаглал хөгжихөд саад болж байна” гэв.

ТУЗ тунгалаг байхаас тухайн компанийн үйл ажиллагаа илүү итгэл төрүүлэхүйц, найдвартай байх нь дамжиггүй.

Төрийн өмчийн хорооноос 2014 оныг компанийн засаглалын жил болгон зарласан. Энэхүү жилийн хүрээнд төрийн өмчит компаниудын ТУЗ-д багагүй өөрчлөлт, шинэчлэлтийг хийжээ. Өмнө нь төрийн өмчит компанийн ТУЗ-д

төрийн төлөөлөл голдуу оролцдог байсан бол эл байдал өөрчлөгдөж, хуулийнхаа хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилж байгаа аж. “Эрдэнэс МГЛ” компанийн гүйцэтгэх захирал О.Сайнбуян “Төрийн өмчит компаниудад компанийн сайн засаглалыг нэвтрүүлэхээр зорьж байна. Хоёр хөршийн төрийн өмчит компаниудын засаглалыг аваад үзэхэд манай өмнө явж байх жишээтэй. “Эрдэнэс МГЛ” компанийн мэдэлд байгаа төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр дорвитой алхам хийж эхэлсэн. Цаашдаа тухайн компаниуд олон улсын зах зээлд хувьцаа гаргаж, хөрөнгө босгохоор зорьж байгаа учраас засаглал тунгалаг байх хэрэгтэй” хэмээн хэлж байсан юм. Хүчирхэг ТУЗ-өөс таны компанийн ирээдүй шалтгаална. ■

Компанийн засаглал болон Нийгмийн хариуцлагаар

# ТЭРГҮҮЛЭГЧ БАНК



[www.facebook.com/xacbank](http://www.facebook.com/xacbank)  
[www.twitter.com/xacbank](http://www.twitter.com/xacbank)  
[info@xacbank.mn](mailto:info@xacbank.mn)  
[www.xacbank.mn](http://www.xacbank.mn)

Лавлах Утас  
1800-1888



- ✓ Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр тэргүүлэгч, салбар нэгжийнхээ тоогоор гуравдугаарт ордог, Монгол улсын системийн ач холбогдол бүхий банк
- ✓ Бичил санхүү, жижиг дунд бизнесийн зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалан Корпорейт зах зээлд хурдацтай өсөгч
- ✓ ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн охин компаниудтай хамтран банкны болон банкны бус санхүүгийн үйлчилгээг цогцоор нь үзүүлэгч
- ✓ Олон улсын хэмжээний санхүүгийн байгууллагуудаас бүрдсэн хүчирхэг хөрөнгө оруулагчид, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн бизнес загвар
- ✓ Компанийн зохистой засаглал, ил тод байдал, бизнесийн ёс зүйг эрхэмлэгч
- ✓ Эрсдлийн удирдлага, тогтвортой өсөлтийн эзэн
- ✓ Харилцагч төвтэй үйл ажиллагаа, урт хугацааны үнэ цэнэтэй хамтын ажиллагаа



### 2013 ОНЫ МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК

Олон улсын банк санхүүгийн салбарт нэр хүнд бүхий The Banker сэтгүүл 2013 оны Дэлхийн шилдэг банкуудыг шалгаруулж ХасБанкийг “МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК”-аар тодрууллаа.

### 2013 ОНЫ ШИЛДЭГ ИРГЭДИЙН БАНК

Дэлхийн орон бүрээс банк санхүүгийн салбарт манлайлагчдыг тодруулдаг нэр хүндтэй The Global Banking and Finance Re-view Awards шалгаруулалтаас ХасБанк Монгол Улсын Шилдэг Иргэдийн Банкаар шалгарлаа.

## ГААЛЬ

# О.ГАНБАТ: ГААЛИЙН ХҮНД СУРТАЛ БАГАССАН

С.БАТЗАЯА

2014 он. Гаалийн байгууллагад шинэчлэл авчрах жил. Энэ байгууллагыг авлига, хүнд сурталд идэгдсэн гэж шүүмжилдэг. Одоо ч энэ нэрнээсээ бүрэн салаагүй. Сүүлийн 20 гаруй жил явж ирсэн тогтолцоо нь ийм байдалд оруулсан гэх. Улсын төсвийн орлогын тодорхой хувийг бүрдүүлдэг гаальчид энэ онд хоёр их наяд төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна. Энэ нь улсын төсвийн 30 хувь. Тэд өнгөрсөн онд 1.6 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбаттай ярилцлаа.



**-Гаалийн байгууллагад шинэчлэл хийж байгаа гэсэн. Шинэчлэлийг ямар хэлбэрээр хийж байна вэ?**

-Шинэчлэл хэд хэдэн хүчин зүйлээс бүрдэнэ. Хүн сольсноор шинэчлэл болох уу, хуулиа яах юм гээд олон асуудал бий. Би ажлаа авсныхаа дараа гаальчдын сэтгэхүйг нэн түрүүнд өөрчлөх зорилт тавьсан. Бид дэлхийн гаалийн болон худалдааны байгууллага, олон улсын конвенцийн үзэл баримтлалын дагуу ажилладаг учраас бүх ажлаа төлөвлөдөг. Гагцхүү хэрэгжүүлэхдээ удаад байсан тал бий. Үүнд нийгэм, улс төрийн, боловсон хүчин, хүний нөөцийн зэрэг хүчин зүйл нөлөөлж байсан. Улсын хэмжээнд 1112 гаальчин ажиллаж байна. Нийгэмд гаальд ажилд орсон хүн амархан баялдаг, авлига, хүнд сурталд идэгдсэн газар гэсэн ойлголт бий болоод удаж байна. Үүнийг эвдэх ёстой. Юунаас эхлэх вэ гэж ярилцсаны дүнд

гаальчдынхаа сэтгэлгээг нь өөрчлөхөөр шийдсэн. Энэ хүрээнд өнгөрсөн жилийн турш төрөл бүрийн сургалт явуулж, багагүй ажил хийлээ. Эхнээсээ үр дүнгээ өгсөн. Мөн гаалийн удирдлагын арга барилыг өөрчлөх ёстой гэж үзсэн. Бид хамтын удирдлагын арга барил буюу багаараа ажиллаж эхэллээ. Өөрөөр хэлбэл, багаараа шийдвэр гаргая, хариуцлагаа ч хамтдаа үүрээ. Энэ нь ч биеллээ олж байна. Түүнээс гадна өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд худалдааг хөнгөвчлөх, иргэдийг улсын төсвийн орлого бүрдүүлэгч гэж харахгүйн тулд өөрчлөх шаардлага зайлшгүй гарсан. Худалдаа өргөн хүрээтэй. Өмнө нь хоёр орон, бүсийн хооронд хийгддэг байсан. Одоо бус нутгуудын хооронд хийгдэж байна. Тиймээс хуулиа өөрчлөх ёстой.

**-Бодит байдал дээр гаалийн хүнд суртал тодорхой хэмжээнд багассан гэж ойлгож болох уу?**

-Гаальд мөнгөөр ордог, дэвшдэг, шагнуулдаг гэсэн яриа байдаг байсан. Харин өнөөдөр мөнгөний хэмжүүр гаалийн арга ажиллагаанд үгүй болсон гэдгийг би баттай хэлж чадна. Бид шинээр хүн ажилд авахдаа нээлттэй, ил тод сонгон шалгаруулж байна. Мөн ажил амьдралын хүнд нөхцөлтэй боомтуудад байцаагчдаа жил ажиллуулаад сэлгэдэг боллоо. Энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, нэг газар удаан ажиллаж сүлжээнд орохоос хамгаалсан зүйл юм. Тухайлбал, өнгөрсөн онд 384 хүнийг сэлгэн ажиллуулсан бол энэ жил 314 хүнийг сэлгэлээ. Нэг газар очоод суурьшсан гаальчдын үр хүүхдүүд тэндээ сургууль соёлд орно. Тухайн газартаа дасаад төвхнөж эхэлж байтал тушаалаар Монгол орны өнцөг булан бүр рүү томилчихдог. Чулуу байрнаасаа хөдөлбөл гурван жилийн дараа байраа олдог гэдэг үг бий. Түүнтэй адил хүн дассан орчноосоо өөр газар очиход сэтгэл зүйн болоод бие махбодид асар их өөрчлөлт гардаг. Гэхдээ төрийн хууль хатуу, төрийн алба шаардаж байгаа учраас ийм томилгоо хийхээс аргагүй. Бид гаальд өмнө нь байгаагүй маш олон шинэчлэлтийг хийсэн. Санхүүгийн ил тод байдлыг бий болголоо. Манай бүх дарга нар иргэдтэй чөлөөтэй уулздаг болсон. Бид өдөрт 12-14 цаг ажиллаж байна. Бидний хийсэн ажлын үр дүн хүмүүст эхлээд харагдаг. Түүний дараа хүн хийсэн зүйлээ ярьж болно шүү дээ. Манайх бүх боомтоо төвөөсөө камераар хянадаг болсон. Энэ системийг Ерөнхий сайд болон бүх яамны сайд нарын IPAD-д суулгаж өгсөн.

**-Гааль дээр гардаг томоохон зөрчлүүд байсаар байгаа юм биш үү. Сэлэнгийн гаалийн байцаагчид ▶▶**

► **саяхан их хэмжээний зөгийн бал ачсан машиныг хоосон гэж 2-3 шат дамжлагаар гаргасан байсан. Үүнийгээ гаальчид “машин өшиглөх” гэж ярьдаг гэсэн. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?**

-Энэ дагуу бид маш сайн шалгасан. Зөрчлийн нэгжийнхэн импортлогч, бизнес эрхлэгчдийн эсвэл гаалийн байцаагчдын гаргасан зөрчил байна уу гэдгийг шалгадаг. Импортлогч, гаальчид хоёр үгсэн хуйвалдсанаас зөрчил гардаг. Уг асуудлыг шалгаад үзэхэд гаальчдын буруу байгаагүй. Байцаагчид маань дүрэм журмынхаа дагуу ажилласан байна лээ. Импортлогчид хоосон машин гэж мэдүүлсэн гэсэн. Тэр дагуу нь бүртгэж аваад хяналтын талбайд авчраад шалгаад үзэхэд зөгийн бал гарч ирсэн юм билээ. Мэргэжлийн хяналтынхан хүртэл хоосон гээд гаргаад явуулсан байсан. Манай гаальчдад өс санасан улсууд хаа сайгүй байдаг. Гүтгэх, гүжирдэх явдал бишгүй. Хэрэв шалгалтаар байцаагчдын буруу байсан бол бүгд халагдах байсан.

**-Засгийн газрын хуралдаанаар таныг цалингийн 20 хувиар торгож, сануулга өгсөн. Энэ юунаас болов. Ахиц дэвшил гарсан уу?**

-Ерөнхий сайдын бухимдах зүйл гарцаагүй гарсан юм. Засгийн газар өнгөрсөн оны гуравдугаар сард зургаан сарын дотор 11 км, 48.000 ам.метр зам талбайн тохижилтыг засах үүрэг өгсөн. Энэ ажлыг бид аравдугаар сарын 30-нд хүлээлгэж өгөх байсан ч хугацаанаасаа сарын өмнө дуусгасан. Тэр замаар машин явахын тулд сүлжээ орсон байх ёстой. Гэтэл сүлжээ оруулж амжаагүй байтал Ерөнхий сайд Замын-Үүдэд ажилласан. Энэ бидний хариуцлагагүй ажилласны үр дүн. Дараа нь нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой тээвэрлэгч компани бидний хооронд үл ойлголцох байдал гарсан юм. Гэтэл гаалийн хүнд суртлаас болж нүүрс гарахгүй байна гэх мэдээлэл Ерөнхий сайдад очсон учраас “Гаалийг удирдаж байгаа учраас таньтай хариуцлага тооцье. Хоёр дахь удаагаа ийм байдал давтагдлаа” гээд хариуцлага тооцсон юм. Нөгөөтэйгүүр шинэчлэлийн Засгийн газар төрийн институтийг авлига, хүнд сурталгүй болгох зорилт тавьсан. Гэтэл гаалийн хүнд суртал арилахгүй яагаад удаад байна вэ гэсэн. Энэ үүднээс надад арга хэмжээ авсныг би

зөв гэж үзэж байгаа. Аливаа зүйл хоёр талтай. Нэг талдаа арга хэмжээ боловч ажиллах хүч, зоригийг өгдөг. Тийм ч учраас бид Засгийн газраас тавьж буй шаардлагыг цаг алдалгүй хэрэгжүүлж байгаа.

**-Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомт 24 цагийн ажиллагаагүй, олон улсын статусгүй байгаа нь Монголын нүүрсний өрсөлдөх чадварт нөлөөлж буйг мэргэжилтнүүд хэлж байсан. Эдгээр боомтыг дээрх дурьдсан ажиллагаанд шилжүүлж болдоггүй юм уу?**

-Аливаа боомтыг нээх, хаах, олон улсын статустай болгох, ямар цагийн хуваариар ажиллах зэргийг хоёр улсын Засгийн газар хэлэлцэж, шийддэг. Боловсон хүчин, байцаагчдынхаа тоог нэмж, манайх Хятадын талтай тохиролцсоны дараа 24 цагийн ажиллагаатай болгож болно. Ийм болгоход Монголын гаалиас шалтгаалах зүйл байхгүй. Засгийн газар нүүрсний экспортыг нэмэгдүүлэхийн тулд 24 цагийн ажиллагаатай болгоно гэвэл бид хүн хүчээ бэхжүүлж болно. Манай Засгийн газар Сэлэнгийн Алтанбулагийн боомтыг 24 цагаар ажиллуулахад бэлэн гэдгээ саяхан зарлалаа. ОХУ-ын Засгийн газартай харилцан тохиролцож чадвал 24 цагийнх болно.

**-Манайх хэдэн жилийн өмнө Тяньжины олон улсын худалдааны бүсэд газар түрээсэлсэн. Энэ газрын ашиглалт ямар байгааг сонирхоё?**

-Манайх гадаад худалдааны асуудлыг хариуцдаггүй. Харин гадаад худалдааны статистикийг гаргадаг юм. Монгол Улсын хилээр хэдий хэмжээний зүйл орж, гарч байна гэдгийг бүртгэдэг. Бүртгэхдээ орж ирж буй бараануудад холбогдох хуулийн дагуу татвар ноогдуулдаг. Нийгмийн аюулгүй байдлыг хангахын тулд тэсэрч дэлбэрэх, хортой бодис, ургамал зэрэг хориглосон бараа орж ирж буй эсэхийг шалгана. Гэхдээ Тяньжинд түрээсэлсэн газрын тухай би мэдээлэлтэй байдаг. Тэнд нүүрс, эрдэс баялгийг буулгаад бусад орон руу экспортолдог задгай барааны бирж байдаг юм. Тус биржээр дамжуулж Хятадын зүүн өмнөд нутаг буюу далайн эргийн болон бусад улсад бүтээгдэхүүнээ явуулахаар манайх төлөөлөгчийн газар байгуулж, газар түрээсэлсэн байсан. Энэ газрыг одоохондоо ашиглаагүй гэж бодож

байна. Учир нь, Монголын экспорт байхгүй байна. Газрын түрээс төлөөд явж байгаа байх. Манайх Хятадын гол нүүрс экспортлогч байсан үед үр ашгаа өгч байсан. Одоо ашиглах нөхцөл нь бүрдээгүй байж магадгүй.

**-Танай байгууллагад эрсдэлийн удирдлагын менежментийг өмнөх даргын үед нэлээд сайн хэрэгжүүлж байсан. Таны үед энэ ажил ямар шатанд байна вэ?**

-Эрсдэлийн удирдлагыг гаалийн хяналтад ашиглах асуудал дэлхийн гаалийн болон худалдааны байгууллагуудад тавигдаад байгаа. Өмнө нь хууль ёсны худалдаанд саад хийхгүй байна шүү гэсэн уриа байсан юм. Одоо хууль ёсны худалдааг хөнгөвчилж гэж байгаа. Энэ уриаг хэрэгжүүлэх нэг арга хэрэгсэл нь эрсдэлийн удирдлагын менежмент юм. Манайх үүнийг онолын түвшинд 5-6 жил ярьсан. Амьдрал дээр саяхнаас хэрэгжүүлж байна. Энэ нь биет үзлэгээс аль болохоос зайлсхийж, иргэд, импортлогч нарт итгэл үзүүлэх асуудал юм. Гэхдээ манай гадаад худалдаанд оролцож буй иргэдийн гаалийн хууль тогтоомжийг сахиж буй байдал маш доогуур. Өнгөрсөн жил эрүүгийн шинж чанартай гэмт хэрэг өмнөх оныхоо мөн үеэс 2.4 хувиар ихэссэнээр энэ зүйл нотлогдож байна. Гэхдээ бид энэ жилээс итгэлцлийг бий болгоно. Ингэхийн тулд хуульдаа өөрчлөлт оруулах ёстой. Бид Монгол Улсын иргэнийг гаалиар дамжуулж татварын орлого төвлөрүүлэгч гэж харахаа больё. Амьжиргааны журмаар оруулж ирж буй бараа бүтээгдэхүүнд хязгаар тогтоож өгнө. Харин тэднийг аюултай болон хориглосон бараа авч явж байгаа эсэхийг нь шалгана. Гадаад худалдааг аж ахуйн нэгжээр хийлгэнэ. Өөрөөр хэлбэл, хил дээр зогсоож шалгахгүй, аюулгүй байдлыг нь үзээд шууд явуулна. Үүний дараа араас нь очиж, гаальд татвараа үнэн зөвөөр нь төлсөн эсэхийг шалгана. Тэр үед зөрчил илэрвэл хил дээр төлвөл зохих мөнгөнөөсөө хэд дахин нугалж төлөх хуулийн төсөл боловсруулж байна. Ийм маягаар эрсдэлийн удирдлагыг олон улсын хэмжээнд хийхээр төлөвлөж байгаа.

**-Гаалийн тухай хуульд өөр ямар өөрчлөлт орох вэ?**

-Хуульд маш их өөрчлөлт орж байгаа. Засгийн газар тарифын зохицуулалтын ►

▶ талаар тодорхой зорилт тавьж ажиллаж буй. Манайх тарифын зохицуулалтаа бараг хэрэглэдэггүй. Учир нь, гаалийн татварын тариф таван хувь. Онцгой татвар мэтийг эс тооцвол энэ хувиасаа хэлбэлзээд байдаггүй. Манайх хамгийн бага татвартай улсуудын нэг. Энэ нь ч тухайн үедээ хэрэгтэй байсан. Улс орны эдийн засгийн хөгжилтэй холбоотой гадаадын хөрөнгө оруулалт татах зорилготой байв. Энэ хүрээнд үр дүнгээ тухайн үед өгч байсан. Одоо бид уян хатан тарифтай болох ёстой. Тиймээс тарифын зохицуулалтыг ойролцоогоор 20 хувьд хүргэх Засгийн газрын зорилт байгаа. Монгол Улс 197 нэр төрлийн тарифын бараатай байсан бол 1700 болголоо. Үүнтэй уялдуулан татвар, тарифын хуульдаа өөрчлөлт оруулна. Мөн манай байгууллагын ерөнхий шинжид өөрчлөлт орох юм. Өмнө нь гааль "ҮАБ-ын зарим чиг үүргийг биелүүлэгч төрийн байгууллага мөн" гэсэн тодорхойлолттой байсан. Шинэ хуулиар захиргааны шинжээс үйлчилгээнийх болно. Дэлхийн олон орны гааль ийм байдаг. Өөрөөр хэлбэл, шуурхай, ил тод, хүнд сурталгүй байх ёстой гэх шаардлага гаальчдад тавигддаг юм. Ингэхийн тулд гаальчдын нийгмийн баталгааг өндөрсгөх ёстой. Тэгж байж авлига, хээл хахууль багасна. Одоогийн мөрдөгдөж буй хуульд байгаа бизнест хүндрэл учруулаад буй заалтуудыг гаалийн хяналтыг алдагдуулахгүйгээр хэрхэн багасгах вэ гэдгийг оруулж өгнө.

#### -Тухайлбал?

-Гадаадын хөрөнгө оруулалтаар манайд бүтээн байгуулалт хийх гэж буй компаниуд хил гаалиар тоног төхөөрөмж оруулж ирдэг. Гэтэл хуулийн зарим зүйл заалтаас болж хугацаа алдах тохиолдол бий. Манайд бүтээн байгуулалтын сар бага. Гэтэл хилээр оруулж ирсэн техник хэрэгслүүд зарим үед жилийн дараа эзэндээ хүрдэг. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулах том хүчин зүйл болж байна. Үүнийг сонгодог хэлбэрт оруулж, хялбаршуулна. Мөн онлайн худалдаа маш их бий болж. Хүмүүс хоёр ном худалдаж авахаар захиалчихдаг. Түүнийг цаад газраас нь илгээмжээр явуулах юм. Гэтэл бид хоёр ном, гурван гутал байсан ч татвар авдаг. Энэ нь ард иргэдийн бухимдлыг төрүүлж байна. Үүнд өөрчлөлт оруулна.


#### -Гаальчдын нийгмийн баталгааг өндөрсгөнөөр эргээд авлига, хээл

#### хахуулийг нэмэгдүүлэх нь гэсэн хардлага нийгэмд байна. Ингэхгүй гэх баталгааг та өгч чадах уу?


-Төр оршихуй дор татвар оршино гэсэн үг байдаг. Төр татвар дээр суурилдаг. Тиймээс төр, төрийн албан хаагчдаар дамжуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ үүднээс гааль, татвар зэрэг орлого бүрдүүлдэг байгууллагуудынхаа албан хаагчдад төр мөнгө харамлах ёсгүй гэж би үздэг. Яагаад гэвэл төрийн албан хаагчдын авч буй цалин амьжиргаандаа хүрэлцэхгүй байна. Ар гэрийнхээ хэрэглээг хангаж чадахгүй хэр нь тушаалаас тушаалын хооронд амьдардаг. Гаальчдын дунд гэр бүл салалт маш өндөр. Өглөөнөөс орой хүртэл босоогоороо ажиллаж байна. Тэр утгаараа өвчин эмгэг тусах нь ч элбэг. Дөнгөж ажилд орж байгаа гаалийн байцаагч 300 гаруй мянган

төгрөгийн цалинтай. Хамгийн дээд талын байцаагч 800-900 орчим мянган төгрөг авч байна. Ийм нөхцөлд амьдарч байгаа хүмүүс үнэнчээр ажиллаж байа гэж бодъё. Ар гэрт нь гэнэт гачигдал гарсан үед хэн нэгэн 20 сая төгрөг өгье тийм бичиг хийгээд өг гэвэл яана. Ийм байдлаас болоод хэрэгт орсон байцаагч олон. Тиймээс ядаж л төрөөс амьжиргааг нь даадаг байх ёстой. Төрийн хайр хишиг чамд очиж байгаа учраас чи үнэнчээр ажилла, тэгэхгүй бол уучлаарай гэдэг болно. Хайр, хатуу байдал хоёр тэнцвэртэй байх ёстой. Ингэж байж авлига, хээл хахууль багасгах учиртай. Үүнийг Ерөнхий сайд, УИХ-ын дарга дэмжсэн. Хууль хаврын чуулганаар батлагдвал бидэнд маш их хэрэгтэй байна.

#### -Ярилцсанд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье. ■



германы хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



giz



МОНГОЛЫН ЭКОНОМИ

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН АЧ ХОЛБОГДОЛ СЭТГҮҮЛЗҮЙН ШИЛДЭГ НИЙТЛЭЛИЙН УРАЛДААНЫ БОЛЗОЛ

**УРАЛДААНЫ ЗОРИЛГО:**

Компанийн нийгмийн хариуцлагын талаарх асуудлуудыг сэтгүүлзүйн мэргэжлийн өндөр төвшинд хөндөж, улмаар уг асуудалд олон нийт болон шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах, олон нийтэд зөв мэдээ мэдээллийг хүргэх

**СЭДЭВ:**

Компанийн нийгмийн хариуцлагын ач холбогдол

**ХАМРАХ ХҮРЭЭ:**

Хэвлэл мэдээллийн бүхий л салбарын сэтгүүлч, уран бүтээлчид

**БҮТЭЭЛИЙН ХАМРАХ ХУГАЦАА:**

2014 оны 3 сарын 10-наас 2014 оны 5 сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн бүтээл

**ШАЛГУУР:**

Асуудалд сэтгүүлзүйн мэргэжлийн үүднээс хандаж баримтад тулгуурласан, тооцоо судалгаа сайтай, тэнцвэртэй, бодитой, хэл найруулгын хувьд шаардлага хангасан, логик сэтгэлгээтэй бүтээл байх

**СЭТГҮҮЛ ЗҮЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ:**


Дүн шинжилгээ бүхий АСУУДАЛ ДЭВШҮҮЛСЭН нийтлэл

**АГУУЛГА:**

Нийгмийн хариуцлагын тодорхой асуудлыг олны анхааралд хандуулах замаар нийгмийн сэтгэлзүйд хүрч, нийгмийн хариуцлагын ашиг тус, ач холбогдлыг тодорхой тоо, баримтаар тусган харуулсан байх

Нийтлэл нь улс төржих, аль нэг талын эрх ашгийг хэт баримтлах, компанийн болон хувь хүний нэр төрд халдах зэрэг гажуудлаас хол хөндий байж, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйг баримталсан байх

Уралдаанд оролцох бүтээл нь сонин хэвлэл болон мэдээллийн цахим сайтуудаар нийтлэгдсэн байх



ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ			
🏆 I БАЙР	800,000 ТӨГРӨГ	🏆 III БАЙР	400,000 ТӨГРӨГ
🏆 II БАЙР	600,000 ТӨГРӨГ	🏆 ТУСГАЙ БАЙР	200,000 ТӨГРӨГ

**СОНИРХСОН СЭТГҮҮЛЧИД ДЭЭРХ ШАЛГУУРУУДЫГ ХАНГАСАН БҮТЭЭЛЭЭ 2014 ОНЫ 6 САРЫН 2-НЫ ДОТОР:**

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага (ЭТИС) хөтөлбөрийн Нэгдсэн Үндэстний гудамж, 38-р байрны (Эдийн засгийн хөгжлийн яамны замын эсрэг талд) 3 давхарт ирүүлнэ.

Сонины бүтээлийг хэвлэлд гарсан эх хувиар болон файлаар авчирна. Интернетийн сайтуудад гарсан бүтээлийг холбогдох линкийн дагуу бүртгэнэ.

Уралдаанд оролгогчид бүтээлийн хамт овог нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг бүхий мэдээллийг хавсаргасан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн 7011 7704 (19) утсаар, [ganbaatar.ganchimeg@giz.de](mailto:ganbaatar.ganchimeg@giz.de) цахим хаягаар авна уу

ДЭЛХИЙН ЗАЛУУ УДИРДАГЧ

# МАНЛАЙЛАГЧ

## Ч.ЛУТАА

“Дэлхийн эдийн засгийн форум”-аас тухайн оны дэлхийн залуу манлайлагч залуусыг тодруулж зарладаг уламжлалтай. Залуу манлайлагчдыг тодруулахдаа ажил үйлсээрээ үндэсний хэмжээндээ манлайлсан, олонд танигдсан, удирдах ажлын туршлагатай, нэр цэвэр, нийгэмд эзлэх байр суурь өндөр, 40 хүртэлх насны залуусыг “Дэлхийн залуу манлайлагч” хэмээн алдаршуулдаг аж.

Тэгвэл энэ оны дэлхийн залуу манлайлагчийг тодруулахад олон улсын 60 гаруй орноос шалгарсан залуу манлайлагчийн хоёр нь монгол залуу байсан юм. Тэдний нэг нь “Nova terra” ХХК-ийн захирал Б.Бямбасайхан, харин нөгөө нь “Шунхлай” группын дэд ерөнхийлөгч, Стратеги төлөвлөлт хариуцсан захирал В.Ганзориг нар байлаа.

Б.Бямбасайхан захиралд өнгөрсөн нэгдүгээр сарын сүүлээр “Дэлхийн эдийн засгийн форум”-ын дарга Клаус Швабын гарын үсэгтэй захидал иррт. Тэр захидалд таныг Дэлхийн залуу манлайлагчаар тодрууллаа. Гэхдээ олон нийтэд ирэх гуравдугаар сард мэдээлнэ гэсэн байжээ. Б.Бямбасайхан захиралаас дэлхийн залуу манлайлагч болсон баярын сэтгэгдэлээс нь хуваалцахад “Сонгон шалгаруулалтын хувьд тусгай баг гараад эх орондоо төдийгүй олон улсад амжилт бүтээлээрээ танигдсан улс төр, урлаг соёл, бизнесийн гээд олон салбарын залуусыг тодорхой хугацаанд судлаад манлайлагчаар тодруулдаг гэсэн. Миний хувьд зургаан жилийн турш Дэлхийн залуу манлайлагч гэсэн эрхэм алдарыг дааж явах юм билээ” гэв.

Уг үйл ажиллагааны гол зорилго нь дэлхийн манлайлагч залуус нэгдэж нийлэх. Мөн хамтраад дэлхий нийтэд хүртээмжтэй сайн зүйлс хийх, хамгийн сүүлийн үеийн мэдээлэл солилцох олон улсын хэмжээний сүлжээг бий болгох байдаг аж. Түүчлэн уг эрхэм хүндтэй шагналын эзэн болсон залуус, хувь хүний хувьд өөрийгөө хөгжүүлэх. Цаашлаад олон улсын чанартай хурал цуглаанд оролцох эрхтэй болдог гэнэ. Тухайлбал, дэлхийн залуу манлайлагчид ДОВАС-ын чуулга уулзалтад



давуу эрхтэй оролцох боломжтой байх жишээтэй. Б.Бямбасайхан “Энэ шагналын эзэн болсноор олон улсад бий болж буй шинэ арга барил, техник технологийн мэдээлэл, дэлхийн хэмжээнд яригдаж байгаа хөгжлийн загвар, эдийн засгийн чиг хандлагыг хамгийн түрүүнд сонсох сүлжээнд нэгдэж байна гэсэн үг. Тиймээс энэ бол хувь хүний тухайд алдаж болохгүй боломж юм. Нөгөө талдаа улс орноо дэлхийн тавцанд таниулах, сурталчилах таатай нөхцөл гэж ойлгож болно. Ид хийж бүтээдэг насны дэлхийн шилдэг залууст эх орныхоо талаар таниулж улмаар хөрөнгө оруулалт татах, мэдлэг туршлагыг нутагшуулах, шинэ бизнес санаа олох, нийгэмд тустай үйл хэрэг хийх гээд олон сайхан боломж бүрдэж байна” гэсэн юм. Энэ тавдугаар сард Филиппин улсад “Дэлхийн залуу манлайлагч”-дын чуулга уулзалт болох аж.

“Дэлхийн залуу манлайлагч”, “NovaTerra” компанийн захирал, Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга зэрэг олон албатай Б.Бямбасайхан захирал мөн “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүнээр ажилладаг. Манай сэтгүүлийн редакцийн зүгээс Бямбасайхан захиралдаа баяр хүргэж, цаашдын ажилд нь амжилт, эрүүл энх, аз жаргалыг хүсье. ■

MADE IN MONGOLIA

# МОНГОЛ ШУУДАЙ

## Э.ЗОРИГТ

Эзэнгүй гэмээр хашаанд чимээгүй дүнснийх үйлдвэрийн зориулалттай саарал байшингийн тосон бор хаалгыг аяархан түлхлээ. Гаднаасаа уйтгартай харагдах байшин босго давахын төдий амь орох шиг. Юуных болох нь үл мэдэгдэх түчигнэсэн чимээ чих дэлсэж, нэгэн жигдийн хөх хувцастай залуус яаран алхална. Энэ бол уул уурхайн эрдэс баялаг савлах, тээвэрлэх зориулалттай бүх төрлийн даацын шуудай үйлдвэрлэдэг “Эс Эм Контейнер Байг” ХХК юм. Тус компани “Сэргэн мандалт групп”-ийн санаачилгаар 2004 онд үүсэн байгуулагдаж, 2005 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа 100 хувийн дотоодын хөрөнгө оруулалттай, хаягдалгүй, эко үйлдвэр гэдгээрээ бусдаас онцлог. 2005 оноос өнөөг хүртэл Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажилласаар ирсэн байна.

Үйлдвэр үндсэн таван хэсгээс бүрдэх бөгөөд эхний хэсэгт ороход тэнд чимээ бага. Цонхоор тусах нарны туяа даган цагаан тоос татсан байх агаад хайлуулсан хуванцарын

гэмээр содон үнэр хамар цоргих аж. Үйлдвэрлэлийн ерөнхий инженер Б.Одонбаатар шуудай хийх түүхий эд болох полипропилен /PP/ буюу монголчуудын нэрлэж заншсанаар хуванцарыг тусгай зууханд хайлуулж байгаа тул ийм үнэр гарах нь аргагүй гэсэн юм. Тэд БНСУ-ын LG, LOTTE компанийн олон улсын стандартад нийцсэн дээд зэргийн түүхий эдийг үйлдвэрлэлдээ ашигладаг аж. Мөн түүхий эдийн хувьд олон улсын ISO-9001, 14001 үзүүлэлтүүдийн шаардлага хангасан гэдгийг ерөнхий инженер онцолсон. Шуудай үйлдвэрлэх эхний шат болох энэ хэсэг бүрэн автомат ажээ. Тусгай шалгагч нар л хааяа тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг нягталж харагдана. Эхний дамжлага хариуцсан ажилтан тусгай зуух руу будаа шиг тунгалаг өнгийн полипропилен буюу хуванцарыг хийгээд дээрээс нь чанар сайжруулах хэд хэдэн тусгай бодисыг нэмээд төхөөрөмжийн товчлуурыг дарахад техник горимынхоо дагуу ажиллаад эхэлдэг аж. Машин полипропиленыг хайлуулж пилонк болгоно. Түүнийг нь зүсэгч машин зүсч туузан хэлбэрт

оруулаад дараагийн дамжлаг руу илгээнэ. Дараагийн машин түүхий эдийг хүлээн аваад татаж, нягтаршуулж, сунгаад тусгай дамранд ээрч шуудай хийх үндсэн түүхий эд болох полипропилен утсыг бэлэн болгоно. Ингээд л үйлдвэрийн эхний үе шат дуусна.

Харин хоёрдугаар хэсэгт нэхэгч машин ажиллана. Дуу чимээ ихтэй гэж жигтэйхэн. Үйлдвэрийн ажилчдын зарим нь дохио зангаагаар ойлголцож харагдана. Өндөр босоо хэлбэрийн зургаан ширхэг дугуй нэхэх машин байх бөгөөд тус тусдаа өөр өөрийн үүрэгтэй. Зарим нь шуудайны их биеийг нэхэж байхад нөгөө хэсэг нь ёроол, таг гээд дагалдах хэсгийг нэхнэ. Ерөнхий инженер Б.Одонбаатар “Манай нэхэгч машин босоо хөндлөн гэсэн дарааллаар утсаа нэхдэг. Машины хувьд хүссэнээрээ өгөгдөлийг нь өөрчилж болдог болохоор төрөл бүрийн уут нэхэх боломжтой. Мөн ямар ч залгаагүй шууд уут хэлбэрээр нь нэхдэг тул эдэлгээ даах чадвар илүү сайн байдаг” гэв. Нэхмэлийн ▶



“Эс Эм Контейнер Байг” ХХК-ий үйлдвэрийн оёдлын хэсэг

Бүтээгдэхүүний чанар шалгах эцсийн дамжлага

▶ машин зогсолтгүй ажилласаар хоолой хэлбэрийн уутыг метр метрээр нь үйлдвэрлэнэ. Эндээс хуванцараас хоолой хэлбэрийн бүтээгдэхүүн дараагийнхаа дамжлага руу хүргэгддэг аж. Үйлдвэрлэлийн гуравдагуур хэсэг нь хоолой хэлбэрийн уутыг тасдах, компанийн логог тавих, дунд шатны чанар шалгагч нарын хяналтыг давах гэсэн хэсгээс бүрддэг юм билээ. Энэ хэсгийг давж чадсан бүтээгдэхүүн эцсийн дамжлага руу явах “виз”-тэй болно. “Product of Mongolia” гэж цагаан дээр хараар “Виз” даруулсан бүтээгдэхүүн ёроол, даацын бүслүүр, таг оёулж гэмээнэ сая нэг юм шуудай хэлбэрээ олно. Гэхдээ эцсийн бүтээгдэхүүн болох хараахан болоогүй. Шуудай маань чанар шалгагч нарын гараар заавал орох ёстой. Чанар шалгагчийн хатуухан шаардлагыг давсан нь л зэсийн баяжмал савлах зориулалттай 1х6 буюу хоёр тонны багтаамжтай ч 12 тонныг даах чадвартай шуудай болон 25 ширхэгээр багцлагдаад Оюутолгойн зүг ачигддаг ажээ. Оюутолгойд шуудай нийлүүлдэг болохын тулд компанийн ажилчид бүтээгдэхүүнээ Шанхайн олон улсын чанар стандартын лабораторт шалгуулж, ISO 21898 1х6 чанарын шаардлагыг хангасан байна. “Эс Эм Контейнер Байг” ХХК-ийн эдийн засагч Н.Алтанхуяг “Оюутолгой компаний зүгээс зэсийн баяжмалыг эцсийн хэрэглэгчид хүргэтэл олон удаа ачиж буулгадаг мөн нар салхинд удаан хадгалдаг болохоор өндөр чанартай зэсийн баяжмалын уут хэрэгтэй байгаа гэсэн. Бид техник технологийн дэвшил гарган, хичээж ажилласны үр дүнд үйлдвэрлэсэн шуудай маань олон улсын стандарчлал хэмжил зүйн лабораторид тестүүлж тэнцсэнээр Оюу Толгой компанид 2013 оны 07 сараас эхлэн уут нийлүүлж амжилттай хамтран ажиллаж байна. Одоогоор манай компани шиганхдагчтүүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр Монголд байхгүй” гэсэн юм. Полипрополин гэх түүхий эд энэ бүх шат дамжлагыг давж шуудай болгохын тулд үйлдвэрт ээлжээр 100 орчим хүн ажилладаг аж. Үйлдвэр энэ зарчмын дагуу дээд хүчин чадлаараа ажиллалаа гэхэд сард 18-20 мянган шуудай үйлдвэрлэх боломжтой гэнэ. Гэхдээ одоогоор 70-80 орчим хувьтай ажиллаж байгаа бөгөөд зөвхөн

Оюутолгой компанийн захиалгаар зэсийн баяжмалын шуудай хийж байгаа гэсэн.

## Ханшийн түймэр

Төгрөгийн огцом уналт, намрын өвсөнд тавьсан гал шиг дүрэлзсэн ам.долларын ханш дотоодын үйлдвэрлэгч нарыг сөхрүүлээд байна. “Эс Эм Контейнер Байг” компанийн хувьд БНСУ-аас түүхий эдээ импортолдог. Гэтэл ам.доллар ойролцоогоор 25 орчим хувь чангарсаны улмаас түүхий эдээ импортлох өртөг өссөн байна. Эдийн засагч Н.Алтанхуяг “Бид түүхий эдээ импортоор худалдан авч үйлдвэрлэл эрхэлдэг болохоор шуудайны өртөг долларын ханштай шууд хамааралтай байдаг. Ам.доллар хэдий чинээ чангарна бүтээгдэхүүний үнэ дагаад өсдөг. Гэтэл өндөр үнэтэй бүтээгдэхүүн авах сонирхол дотоодын компаниудад бага. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэр биднээс урдынхаа тогтоосон үнээрээ шуудай авах сонирхолтой байна. Гэвч зах зээлийн зарчимаар бүтээгдэхүүний өртөг өсчихөөд байна. Тиймээс 2013 онд бидашигтай ажиллаж чадсангүй. Үнэтэй холбоотой асуудлаас болоод Эрдэнэт үйлдвэрт шуудай нийлүүлэхээ түр зогсоогоод байна” гэлээ. Эрдэнэт үйлдвэрийн хувьд бүтээгдэхүүний зах зээлийн үнийг судалж байгаа аж. “Эс Эм Контейнер Байг”-ийн үйлдвэрлэсэн шуудай үнийн хувьд янз янз. Учир нь захиалагч талын тавьсан чанар, стандартын шаардлагаас хамаараад өөр өөр үнэлгээтэй байдаг аж. Тухайлбал, шуудайнд зэсийн баяжмал, жонш, төмрийн хүдэр, ган бөмбөлөг гээд ямар эрдэсийн бүтээгдэхүүн савлахаас хамаараад нимгэн зузаан, даац зэргийг нь тусгай аргачлалын дагуу бодоод нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртгийг гаргадаг аж. Одоогоор тус тооцооллын дагуу 1-3.5 тонны даацтай шуудай үйлдвэрлэхэд 15-32 мянган төгрөгийн үнээр зарагддаг юм байна.

## Дахиад л тэд

Монголын талаар ярихын тулд сүүдэр мэт дагадаг сэдэв бол нөгөө л урд хөрш. Энэ удаа ч гэсэн тэдний тухай дурдахгүй өнгөрч болохгүй нь. Ам.доллар чангарахын хажуугаар

“Эс Эм Контейнер Байг” компанийн хамгийн том өрсөлдөгч нь хятадууд болоод байгаа аж. Хятадад бүх төрлийн шуудай үйлдвэрлэдэг. Монголчуудыг бодвол аль хэдийнэ аж үйлдвэржчихсэн. Тийм болохоор үнийн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх өртөг харьцангуй хямдхан байдаг аж. Тиймээс урд хөршийнхөн хямд үнээр Монголын шуудайны зах зээлд ихээхэн байр суурьтай. Гэхдээ тэдэнд сул тал бий. Ерөнхий инженер Б.Одонбаатар “Манай бүтээгдэхүүн чанарын хувьд маш сайн. Гэтэл урдаас оруулж ирсэн шуудай амархан урагдах, цоорох гэх мэт асуудал байнга гардаг. Харин манайх Эрдэнэт, Оюутолгой гээд томоохон үйлдвэртэй хамтран ажиллах хугацаанд нэг ч удаа шуудайны чанарын тухай асуудал яригдаж байгаагүй. Гэхдээ Хятадуудад нэг давуу тал байгаа нь хямд үнэ. Тэд тодооддоо түүхий эдээ хангадаг. Гэхдээ манай импортоор авч байгаа түүхий эдийн үнэ тэднийхээс тийм ч ялгаатай биш. Хамгийн гол нь урд хөршийнхөн ашигласан шуудайг дахин боловсруулаад бүтээгдэхүүний орцонд хольчихдог. Тэгэхээр бүтээгдэхүүний үйлдвэрлэж байгаа өртөг арай хямдхан болно. Гэхдээ нөгөө талдаа бүтээгдэхүүний чанар мууддаг” гэсэн юм. Мөн түүний хэлснээр Оюутолгой компани маш өндөр стандарт тавьдаг. Тэр шаардлагад тэнцсэн бүтээгдэхүүнийг худалдаж авдаг нь манай чанартай бүтээгдэхүүний давуу тал болдог. Тиймээс бид чанараар өрсөлдөж чаддаг юм байна. Гэтэл дотооддын компаниуд хямд үнийг нь бодоод урдаас оруулж ирсэн чанаргүй бүтээгдэхүүн рүү хошуурдаг аж. Зөвхөн шуудай ч гэлтгүй Монголын дотоодын үйлдвэрлэгч нарт Хятадын хямд үнэтэй импортын бараа том тээг саад болдог. Уг нь төр засгаас энэ тал дээр бодлого гаргаад монголчууд өөрсдөө чанартай бүтээгдэхүүн дотооддоо үйлдвэрлэж чадаж байгаа бол гаднаас тухайн бараа бүтээгдэхүүнийг импортоор авахыг хориглох. Дотоодын үйлдвэрлэгч нарыг зах зээлийн үнээр чанартай бүтээгдэхүүн нийлүүлэхийг шаарддаг тийм хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгмөөр. Хэрвээ тэгвэл “Эс Эм Контейнер Байг” компаниас авахуулаад хийж бүтээе гээд яваа нь олон байна. ■

МОНГОЛ БАХАРХАЛ

# “ХҮННҮ КОАЛ”-ЫГ ҮНДЭСЛЭГЧ



“Хүннү Коал” ХХК-ийн үүсгэн байгуулагч, “Wolf Petroleum” компанийн Захирлуудын зөвлөлийн дарга Т.Лхагвадорж

## Д.БЭХЭЭ

“Хүннү коал” нэрийг богино хугацаанд Монголын хөрсөнд нутагшуулж чадсан эрхэм бол Жорж буюу Т.Лхагвадорж юм. Монголчуудын түүхэнд Чингэсээс өмнө бахархам түүх байсныг сурталчлах нөгөө талдаа хариуцлага хүлээх үүднээс энэ нэрийг сонгож компаниа байгуулсан гэдэг. Өнөөдөр “хүннү” нэртэй олон байгууллага, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болжээ. “Хүннү коал” байгуулагдаад таван жил болж байгаа ч уул уурхайн салбарт 10 гаруй төсөл хэрэгжүүлж яваа тэргүүлэх компаниудын нэг болж, шилдэг хайгуулын компани, шилдэг IPO, шилдэг компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч зэрэг олон нэр хүндтэй шагнал авсан бол тус компанийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Т.Лхагвадоржийг 2013 оны “Next stop”-ын шагналтнаар тодруулсан юм.

Улс төр, бизнесийн салбарын оны шилдгийн шилдэг хоёр л эрхмийг жилдээ шалгаруулдаг тус наадам өндөр нэр хүндтэйд тооцогддог. Тус арга хэмжээ нь ажил хийж, ажил нь нийгэмд үнэлэгдэж, улс орны хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг, мөн оруулахаар ажиллаж буй, улс төр, бизнесийн түшээдийг нэр дэвшүүлэх замаар шалгаруулдаг билээ. Тухайлбал, бизнесмэнүүдээс “MCS-ийн Ж.Оджаргал, “Голомт”-ын Д.Баясгалан, “Буян”-гийн Б.Жаргалсайхан, УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, Монголын Бизнесийн зөвлөлийн дарга Б.Бямбасайхан зэрэг улс орондоо баялаг бүтээж яваа компаниудын захирлууд, шилдэг эдийн засагчид уг шагналыг хүртсэн байдаг»

Фотог Э.Зоригт

▶ “Эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулахын төлөө өөрөөс шалтгаалах бүхнээ дайчлан ажиллаж, энэ нэр хүндтэй шагналын үнэ цэнийг гундуулахгүйн төлөө хичээх болно” хэмээн Т.Лхагвадорж “Next stop”-ын индрээс хэлсэн билээ.

## “Эрдэнэт”-ийн диспетчер

Америк нэр нь Жорж, монгол нэр нь Т.Лхагвадорж Улаанбаатар хотын унаган хүүхэд. Түүний бага нас нийслэлийн V хороолол, Цирк орчимд өнгөрсөн бөгөөд 1,31 дүгээр сургуулийг төгссөн. Аравдугаар ангиа төгсөх жилээ “Эрдэнэт” үйлдвэрийн нэрийг сонсоод л мэргэжлээ шууд сонгосон гэдэг. Учир нь Лхагвадоржийн мэргэжил сонгох ээлж ирж, Украинд уул уурхайн баяжуулагчийн сургууль байна. Баяжуулагч хүн “Эрдэнэт” үйлдвэрт ажиллана даа хэмээхэд нь шууд л “за” гэжээ. Ингэж тэрбээр уул уурхайн салбарын хүн болох гараагаа тавьжээ.

Өнөөдрийн дэлхий дахиныг цочроосон үйл явдал өрнөөд буй Украин түүний хувьд оюутан насыг нь үдсэн орон учраас тун дотно санагддаг. “Украинчууд их сайхан хүмүүс байдаг” хэмээн дурсах. Уул уурхайн баялаг ихтэй Укрианд баяжуулагчийн мэргэжил эзэмшсэн залуу “Эрдэнэт” үйлдвэрт ажиллах шийд сонсоод ихэд баярласан нь мэдээж. Хамтарсан хөрөнгө оруулалттай том үйлдвэрт дадлага хийхээр ирсэн анхны өдөр түүнд баяжуулахын машин доогуур ажиллах үүрэг өгчээ. Машинаа угаана, цэвэрлэнэ, арчина, ядарна, хөлс гоожно. Энэ завсраа сургуульд үзсэн онолыг практикт нэвтрүүлж, баяжуулахын машины эд анги, системийг бүрэн мэдэж авч гартаа орууллаа. Гадаадад төгссөн ганган залуу баяжуулахын машин дороос халтар нүүрэлж гарч ирдэг байсан тухай тэр дурсах.

1990-1996 он, Монгол Улсын хувьд зах зээлд шилжсэн ид хямралын үе. Лангуун дээр давснаас өөр зүйлгүй байсан он цагууд. Цахилгаан, дулаан, ус тасарна. Хотоороо, аймгаараа, улсаараа харанхуйд автдаг жилүүд. Ийм хүнд үед үйлдвэрийн диспетчер хийж, ажил хөдөлмөрийн амт шимт, алдаа оноо, хариуцлага, ёс зүйг жинхэнэ утгаар нь мэдэрсэн бөгөөд

ирээдүйн их үйлсийг бүтээх сайн гараа болж өгсөн нь ойлгомжтой.

Баяжуулагчаас баяжуулах үйлдвэрийн диспетчер, төд удалгүй уулын баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь хариуцсан диспетчерийн албанд очив. Хийх ажил их, хариуцлагатай ч алба. “Шөнийн захирал” нэртэй. Уурхайгаас авахуулаад төмөр зам, хүртэлх үйлдвэрийн үйл ажиллагааны бүх шат дамжлага, шөнийн үйл явцыг хянаж, мэдэж байх ёстой. Үүнээс гадна Эрдэнэт хотын эрчим хүчний байдал, Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн ажил, хойд хөршөөс авсан цахилгааны хэмжээ, Замын-Үүдэд хэдэн тонн ачаа хуримтлагдсан зэрэг мэдээллийг авч анализ хийгээд өглөөний 06.40-д үйлдвэрийн бүх захирлын гэрт утсаар холбогдож, рапорт өгнө. Хамгийн сүүлд цаг агаар ямар байгааг хэлэх ёстой. Шөнөжин ажилласан дарга нар нүдний хор гаргахаар гэр рүүгээ явдаг ч өглөө утсаа авч диспетчерийн мэдээлэл сонсоод 07.15 гэхэд ажил дээрээ ирээд л хуралд орно.

“Үйлдвэрийн захирал Ш.Отгонбилэг орос хэлээр албан бичиг төлөвлөөд ороход улаан эрэн болтол засдаг, орос хэлийг гайхалтай эзэмшсэн, шударга, шулуун зантай, ажлаа сайн мэддэг, худал хэлэхийг анддаггүй, дэлхийн хаана ч явсан ажлаа асуудаг удирдлага байсан. “Эрдэнэт” сөгдвөл улс даяараа сүйрэх учраас үйлдвэрийн бүх ажилтан эрвийх дэрвийхээрээ хичээн нойр, хоолгүй, маш зохион байгуулалттай, замбараатай, цэргийн дэглэмтэй ажилладаг байлаа. Хүний үгийг сонсож, ажилд хариуцлагатай хандаж, хамтач байх, багаар ажиллах гээд олон зүйлд суралцсан” хэмээн Т.Лхагвадорж ярьсан юм.

## “Эрдэнэт”-ээс Америк руу

Диспетчерт маань их гүрэн рүү явах аз тохиожээ. 90-ээд онд гадагш тэр дундаа Америк руу сургуульд явна гэдэг бол аавын хүүгийн санасан мөрөөдсөн болгоны бүтдэг ажил биш байв. Ардчилсан систем рүү шилжсэн эхний он жилүүдэд ах нартаа муудсан монголчууд оросуудыг хөөн гаргах ажиллагааг эрчимтэй явуулж байлаа. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрт ч энэ процесс үргэлжилж, техник технологио баруунжуулах асуудал

яригдаж, ирээдүйтэй мэргэжилтэн боловсон хүчнээ ч барууны өндөр хөгжилтэй оронд сургах тухай яриа газар авснаар “Эрдэнэт”-ийн диспетчер АНУ-ын уул уурхайн ууган, шилдэг сургуульд суралцахаар болжээ.

Колорадигийн уул уурхайн их сургууль 3000 оюутантай, оюутнаа шилж, шалгаруулж авдаг, Монголтой төстэй уулын бэлд оршдог том сургууль. Үйлдвэрийн зардлаар сурч буй тул төгсөөд “Эрдэнэт”-д ажиллах гэрээтэй. Мань хүн ч сайн сурч, үйлдвэртээ ажиллах хүсэл эрмэлзэл дүүрэн байлаа. Гэтэл түүнийг суралцах хугацаанд үйлдвэрийн удирдлага солигдсоноор тэтгэлгийг зогсоосон нь хүнд цохилт болов. “Ш.Отгонбилэг даргын хамаатан садан биш дээ” гэсэн бодол тухайн үед төрсөн гэдэг. Харин турк багшийнхаа тусалцаатайгаар мастерийн зэргээ сургуулийнхаа зардлаар хамгаалжээ. Нийтдээ долоон жил Америкт сурсан уул уурхайн мэргэжилтнийг урьж ажиллуулах санал олноор ирдэг байсан гэнэ. Лхагвадоржийн хувьд хуучин ажилдаа очих сонирхол их байсан, санаагаа ч тухайн үеийн удирдлагад хэлээд үр дүнд хүрээгүй тул жилийн 60 мянган ам.долларын цалинтай Америкийн уул уурхайн компанид ажиллахаар гэрээ үзэглэв. Гэтэл “Монголросцветмет” нэгдлийн захирал Х.Бадамсүрэн компанидаа ажиллах санал тавихад нь эргэлзэлгүй зөвшөөрч, эх орондоо ирээд сарын 300 мянган төгрөгийн цалинтай ажилд орлоо.

“АНУ-д өндөр цалинтай хангалуун сайхан амьдарч болно. Гэхдээ мэргэжлийн хувьд сэтгэл хангалуун байж чадахгүй. Монгол инженер их гүрэнд ямар түвшинд хүрч ажиллах уу. Олон жил сурсныхаа үр дүнг Монголдоо очиж гаргая. Монголд ч уул уурхайг хөгжүүлэх тухай нэлээд ярьж эхэлж байсан үе. Тэгээд л эх орноо сонгосон доо” хэмээн яриу.

2004 онд ирээд “Монголросцветмет” нэгдлийн Хөгжил, хэтийн төлөвийн газрын ахлах мэргэжилтэн, Хэтийн төлөв хариуцсан орлогчоор ажиллав. Тус нэгдлээс Асгатын мөнгөний орд, Баргилтын төмрийн ордыг хөгжүүлэх том төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байсан үе. ▶

▶ Бадамсүрэн захирлын зүгээс их итгэл үзүүлсэн ч хоёр жил орчим ажиллаад Хэтийн төлөв хариуцсан орлогч захирлын орон тоог цомхтгосноор Лхагвадорж ажилгүйчүүдийн эгнээнд шилжжээ. Төрийн компанид ажилласнаар шийдвэр удаан гардаг, хүнд суртал ихтэй, оросуудын үгийг сонсох, зөвшилцөх хэрэгтэй болдог зэрэг олон асуудал байдгийг тэрбээр удирдах түвшинд ажилласнаар мэдэж, мэдэрсэн учраас хувийн хэвшлийг сонирхож эхэлсэн юм.

Цомхтголд орсон нь азтай хэрэг болсон тухай тэр сүүлд ярьсан байдаг. Үүний дараа нэг найзынхаа саналаар Япон, Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай “Юнигаз” компанийн гүйцэтгэх захирлын албыг нэг жил хашигдаа шингэрүүлсэн хий импортлох ажлыг эрчимжүүлж, агуулахыг нь ашиглалтад оруулжээ. Япончуудын нямбай, асуудалд долоо хэмжиж нэг огтолж ханддаг чанар Америкт эзэмшсэн сэтгэлгээ хоёр зөрчилдсөнөөр “Юнигаз” компанийг орхиод хүргэжээ.

Америкчуудын хувьд тухайн бизнесийг тооцоолж үзээд, ашигтай бол шууд л шийдвэрээ гаргаад орж, үр дүнг гаргахын төлөө зүтгэдэг зантай. Ийм сэтгэлгээтэй улсад долоон жил сурсан хүн япончуудын шийдвэр гаргах удаан процессыг тэсвэртэй хүлээж чадах уу. Тэгэхээр бизнест сэтгэлгээний ойлголцол асар чухал, хаанахын хэнтэй, ямар соёл заншилтайг нь сайн судалж, ойлгож байж бизнесийн түншээ сонгохын ач холбогдлыг дээрх жишээ харуулна.

## Жорж ба “Энержи ресурс”

Шилдэг менежерүүд шилдэг л байдаг. Тэд өөрсдийгөө хаана байхыг мэдэж, өөрсдийгөө үнэлж чаддаг. Монгол Улсын бахархал болсон уулын баяжуулах үйлдвэрт ажиллаж, гадаад, дотоодын удирдлагын чанга хатуу гараар хүмүүжиж, ажил амьдралын зовлон бэрхшээлийг амсаж, улмаар барууны өндөр хөгжилтэй оронд олон жил сурсан, бас туршлагажиж яваа менежер өөрийгөө үнэлж чадна. “Юнигаз”-аас гарсныхаа дараа Жорж Монголын баялаг бүтээгчдийг тэргүүлдэг “Эм Си Эс”-ийн мэдэлд очив. Ж.Оджаргал захирлын хувьд “Энержи ресурс” компанийг байгуулан

Тавантолгойн орд төсөл дээр монгол түншүүдтэйгээ хамтран эрчтэй ажиллаж байсан үе. “Энержи ресурс”-ын гүйцэтгэх захирал Т.Лхагвадорж Тавантолгойг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах их ажлыг хариуцаж, ТЭЗҮ-г бэлэн болгоод байх үед төр хувийн хэвшлийнхнээс илүү хурдтай, илүү ашигтай сайн ажиллуулна хэмээн Ухаа худагийн ордыг “Энержи ресурс”-т үлдээж, бусад толгойг өөрийн мэдэлдээ авах шийдвэр гаргасан юм.

Ийн Монголын бахархал болоод буй нүүрсний компанийн ажлыг нугалах гараан дээр гурван жил ажиллаад, Жорж захирлын албаа хүлээлгэн өгөх шийдвэр олон хүнийг гайхшруулсан байна. Түүний хувьд ажлаас гарах шийдвэр үнэхээрийн хүнд, олон хоног бодож, нойргүй хоносон гэдэг. Тавантолгойн мастер төлөвлөгөө дээр ажиллаж эхлэхэд түүний удирдлага дор таван хүн байсан бол ажлаас гарахад нь 1000 орчим хүнтэй болсон байв. Тэрбээр Ж.Оджаргал захиралтай баг болж, Монголын хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц бүтээн байгуулалт өрнүүлж яваа компанид ажиллаж байснаараа ихэд бахархдаг.

## Жорж ба Матью Вүүд

Дэлхий Монголыг сонирхож, ялангуяа уул уурхайн салбарыг илүүд үзэж, гадаадын хөрөнгө оруулагчид манай орон руу хошуурч эхэлсэн тэр жил Матью Вүүд Жоржтой танилцжээ. Геологич мэргэжилтэй бизнесмэн 2009 онд анхлан Монголд ирж, Өмнийн говиор долоо хоног явж, уул уурхайг судалсны дараагаар Т.Лхагвадоржид хамтран ажиллах санал тавьснаар “Хүннү коал” компани байгуулагдсан түүхтэй.

Жоржийн тодорхойлсноор австраличуудын хувьд алив зүйлд шударга шулуухан ханддаг, за гэвэл ёогүй хүмүүс. Ойлголцож ажиллахад их амар, далд санаа байхгүй, асуудлыг уулзаж, нүүр нүүрээ харж ярих сонирхолтой. Цаг зарцуулж хүмүүстэй уулзаж, өөрсдийгөө таниулдаг, хамтраад явбал үр дүнг нь харахын төлөө тууштай зүтгэдэг хүмүүс гэнэ.

“Хүннү коал” өнөөдөр Өмнөговьд хайгуулын, уурхай байгуулах хоёр төсөл дээр ажиллаж байна. Мөн

Монголын эрдэс баялгийн зөвлөл Говь-Алтай аймгийн Төгрөг сум дахь Хүрэн голын төслийн нөөцийг нь 250 сая тонноор хэмээн баталж, Монголын нүүрсний нөөцийг нэмэгдүүлжээ байна. Өмнө нь “Рио Тинто” компани Хүрэн голын төслийг хэрэгжүүлж байсан бөгөөд ийм хэмжээний нөөцтэйг тогтоож чадаагүй аж. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжүүлж буй Үнст худагийн нөөцийг ойролцоогоор 700 сая тонноор тогтоочихсон явж байна. Азийн нүүрсний зах зээл дэх тэргүүлэгч компанийн нэг, “Азийн энергийн нүүр царай” гэгддэг Тайландын Банпу “Хүннү коал”-ын хувьцааг худалдан авснаар Монголд орж ирсэн билээ.

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хүннү коал” анхныхаа IPO-г 2010 оны хоёрдугаар сарын 9-нд Австралийн хөрөнгийн биржид гаргаж, эхний өдрөө л 20 сая ам.долларыг босгосон бөгөөд “Хүннү”-гийн хувьцаа тэр жилдээ Австралийн хөрөнгийн биржийн шилдэг IPO-гоор шалгарч байв. Хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулах нь маш эрсдэлтэй бизнес. Хайгуулаа зөв хийгээд нөөцийг тогтоосны дараа эдийн засгийн эргэлтэд оруулах хэмжээний санхүүжилт гаргах чадвартай хүмүүстэй хамтарч ажиллах нь хамгаас чухал тухай Т.Лхагвадорж зөвлөж байна.

Их амжилтыг хар, цагаан хэл ам үргэлж дагаж явдаг. Гагцхүү тэрхүү саад бэрхшээлийг хэрхэн даван туулахаас амжилт бүтээл шалтгаалдаг гэдэг. Ер нь монголчуудын маань амжилттай яваа нэгнээ дэмжиж, илүү амжилт гаргахын төлөө хичээхийн оронд хараар будаж, доош унагахыг оролддог зан “Хүннү Коал”-ын захирлыг тойрч гарсангүй. Түүнийг гаднынхантай нийлж, Үнст худагийн ордыг зарж худалдсан, тус ордын тусгай зөвшөөрөл барьцаалж, Австралийн бирж дээр мөнгө босгосон мэтээр ярьж, сонин хэвлэлээр захиалгаар олонтаа бичүүлж, Арбитрийн шүүхэд ханджээ.

Бодит байдал дээр асуудал эсрэгээрээ өөрөөр хэлбэл, Үнст худагийн ордын зараагүй бөгөөд тусгай зөвшөөрөл ашиглаж гадны бирж дээр мөнгө босгох ойлголт ▶

► байдаггүй тухай Т.Лхагвадорж захирал хатуухан хариу өгсөн. Өөрсдийн боломжоо буруугаар ашиглаж, ахиухан мөнгө олох гол зорилготой хүмүүс Арбитрт хандсан нэхэмжлэлээ өөрсдөө татаж авч асуудлыг дуусгасан ч сонин хэвлэлээр түүний нэр хүндэд халдсаар байгаад “Хүннү коал”-ыг үндэслэгч гайхаж байгаагаа хэлсэн юм.

## Газрын тос хайх эрэлд

Т.Лхагвадорж захирал өнөөдөр “Хүннү коал” компанийнхаа зөвлөхөөр ажиллаад газрын тосны хайгуулын

тосоо олж илрүүлэхгүй бол мөнгө газарт булагдаж, эрсдэл үүрнэ гэсэн үг. Олж чадвал бизнесийн ч, улс орны ч хөгжилд хэрэгтэй. Газрын тосоо дотоодоосоо хангадаг болмоор байна” хэмээн тэр ярих.

Монголын төр алдаагаа хэдийгээр засаж залруулсан ч хөрөнгө оруулагчид цаашдын үйл явцыг анхааралтай ажиглаж буй. Хуулиа залруулангуут хөрөнгө оруулагчид бөөн бөөнөөрөө ороод ирэхгүй нь ойлгомжтой. Лхагвадорж захирлын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй засгийн ааш араншин, эрх

хөлд оруулаад ирэнгүүт “та нар хөлд ороод даврах нь уу” гээд л унагаад авдаг сэтгэлгээ Монгол орныг хөгжүүлэхгүй байна. Мөн уул уурхай мөнгөөр харах бус цаад дагадалдах олон зүйлийг хамтад нь авч үзэх хэрэгтэй. Уурхайд үйлчилж буй үйлчилгээний салбар маш чухал. Уул уурхай зогсохоор үйлчилгээний салбар ч унаж байгааг бид харж байна хэмээн ярих Лхагвадорж захирлын удирдлагын зарчим нь хүнд итгэл үзүүлэх. Уул уурхайд эрчүүд түлхүү ажилладаг. Улирлын чанартай хатуу хүтүү ажил



Т.Лхагвадорж захирал өнөөдөр “Хүннү коал” компанийнхаа зөвлөхөөр ажиллахын сацуу газрын тосны хайгуулын бизнес рүү ханцуй шамлан оржээ.

бизнес рүү ханцуй шамлан оржээ. Түүний удирдаж буй “Wolf petroleum” компани байгуулагдаад гурван жил болж буй ч гурван жилд хийх ажлыг 18 сарын дотор хийж гүйцэтгэсэн амжилтаараа Газрын тосны газраас шалгаруулдаг шилдэг хайгуулын компаниар жил дараалан тодорчээ. Тэднийх гурван талбайд хайгуул хийж буй бөгөөд гол үйл ажиллагаа нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар 27 Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд явагдаж байна. 450 км-ийн урт зайд чичирхийллийн судалгаа хийгээд 100 км урт, 40 км-ийн өргөнтэй газрын тос байж болох бассейн илрүүлжээ. Нөгөө хоёр нь засагтай хамтарсан хайгуулын талбай аж. “Газрын тосны салбар Монголд бага судлагдсан. Их хөрөнгө шаардагддаг бизнес. Хайгуул хийгээд

зүйн өөрчлөлтийг яс махаараа мэдэрч буй нэгэн. Хөрөнгө оруулагчдыг эх орондоо ирэхийг уриална. Ирэхээр нь хөөгөөд явуулна. Тэгснээ эргээд ороод ирээчээ гээд гуйдаг тогтолцоог халж, зөвхөн хуулийн орчинд бус том цогц өөрчлөлт хэрэгтэй байна. Монгол хүн, бизнесмэнүүд ч сэтгэлгээгээ өөрчилмөөр байна. Ажилсаг, туйлбартай, итгэлтэй зан хэрэгтэй. Хамтын түнш, хамт унаж, босдог, олон зангүй байх, замын дундаас буцдаггүй зэрэг чанар хөрөнгө оруулагчдад төдийгүй бизнест маш чухал гэдгийг “Хүннү Коал”-ын зөвлөх онцлон тэмдэглэлээ.

Төрийн бодлого тодорхой, тогтвортой байхын чухлыг бизнесмэнүүд байнга л сануулдаг. Бизнесийг дэмжинээ л гэдэг. Өөрсдийн хүчээр бизнесээ

тул хүмүүст итгэл үзүүлэх, тэвчээр хамгийн чухал. Үр дүнг нь зөв хянаж чаддаг, хүнээ зөв ажиллуулж, багаар ажиллах чадварыг тэр баримталдаг. Одоогийн залуусын амар хялбар аргаар мөнгө олж, дарга захирал болох сэтгэлгээг тэрбээр шүүмжлээд томоохон компанид дунд зэргийн менежерийг гурван жил хийснээ туршлагатайд тооцож, тусдаа компани байгуулаад дарга болох тухай бодох нь тийм ч зөв бодол биш ээ. Дарга болох амархан, хариуцлага өндөр тухайд “Хүннү коал”-ыг үндэслэгч туршлагаасаа хуваалцлаа.

Уул уурхайн салбарын мэргэжлийн мэдлэг, мэдрэмжээр бизнесийн салбарт хүч үзэн өөрийн эрхээр зүтгэж яваа Жорж захирал залуу хүний эрч хүчээр урагш тэмүүлэн ажилласаар. ■

## ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨРТ

## УС БА ХӨГЖИЛ

Ж.ДАЛАЙ

/Усны үндэсний төвийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер, доктор/

**Манай орны усны нөөцийн хуваарилалт ба хэрэглээ**

Ус бол хэрэглээний үл орлуулагдах шинж чанарыг өөртөө агуулан, үйлдвэрлэлийн болон эдийн засаг, экологийн чадавхийг илтгэдэг байгалийн онцгой баялаг юм. Энэ утгаараа ус нь хөгжлийг тодорхойлох гол хүчин зүйл билээ. Тиймээс ч НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 58 дахь удаагийн хуралдаанаас 2005-2015 оныг “Ус бол амьдралын эх булаг” олон улсын арван жил болгон зарлан тунхаглаж, “Ус нь ядуурал болоод өлсгөлөнг арилгах, тогтвортой хөгжлийг хангах хөдөлгөгч хүч” гэж цохон тэмдэглэсэн байдаг. Харин 68 дахь удаагийн чуулган дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж усны асуудлаарх хамтын ажиллагааны дэлхийн байгууллага бий болгохоор санал дэвшүүлсэн билээ.

Монгол орны хувьд цөлөрхөг улс орнуудыг бодвол усны нөөцөөр

харьцангуй боломжийн байж болох орон. Өөрөөр хэлбэл, хурмастаас чамлаад байхааргүй хэмжээний усыг бидэнд илгээдэг. Гэвч усны ихэнх нөөц умард болон зүүн зүгт Хойд мөсөн далай, Номхон далайн ай сав газар тийш хором бүр гадагшилдаг онцлогтой. Алт, зэс зэрэг газрын баялгаас ч илүү үнэтэй баялаг маань ийнхүү бидний нутгаас секунд, минут тутамд тасралтгүй урсан гарсаар байна гэсэн үг. Нөгөөтэйгүүр, монгол орны өмнөд хагаст хур тунадас маш бага унадгаас цөлжилт хурдацтай явагдаж байна. Гэтэл манайд ус ихээр хэрэглэдэг уул уурхай, эрчим хүч, хүнд үйлдвэрийн томоохон бүтээн байгуулалтууд гол төлөв ус багатай, цөлжилт ихтэй говийн бүсэд эхэлчихсэн. Энэ бүх үйлдвэрийн усны хэрэгцээг хангахын тулд говийн газрын доорх уснаас их хэмжээгээр авбал нөөц нь хомсдох, давсжих, цөлжилтөд түлхэц өгөх зэрэг хор уршиг бий болох магадлал өндөр юм.

Энэ байдлыг урьдчилан мэдэрсэн дэлхийн олон улс орон гадаргын усыг аль болох олон салбарт зүй зохистой ашиглах чиглэлд бодлого боловсруулан хөгжиж байна. Манай улс ч энэ чиглэлд бодлогоо

тодорхойлж, “Усны шинэтгэл, XXI” хөтөлбөрийг Засгийн газраас 2004 онд баталсан юм. Энэхүү хөтөлбөрөөр газрын доорх болон гадаргын усны нөөцийн хэрэглээний харьцааг 2010 онд 65:35, 2015 онд 55:45, 2025 онд 50:50 болгох зорилт тавьсан билээ. Тухайн зорилтыг тавих үед дээрх харьцаа 80:20 байсан бөгөөд өнөөдөр газрын доорх болон гадаргын ус хэрэглээний харьцаа харин ч эсрэгээр 90:10 болсон. Өөрөөр хэлбэл хөтөлбөр хэрэгжээгүй гэсэн үг.

Бид ус хэрэглээний сэтгэлгээгээ өөрчлөхгүй бол богино хугацаанд хязгаарлагдмал нөөцөө цөлмөөд дуусгах аюултай байдалд ороод байна. Зам даган хөгжил ирэх нь ойлгомжтой ч хөгжлийн үндэс нь ус гэдгийг монголчууд бид нэг л сайн ойлгож өгөхгүй байх шиг. Усны асуудлаа нэгдүгээрт тавьж шийдсэний дараа дэд бүтэц, бүтээн байгуулалтын бусад ажлуудаа усны нөөцийн боломжтойгоо уялдуулан төлөвлөж байх нь манай орны онцлог байх ёстой. Ер нь манай улсын хувьд зам, цахилгааны асуудлыг ямар ч хэлбэрээр шийдэж болно. Зөвхөн санхүүгийн асуудлыг нь шийдвэрлэхэд л бүтчихнэ. Харин усны асуудлыг ▶



▶ ямар ч их мөнгө байгаад шийдэхэд хүндрэлтэй байгаа нь бас л манай орны өвөрмөц онцлогтой холбоотой.

## Ус ба эдийн засгийн өсөлтийн талаар

Усыг нэг зорилгоор бус олон зориулалтаар ашиглаж, усны нэг системийг олон үүрэгтэйгээр ашигласнаар уснаас хүртэх үр ашиг улам бүр нэмэгдэнэ. Тухайлбал, эрдэмтэд өдөрт нэг хүнд 100 л ус өгөх үнд ахуйн ус хангамжийн системийг сайжруулж, олон зориулалтаар ашиглаж эхэлбэл нэг хүнд ноогдох ДНБ жилд 40-80 ам.доллараар нэмэгдэх боломжтой гэж тооцсон байна.

Дэлхийн буурай хөгжилтэй орнуудад ус хангамж тааруу байдаг бөгөөд тэр тусмаа амьжиргаа нь усны нөөцөөс хамааралтай байдаг. Улс орны усны хүртээмж ямар байгаагаар тухайн орны хөгжлийн түвшин болон баялгийн хуваарилалт ямар байгааг тольдож болдог ба ядуурал нэмэгдэх тусам усны асуудал төрөөс хамааралтай болж, төрийн ачаалал улам бүр нэмэгддэг байна.

Усны менежмент нь эдийн засгийн өсөлт, эсвэл хүний хөгжил, наад захын үйлчилгээний аль алинд нь хамааралтай асуудал юм. Нэгэн цагт дэлхийн эдийн засаг хөдөө аж ахуйд суурилж байсан бол өдгөө, аж үйлдвэрлэл, өндөр технологи дээр тогтох болсноор усны салбарын хөгжил ч энэ чиглэлийг даган хөгжиж буй. Тухайлбал, 1960-аад оны БНСУ дахь аж үйлдвэрлэлийн үсрэнгүй хөгжлийн өмнө хэдэн арван жил үргэлжилсэн хөдөө аж ахуйн өсөлт явагджээ. Үүний дараагаар 1990-2003 онд эдийн засгийн тогтвортой өсөлтийн үед Ази тивд аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, ус хуримтлуулалт, ус хангамж, бохир ус цэвэрлэх үйл ажиллагааг эрчимтэй явуулсан байдаг юм.

Манай улс ч мөн адил энэ замаар хөгжиж эхлэх ёстой. Сүүлийн 20-иод жилд ус дутагдалтай говь, тал хээрийн бүсэд усыг ихээр ашиглагч уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжих болж, усыг эдийн засгийн өсөлтийн тулгуур хүчин зүйл гэж харж, ойлгож эхэлж байна.

## Усны салбарын уналт

Монгол оронд өнгөрсөн 20 гаруй жилд зам, харилцаа холбоо, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбар маш их өөрчлөгдөн хөгжсөний дээр уул уурхайн салбарын үсрэнгүй хөгжлийн эхлэлийн жилүүд байлаа. Гэтэл дээрх салбаруудын хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй усны салбар “Усны аж ахуйн яам”-ыг харъяа Усны институт болон 19 удирдах газруудынх нь хамт татан буулгаснаас хойш 2005 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар” байгуулагдах хүртэл бүрэн уналтын байдалтай



Усны менежмент нь эдийн засгийн өсөлт, эсвэл хүний хөгжил, наад захын үйлчилгээний аль алинд нь хамааралтай асуудал юм. Нэгэн цагт дэлхийн эдийн засаг хөдөө аж ахуйд суурилж байсан бол өдгөө, аж үйлдвэрлэл, өндөр технологи дээр тогтох болсноор усны салбарын хөгжил ч энэ чиглэлийг даган хөгжиж буй.



байсан. Одоогийн байдлаар “Усны газар”-ыг татан буулгаж, усны нөөцийн асуудлыг БОНХЯ-нд, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус хангамжийг ҮХААЯ-нд, уул уурхай, эрчим хүчний ус хангамжийг УУЯ болон ЭХЯ-нд, хотуудын ус хангамжийг БХБЯ-нд тус тус хариуцуулсан бөгөөд усны асуудлаарх салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий Усны үндэсний хороо байгуулагдаад удаагүй байна. Энэ нь сайшаалтай ч тус хорооны үйл ажиллагаа салбар дундын зохицуулалт хийхэд хүндрэлтэй байгаа нь усны салбар олон яамтай ч юм шиг, огт эзэнгүй ч юм шиг болж хувирсантай холбоотой байна. Мөн усны нөөцийн менежмент

хийх, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий “Монгол ус” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг 2012 онд байгуулсан ч төсөв мөнгөгүй, ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхой бус байдалтай байна.

## Усны бодлого

Улс орны тогтвортой хөгжлийг хангах үзэл баримтлалын тулгуур хүчин зүйлийн нэг нь байгалийн нөөц, түүний зохистой хэрэглээний асуудал бөгөөд тэр дундаа усны цогц бодлого түүний менежмент голлох үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь тодорхой нутаг дэвсгэрийг хөгжүүлэх эдийн засгийн бодлогыг боловсруулж төлөвлөхөд усны нөөцийн судалгаа, хуваарилалт, менежментийн оновчтой зөв хувилбарыг эхний ээлжинд төлөвлөж, боловсруулах нь ихээхэн ач холбогдолтой болохыг илтгэж байгаа юм. Ялангуяа усны нөөц нутаг дэвсгэрийн хувьд жигд бус тархсантай холбоотойгоор нийгмийн амьдрал, үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж тэр хэмжээгээр хязгаарлагдмал байдаг. Мөн бараг бүх аймаг, сумын төв, суурин газрын ус хангамжийн эх үүсвэр нь хэдэн зуун жилд нөхөн сэргээгдэх газрын доорх усаар хангагддаг тул тэдгээрийн нөөцийг тогтоож, ашиглалтын горимыг тодорхойлон мөрдөх хойшлуулшгүй шаардлага тулгараад байгаа билээ. Иймд манай улсад усны нөөцийн хуваарилалтыг зөв бодлогоор зохицуулж байж тогтвортой хөгжих үндэс тавигдана. Өөрөөр хэлбэл аливаа улс орны усны нөөц ховор байгаадаа бус буруу менежмент, буруу бодлоготой холбоотойгоор л хомсддог. Иймээс гадаргын усаа экологи, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зоригтойгоор хурдхан хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Манай улс хөгжихийн хэрээр усны хэрэгцээ цаашдаа 20-30 дахин нэмэгдэх тойм тооцоо байдаг. Тиймээс усны хэрэглээ дагасан менежментийг одооноос хэрэгжүүлж эхлэх нь усны бодлогын чухал хүчин зүйл юм. ■

Үргэлжлэл бий